

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ISSN: 2313-6170
Key title: Orčuulgazuj

ОРЧУУЛГАЗҮЙ

V

(Монголын үе үеийн орчуулагчдын бүтээл, туурвил)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар
2016

DDC
418.02'015
О-497

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
КҮНЗИЙН ИНСТИТУТ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ
№05

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:
Нарийн бичгийн дарга:
Гишүүд:

М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)
Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)
Э.Равдан (ШУ-ны доктор, профессор)
Го.Аким (доктор, профессор)
С.Эрдэнэмаам (доктор, профессор)
Л.Чулуунбаатар (доктор, профессор)
Г.Буяннэмэх (доктор, профессор)
О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч)
Ш.Эгшиг (доктор, дэд профессор)
К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор)
Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор)
В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор)
Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор)
Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн
Монгол судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч:
Хянан засварласан:
Хуудасны хэмжээ:
Хэвлэлийн хуудас:
Хэвлэсэн тоо:
Хэвлэлийн газар:

МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессоруудын хамтлаг
Г.Элдэв-Очир
А4
33.5 хх
150ш
“Удам соёл” ХХК

ISBN 978-99973-7324-3

**NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
INSTITUTE OF CONFUCIUS**

ISSN: 2313-6170
Key title: Orčuulgazuj

TRANSLATION STUDIES

V

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar
2016

DDC
418.02'015
O-497

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
INSTITUTE OF CONFUCIUS

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES
№05

Editor: Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)
Secretary: Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)
Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)
Akim.G (Ph.D, Professor, Mongolia)
Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)
Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)
Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)
Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)
Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)
Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)
Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)
Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)
Marie-Dominique Even (French National Center for
Scientific Research, France)
Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking
University, P.R.China)

Founder: Professors Team for Translation Studies, Division of Humanities,
School of Arts and Science, National University of Mongolia
Edited by: Eldev-Ochir.G
Paper size: A4
Number of pages: 33.5
Number of prints: 150
Press: “Udam soyol” printing company

ISBN 978-99973-7324-3

ГАРЧИГ

Өмнөтгөл үг

ОЛОН ХЭЛНИЙ ОРЧУУЛГЫН ТОЙМ

А.Өлзийнаран, Н.Оюунзаяа	Америкийн уран зохиолыг Монгол хэлээр орчуулсан үе үеийн орчуулагчдын бүтээл туурвилын тойм	17
Ж.Ариун	Герман-Монгол, Монгол-Герман орчуулгын бүтээлийн тойм	25
Б.Пүрэвсүрэн	Испани хэлт зохиолчдын бүтээлийг Монгол хэлнээ орчуулсан туршлагаас	39
Г. Бат-Учрал	Итали зохиолчдын зарим бүтээлийн Монгол орчуулгын тухайд	42
Н.Оюунзаяа, А.Өлзийнаран	Монгол уран зохиолыг Англи хэлнээ орчуулсан нь	45
Д.Бүрнээ	Монголчуудын Төвд хэлнээс орчуулсан зохиолын тойм	52
Б.Алтангүл	Монгол хэлнээ орчуулсан Франц зохиол, бүтээл	65
Д.Энхжаргал	Оросоос бусад Слав хэлтэн улсуудын уран зохиол Монголд	72
Г. Эрдэнэчимэг	Солонгос утга зохиолын Монгол орчуулгын тойм	93
Г. Буяннэмэх	Франц хэлээр орчуулсан Монголын уран зохиолын тухайд	110
Ш. Эгшиг	Хятад-Монгол орчуулгын түүхэн хандлага	122
С.Долгор, Ц.Онон	Японы уран зохиолыг Монгол хэлнээ орчуулсан тойм /2007-2016/	143

ОРЧУУЛАГЧДЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

А.Сүхмаа	Судлаач, орчуулагч Шөгөө овогт Ойдовын Адъяагийн намтар, туурвил, орчуулгын онцлог	157
Б.Соёлсүрэн	Нэрт гүүш Б.Банзрагчийг дурсан бичихэд...	162
Б.Энхбаяр	Орчуулагч Артын Бямбаноровын бүтээлийн тухайд	167
Д.Отгонтуяа, Б.Нямжав	Орчуулагч Н.Доржготов ба Монголын нууц товчоо	177

А.Цэрэнчулуун	Чой.Лувсанжав, Г.Лувсан нар “Герман хэл өөрөө сурах бичиг”-тээ Герман, Монгол хэвшмэл хэллэгийг хэрхэн дүйцүүлсэн нь	185
---------------	--	-----

УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Ц.Отгонсүрэн, С.Уранбаясгалан	Уран зохиолын орчуулга дах хэлзүйн хураах үзэгдэл	199
Б.Удвал	Уран зохиолын бичвэр дэх коннотатив, перифраз утга, түүнийг орчуулах нь	209
Б.Хөгжилт	Хятад-Монгол орчуулгад Өвөр Монгол орчуулагчид тавигдах үндсэн шаардлагын тухай	215
Ц. Оюунгэрэл	“Чүнхянг бүсгүйн домог” зохиолын орчуулгын хэл найруулгын тухайд	220

ХАВСРАЛТ

Б.Гэрэлт-Ирээдүй	Мо Еэнь “Чоно” өгүүллэгийн орчуулга	229
М.Амартайван	Орчуулгын тухай бүтээлийн номзүй	230

Өмнөтгөл үг

ДЭД ПРОФЕССОР, ДОКТОР ГЭНДЭНГИЙН ЛУВСАН

Гэндэнгийн Лувсан нь Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг “Их гол” хэмээх газар 1948 онд төржээ. Зүүнхангай сумын бага сургууль, Баруунтурууны 10 жилийн дунд сургууль төгсөөд, 1965-1970 онд МУИС-ийн ХБФ-ийн монгол хэл, уран зохиолын ангид суралцаж, уран зохиол, монгол хэлний багш мэргэжлээр төгссөн байна.

1980 онд “Герман хэлний угтлагыг монгол хэлний дагавар үгтэй харьцуулсан судалгаа” хэмээх нэг сэдэвт бүтээл бичиж БНАГУ-ын Берлин хотын Хумбольдтын нэрэмжит Их сургуульд докторын (Ph.D) зэрэг хамгаалжээ. 1994 онд МУ-ын эрмдийн зэрэг олгох дээд зөвлөлөөс дэд профессор цол олгожээ.

Г.Лувсан 1970-1975 онд МУИС-д багш, 1975-1980 онд Берлин хотын Хумбольдтын нэрэмжит Их сургуульд монгол хэлний багш, тользүйч, 1980-1988 онд МУИС-д багш, тэнхимийн орлогч эрхлэгч, тэнхимийн эрхлэгч, 1988-1993 онд Берлин хотын Хумбольдтын нэрэмжит Их сургуульд багш, эрдэм шинжилгээний ажилтан, 1993 оноос МУИС-д тэнхимийн эрхлэгч, профессор багшаар ажиллаж ирсэн байна. Дэд профессор, дэд доктор Г.Лувсан нь МУИС-ийн ГХСС-ийн Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хүмүүнлэгийн Их сургуулийн дэргэдэх хэлшинжлэлийн ухаанаар докторын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байжээ.

2010 оноос ГХСС-ийн Хэлшинжлэлийн хамтлаг, Эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж, голлон зэрэгцүүлсэн хэлшинжлэл, тользүйн чиглэлээр судалгаа хийж байв.

Г.Лувсангийн ажил хөдөлмөрийг үнэлж 1974 онд “Засгийн газрын хүндэт жуух бичиг”, 2000 онд “Ардын боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2001 онд “Боловсролын 80 жилийн ойн медаль”, 2002 онд “Алтан гадас” одонгоор шагнасан байна. 2009 онд МУ-ын “Гавьяат багш” цол хүртээжээ.

ДЭД ПРОФЕССОР, ДОКТОР Г. ЛУВСАНГИЙН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ:

НЭГ. СУРАХ БИЧИГ, НОМ, ТОЛЬ, ТОВХИМОЛ

№	Номын нэр	Хэвлэсэн газар, он, хэмжээ	Хамтран зохиогч
1	Герман хэл өөрөө сурах бичиг	УБ, 1975, 2000, 14 хх	проф.Чой. Лувсанжав

2	Герман-Монгол ярианы дэвтэр	УБ, 1975, 8,5 хх	
3	Герман-Монгол толь	Лайпциг, 1981, 1992..., 28 хх	проф. Х,-П. Фийце нар
4	Герман - Монгол өврийн толь	УБ, 1987, 13 хх	
5	Орос-Монгол-Герман зурагт толь	УБ, 1986, 8 хх	проф. Т.Дорждагва нар
6	Цэнхэр хадаг	Берлин, 1978, 6 хх	Р. Бауве
7	Хичээлийн герман хэллэг	УБ, 1972, 1,5 хх	
8	Алтан товч	Токио, 1992, 18 хх	проф. Х,-П Фийце
9	Германы монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт	УБ, 2002, 15 хх	доктор С. Алимаа
10	Монгол хэлний сурах бичиг (Герман хэлтэнд зориулсан)	УБ, 2002, 19 хх	
11	Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь	УБ, 2003, 5 боть, 8 дэвтэр, 474,8 хх	Хамтын бүтээл
12	Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (Манж, Богдхаант улсын үе)	УБ, 2004, 23,5 хх	Хамтын бүтээл
13	Герман - Монгол толь	УБ, 2008, 46,5 хх, 750 хуудас	Хамтын бүтээл

ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

№	Номын нэр	Хэвлэсэн газар, он, хэмжээ	Хамтран зохиогч
1	Элжигийн халхын гарал, газар усны нэрийн домог	УБ, 1973, 2 хх	проф.С. Бадамхатан
2	Монгол ардын хоёр дуу	УБ, 1973, 3 хуудас	
3	Ардын хувьсгалын эхэн үеийн зарим дуу	Лондон, 1984, 6 хуудас	

4	Монгол хэлний нэгэн зүйл - саг4 дагаврын утга бүтэц	УБ, 1985, 3 хуудас	
5	Алтан товч компьютерт	Берлин, 1990, 6 хуудас	проф. Х.-П. Фийце
6	"Монголын Нууц Товчоо"-ны герман хоёр орчуулгын тухайд	УБ, 2006, 4 хуудас	
7	Вальтер Хайссиг "Удиртгал" орчуулга	УБ, 2007, 6 хуудас	

ГУРАВ. РЕДАКТОРЛАСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТЫН БҮТЭЭЛ

№	Зохиогч	Номын нэр	Хэвлэсэн газар, он, хэмжээ
1	Б. Амаржаргал	Халхын аман аялгууны толь	УБ, 1988, 22,5 хх
2	С. Алимаа	Герман хэл сурах-сургах гарын авлага	УБ, 1998, 14,5 хх
3	Т. Сосорбарам	Чанар стандарт хэмжилзүйн англи-монгол нэр томъёо	УБ, 1999, 8,8 хх
4	Ш. Туяа	Герман хэлний 2000 сорилго	УБ, 2002, 10,5 хх
5	Э. Равдан	Хэл шижлэлийн түүхийн товчоон	УБ, 2002, 19 хх
6	Э. Равдан	Монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утга зүйн судалгаа	УБ, 2004, 26,8 хх
7	Э. Равдан	Орчин цагийн хэл шинжлэл	УБ, 2005, 17 хх
8	Н. Нансалмаа	Үгсийн сан судлал	УБ, 2005, 10,8 хх
9	Э. Равдан	Орчин цагийн хэл шинжлэлийн үүд	УБ, 2005, 18 хх
10	Ч. Дэлгэрцэцэг	Герман хэлний 1000 сорилго	УБ, 2005, 7,5 хх

11	"Дэлхийд тахрсан монгол газар нутгийн нэр"	Тус номын 8 өгүүллийн хөрвүүлгийг хянасан	УБ, 2006, 9,8 хх
12	Э.Равдан	Монгол орны газар нутгийн нэрзүй	УБ, 2008, 44,5 хх

ДӨРӨВ. РЕДАКТОРЛАСАН ОРЧУУЛГЫН ЗОХИОЛ

№	Зохиогч	Номын нэр	Хэвлэсэн газар, он, хэмжээ
1	Бруно Апиц	Араатны дунд гар хоосон	УБ, 1972, 26 хх
2	Хайнрих Манн	Боол	УБ, 1974, 23,7 хх
3	Эрвин Штритт-маттер	Одой азрага Пони Педро	УБ, 1974, 9,3 хх

ТАВ. УДИРДАЖ ХАМГААЛУУЛСАН МАГИСТРЫН АЖИЛ

1. Ж.Ариунаа, Герман хэлний чиглэлт хөдөлгөөн заасан үйл үгийн утга монгол хэлнээ илрэх нь, 1998 он
2. Б.Нямсүрэн, Герман монгол хэлний нэрийн тооны тогтголцоог зэрэгцүүлсэн судалгаа, 2000 он
3. Я.Эрдэнэсүрэн, Герман хэлний барилга, архитектурын нэр томъёог монгол хэлнээ оноон орчуулах асуудалд, 2000 он
4. О.Нуржан, Казак, монгол, герман хэлний өнгөний бэлгэдлийг зэрэгцүүлсэн судалгаа, 2001 он
5. М.Цогбаатар, Адууны зүсийг герман хэлнээ орчуулах асуудалд, 2002 он
6. Ц.Доржнямбуу, Герман хэлний aus – угтвар, түүний утга монгол хэлнээ илрэх нь, 2002 он
7. С.Атармаа, Монгол хэлний үндэсний онцлогтой үг хэллэгийг герман хэлнээ орчуулах асуудалд – цагаан идээний жишээн дээр, 2002 он
8. Г.Гэрэлмаа, Герман хэлний –lich дагавартай хавсрал нэр, түүний утга монгол хэлнээ илрэх нь, 2003 он
9. О.Болдцэцэг, Герман монгол хэлний өгөх оршихын тийн ялгалыг харьцуулан судалсан нь, 2003 он
10. Б.Даваасүрэн, Европын холбоо хийгээд хоёр германы нэгдсэн асуудалд, 2003 он

11. Н.Мөнхбаяр, Герман хэлний идэвхгүй хэвийг монгол хэлнээ харьцуулсан судалгаа, 2003 он
12. Ч.Дэлгэрцэцэг, Германы үндсэн хуулийг монгол хэлнээ орчуулсан асуудалд, 2003 он
13. П.Одонцэцэг, Герман хэлний хүний бие эрхтэнтэй холбоотой хэвшмэл хэллэгийг монгол хэлнээ орчуулах асуудалд, 2003 он
14. Д.Энхзаяа, Монгол хэлний ертөнцийн гурвыг герман хэлнээ орчуулах асуудалд, 2003 он
15. Д.Болормаа, Funktionsverb- (нөхцмөл үйл үг)-ийн утга монгол хэлнээ илрэх нь, 2003 он
16. Ч.Сэлэнгэмөрөн, ХБНГУ-ын нутгийн өөртөө удирдах тогтолцоо, ялгаатай болон төсөөтэй шинж – Бавари, Баден-Вюрттемберг муж улсын жишээн дээр, 2006 он
17. Д.Оюунхишиг, Германы хуримлах ёс, уламжлал, шинэчлэл, 2007 он

ЗУРГАА. ШҮҮМЖ БИЧСЭН ДОКТОР (Ph.D)-ЫН АЖИЛ

1. Х.Наранчимэг Герман, монгол зүйр цэцэн үгийн зэрэгцүүлсэн судалгаа, 2001 он
2. Ш.Туяа Орчин цагийн орос монгол хэлний үүсмэл нэрийн бүтэц, утга судлал, 2001 он
3. Ж.Ариунаа Герман монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэрийн зэрэгцүүлсэн судалгаа, 2004 он
4. Ч.Батсүрэн Монголын газар усны нэрэнд малын тухайт үг туссан хийгээд утгазүйн судалгаа, 2006 он

ДОЛОО. ШҮҮМЖ БИЧСЭН МАГИСТРЫН АЖИЛ

1. Б.Энхжаргал “Элэг” орсон монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа, 2006 он
2. Ундармаа Отгонтэнгэр уулын ойрлцоох газар усны нэрийн судалгаа, 2005 он
3. Уянга Орчин цагийн монгол хэлний нэршүүлэх үзэгдэл
4. Г.Ганзул Ертөнцийн хэлний зураглал, 2007 он

НАЙМ. УДИРДАЖ ХАМГААЛУУЛСАН ДИПЛОМЫН АЖИЛ

1. С. Батцэцэг Морины зүсийг герман хэлнээ орчуулах асуудалд
2. Т. Одонцэцэг Хүний бие эрхтэнтэй холбоотой монгол хэлний хэвшмэл хэллэгийг герман хэлээр орчуулахад
3. А. Дуулиант Герман хэлний хууль зүйн зарим нэр томъёог монгол хэлнээ орчуулах асуудалд



4. Н. Батхишиг Герман хэлний –heit, -keit дагавар монгол хэлнээ илрэх нь
5. Б. Хулан “Монголын Нууц Товчоо”-ны герман хоёр орчуулгыг харьцуулсан судалгаа, 2007 он
6. Ш. Мөнхбаатар Монгол хэлний –лаг⁴ дагаврын утга, бүтэц герман хэлнээ илрэх нь, 2008 он

ЕС. ШҮҮМЖ БИЧСЭН ДИПЛОМЫН АЖИЛ



1. Л. Лхагвасүрэн Бисмаркийн гадаад бодлого, 2003 он
2. Б. Итгэл Монгол хэлний зарим чимэх үг, түүний утга герман хэлнээ илрэх нь, 2005 он
3. Д. Цэцэнбилэг Монгол хэлний –тан, -чин, -ч дагаврыг герман хэлнээ илрүүлэх боломж, 2007 он
4. Г. Цэрэн-Янжин Герман хэлний хүсэн болзох төлөв II монгол хэлнээ илрэх нь, 2007 он
5. М. Мандах Герман монгол хэлний хавсарсан нийлмэл өгүүлбэр дэх цагийн зохицол, 2008 он

АРАВ. УДИРДСАН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

1. Б. Энхболд Орчин цагийн монгол хэлний нэрээс үйл үг үүсгэх –да⁴ дагаврын утга, бүтэц герман хэлнээ илрэх нь, 2003 он
2. Нацагдорж Халимагийн түүхийг герман сурвалжаар мушгих нь, 2003 он



ОЛОН ХЭЛНИЙ ОРЧУУЛГЫН ТОЙМ



АМЕРИКИЙН УРАН ЗОХИОЛЫГ МОНГОЛ ХЭЛЭЭР ОРЧУУЛСАН ҮЕ ҮЕИЙН ОРЧУУЛАГЧДЫН БҮТЭЭЛ ТУУРВИЛЫН ТОЙМ

А. Өлзийнаран¹, Н.Оюунзаяа²

Товч утга: Энэхүү өгүүлэлээрээ Америкийн уран зохиолыг Монголд орчуулсан үе үеийн орчуулагчдын зохиол бүтээлийн тойм гаргав.

Түлхүүр үг: америкийн уран зохиол, нэрт төлөөлөгчид, монголын орчуулагчид

Дэлхийн улс орнууд эрт үеэс өөр хоорондоо олон талаар харилцаж, өөрсдийн соёлоо шууд болон дам байдлаар түгээж ирсэн бөгөөд үүний нэг илрэл нь гадаадын уран зохиол, түүнийг орчуулан бусад ард түмний соёлтой танилцаж ирсэн явдал юм.

Монголчууд гадаадын олон орны уран зохиолыг эх хэлнээ хөрвүүлж, утга зохиолын нэг төрөл болтол баяжуулж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Орчин үеийн орчуулгын уран зохиолын дотор Америкийн уран зохиол томоохон байр суурийг эзэлдэг.

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж (1906-1937) нь орчин үеийн Монголын орчуулгыг хөгжүүлэхэд үлэмж их хувь нэмэр оруулсан гавъяатан мөн. Тэрээр 1935 онд Эдгар Аллан По-гийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, монголын ард түмнийг Америкийн уран зохиолтой танилцуулсан билээ.

XX зууны монголын орчуулгын хөгжилд дорно дахины суут эрдэмтэн, зохиолч Бямбын Ринчен (1905-1977) үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан юм. Б.Ринчен хориод орны далаад зохиолчдын хоёр зуун дөч орчим зохиол бүтээлийг англи, орос, франц, чех, польш, эсперанто зэрэг олон хэлнээс монголоор орчуулсан гэсэн тойм байгаа боловч бүрэн тооцоо хараахан биш. Учир нь түүний орчуулгын бүтээлээс багагүй зүйл үрэгдсэний зэрэгцээ янз бүрийн шалтгаанаар хэвлэгдэж амжаагүй гар бичмэл олдсоор байгаа билээ. Тэрээр Ж.Рид, Ж.Лондон, В.Ветман, Х.Лонгфелло нарын зохиол бүтээлээс орчуулж байсан боловч тодорхой шалтгаанаар тухайн үедээ хэвлэгдээгүй байна. (Р.Гүрбазар, 1996:64)

Монголчууд Америкийн уран зохиолын олон төрөл жанрыг англи, орос, герман, чех, румын зэрэг хэлнээс хөрвүүлж ирсэн байдаг. Энэхүү сэдвийн хүрээнд америкийн уран зохиолыг монгол хэлнээ орчуулж ирсэн үе үеийн орчуулагчдын зохиол бүтээлийн тойм гаргахыг зорилоо. Үүний тулд, Төв номын сангийн 1921-2005 оны хооронд орчуулагдаж хэвлэгдсэн америкийн

¹ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

² МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

уран зохиолын орчуулгын бүтээлүүдийн бүртгэл, номзүйг шүүн, тэдгээрийг төрөл, зохиолч, орчуулагчаар ангилан судалгааны тойм дүгнэлт гаргав.

Америкийн уран зохиолыг монгол хэлээр орчуулсан бүтээлийг дараах байдлаар үечилж, тухайн үеийн орчуулгын уран зохиолын онцлогыг товч дүгнэлээ. Үүнд:

1. 1935-1960
2. 1961-1970
3. 1971-1985
4. 1986-2005

1. 1935-1960 оны орчуулгын уран зохиолын онцлог

1935 онд их зохиолч Д.Нацагдорж Эдгар Аллан По-гийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, Америкийн зохиолчдын сонгодог бүтээлүүдийг орчуулах ажлыг эхлүүлсэн юм. Түүнээс хойш Б.Энэбиш, М.Гаадамба, С.Эрдэнээ, Г.Дэлэг, П.Чойжил, Г.Дамдин, Г.Сүхбаатар, Н.Самбуу, Д.Лодойдамба, Д.Бямбаа, Б.Дэмчигдорж, Д.Цэрэндондов, С.Сандагдорж, Ж.Аминдаваа нарын 14 орчуулагч Жек Лондон, Эдгар По, Т.Драйзер, Г.Лонгфелло, А.Мальц, М.Твен, М.Гольд, Г.Фаст зэрэг 15 зохиолчийн 20 сонгодог бүтээлийг герман, орос, англи хэлнээс орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг:

Эдгар Аллан По “Алтан цох” (Герман хэлнээс Д.Нацагдорж, 1935), Говард Фаст “Пикскилл, Америкийн нэгдсэн улс” (Оросоос орч. М.Гаадамба, 1959), “Тэргэнд зүтгэгч хүн” (Оросоос орч. Н.Самбуу, Д.Лодойдамба, 1953), Жек Лондон “Амьд явахын хүсэл” (орч. Г.Дэлэг, 1944), А.Мальц “Цирк ирлээ” (Англиас орч. Д. Цэрэндондов, 1958), Т.Драйзер “Сэтгэлийн догшин шуурга” (Оросоос орч. Б.Дэмчигдорж, 1957) зэрэг 11 бүтээлүүдийг орчуулагдсан байна.

Б) Шүлэг:

Х.Гардман “Эхийн үг” (орч. С.Эрдэнээ, 1953), Гольд.М “120 сая” (Англиас орч. Д. Бямбаа, 1959), Лонгфелло.Г.У “Ариун нэр” (Англиас орч. Д. Бямбаа, 1958), “Сум дуулал хоёр” (Оросоос орч. М.Гаадамба, 1957), Эдгар Аллан По “Аннабель Ли” (Оросоос орч. С.Сандагдорж, 1954), Ростен.Н “Сан-Франциск-д” (Оросоос орч. Г.Дамдин, 1951) гэсэн 6 шүлэг орчуулагдсан байна.

В) Үлгэр:

Жек Лондон “Орчлонгийн жам” (Орчуулга, 1937), “Кишийн тухай үлгэр” (Оросоос орч. П.Чойжил, 1955) “Тахиа, хулгана, сойр гурав” (Германаас орч. Б.Энэбиш, 1955) гэсэн 3 үлгэр орчуулжээ.

2. 1961-1970 оны орчуулгын уран зохиолын онцлог

Манай орчуулагчид 1950-аад оны дунд үе хүртэл цаг үеийн шаардлагаар зөвхөн орос хэлээр дамжуулан гадаадын зохиолтой танилцаж байсан бол аажмаар олон төрлийн харь хэл эзэмших болсноор бусад орны уран зохиолыг

эх хэлнээс нь шууд орчуулах хандлага давамгайлах болжээ. Энэ үеийн онцлог нь манай сэхээтнүүд америкийн уран зохиолыг ихээхэн сонирхох болсон нь тухайн үед орчуулагдсан бүтээлүүдийн төрөл, тоо, орчуулагчдын тооноос харагдаж байна.Тухайн үеийн орчуулагчдаас Бага Энэбиш, С.Цэрэндэндэв нарын зохиолчид англи хэлнээс түлхүү орчуулж, ялангуяа яруу найргийн бүтээлийг шимтэн орчуулж байсан нь ажиглагдаж байна.

Энэ үеийн гол орчуулагчид болох Бага Энэбиш, Н.Наваан-Юндэн, Б.Бааст, Б.Энэбиш, Г.Биндэрьяа, Бооёо, Х.Нацагдорж, С.Сандагдорж, С.Цэрэндондов, Ц.Шүгэр, Э.Эрдэнэ, Ц.Мөнхжаргал, Г.Лувсанцэрэн, П.Ядамсүрэн, Д.Гомбожав, Ч.Нямдорж, Д.Хишигжаргал, Л.Хуушаан, Х.Лхамдорж, Ц.Балхаажав, Г.Цагаач, Л.Түдэв, Цэнд-очир, Т.Төмөрбат, Ү. Нямдорж, С.Авирмэд, М.Цэдэндорж нарын 26 орчуулагч Арт Бухвальд, О.Генри, Т.Драйзер, Жек Лондон, Ж. Рид, Х.Сэндберг, У.Уитман, Р.Фрост, Л.Хьюз, Э.Хэмингуэй, Э.Дикинсон, Г.Лонгфелло зэрэг 26 зохиолчийн 49 бүтээлийг орос,англи, чех хэлнээс орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг:

Дуглас.У “Америкчуудын харахад монгол орон” (Орчуулга, 1964), Колдуэлл.Э “Сүүлчийн ой” (Оросоос орч. Г.Биндэрьяа, 1964), Куйна.М “Яап Яап арлын алтан бээлийнүүд”(Англиас орч.Бооёо,1962), Эдгар Аллан По “Хулгайд алдагдсан захидал” (Оросоос орч.Ц.Шүгэр, 1963), “Хүн амины хэрэг” (Оросоос орч.Ц.Шүгэр, 1963), “Ганс Пфрольд учирсан явдал” (Оросоос орч. Ц.Шүгэр,1963),Т. Уолкинс “Баруун зүгийн араншин” (Оросоос орч.Ү.Нямдорж, 1962), Бухвальд.А “Хэний ч санаанд ороогүй юм даа” (Оросоос орч.С.Цэрэндэндэв, 1966), Генри.О “Сүүлчийн навч” (Англиас орч. Л.Хуушаан, 1966), Азимов.А “Аялгуут хонх” (орч.Р.Доржсүрэн, 1970) зэрэг 6 өгүүллэг хөрвүүлэгдсэн байна.

Б) Шүлэг

Робинзон.Э.А “Ричард Кори” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Сегал.Э “Шувуу байсан бол”,“Гүүр” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Сэндберг.Э “Алхаад өнгөр” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Уитман.У “Америкийг дуулахыг сонсном”, “Бүсгүй намайг хүлээж байгаа” (Орчуулга,1962), “Өвсний навч” (Оросоос орч. Д.Гомбожав, 1964), Р.Фрост “Билчээрт”, “Навчис” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), “Алсын тэртээгээс”, “Бадарчинд биширсэн нь”, “Эрэлчин”, “Навчын ертөнц” (Оросоос орч.Г.Лувсанцэрэн,1963), “Хусан шугуй” шүлгүүд (Оросоос орч.Г.Лувсанцэрэн, 1966), Л.Хьюз “Саад хашлага хилийн харуулыг ч хайхрахгүй” (Англиас орч.С.Цэрэндэндэв, 1962), “Ажилгүй хүн”, “Хөрөнгөтний бодол”, “Дарлал”, “Хав харанхуй шөнө”, “Өнөөдөр” (Англиас орч. Бага Энэбиш, 1963),“Африк” (Англиас орч. С.Цэрэндэндэв, 1963), Жон Рид “Бид бол хувьсгалчид”, “Хүү минь үүнийг ойлгоорой”, “Дайн үргэлжилсээр байна” дуунууд (Оросоос орч. Л.Хуушаан, 1967), Сэндберг.Х “Турван үг” (Оросоос орч.М.Цэдэндорж, 1968), “Тоорой хайлаас хоёр” (Оросоос орч.С.Авирмэд, 1969), Уйтмен.У “Буурал нь баярлалаа”, “Өдөр өнгөрөхийн хэрд

сонсоод би” (Оросоос орч. М.Цэдэндорж, 1969), ”Гайхамшиг” (Оросоос орч. М.Цэдэндорж, 1968), Жо Хилл “Бид дуулна” (орч.Ш.Цогт, 1970) зэрэг 20 орчим шүлэг орчуулагдсан байна.

В) Тууж

Эрнест Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” (Оросоос орч.С.Сандагдорж, 1961), Игер.Э “Шидэт долоо хоног” (Англиас орч. Г.Цагаач, Л.Түдэв, 1968) гэсэн 2 тууж орчуулагдсан байна.

Г) Роман

Бичер Стоу.Г “Том авгын овоохой” (Оросоос орч. Н.Наваан-Юндэн), Драйзер.Т “Америкийн эмгэнэлт явдал” (Оросоос орч. Б.Энэбиш, Г.Амар, 1960), “Америкийн эмгэнэлт явдал” 2-р дэвтэр (Оросоос орч. Б.Энэбиш, Г.Амар, 1968), “Женни Герхард” (Оросоос орч.Х.Лхамдорж, Ц.Балхаажав, 1966), “Амьдралын баатар” (Англиас орч.Л.Дашням, 1970), Жек Лондон “Мартин Иден” (Оросоос орч.Г.Төмөрбат, Ү.Нямдорж, 1969), Твен.М “Текельберри Финнад тохиолдсон адал явдал” (Оросоос орч. Г.Төмөрбат, 1965), Ж.Купер “Сүүлчийн Могикан” (Оросоос орч. Г.Амар, 1970), Эрнест Хэмингуэй “Зэр зэвсэг минь баяртай” (Оросоос орч.М.Цэдэндорж, 1970) зэрэг 10 орчим роман орчуулагдаж уншигчдын хүртээл болжээ.

3. 1971-1985 оны орчуулгын уран зохиолын онцлог

Энэ үеийн орчуулагчид Америкийн уран зохиолын төрлүүдээс өгүүллэгийг голчлон орчуулж байсан бөгөөд “Бродвэйн шөнө” хэмээх 18 өгүүллэгийн эмхэтгэлийг олон орчуулагч хамтран гаргасан байна. Мөн англи хэлнээс орчуулагчдын тоо олширсон нь ажиглагдаж байна. Тухайлбал, Ч.Алагсай, Л.Дашням, Н.Доржготов, Н.Цэвэгмид, Чимэддорж, Ц.Гомбосүрэн, Б.Цэрэндаш, Д.Алтанхуяг нарыг дурдаж болох юм. Орчуулагч Д.Бямбаа шүлэглэсэн бүтээлийг орчуулахад нилээд гаршиж байсан төдийгүй “Хэрэв бүх тэнгисийг нэг тэнгис болговол” хүүхдийн шүлгийн номыг дангаараа орчуулж байжээ.

Р.Доржсүрэн, Ч.Алагсай, Б.Пүрэвсүрэн, Л.Дашням, Ш.Цогт, Г.Амар, Р.Санжаасүрэн, Ч.Оюун, Д.Лодойдамба, Ж.Лхагва, Б.Ламжав, М.Цэдэндорж, Н.Доржготов, Л.Хуушаан, Чимэддорж, Н.Цэвэгмид, Ц.Сумъяа, Ц.Цэрэн, Д.Нацагдорж, Б.Энэбиш, А.Шархүү, Ц.Гомбосүрэн, Д.Лхамжав, Д.Цэцэгмаа, Д.Алтанхуяг, Б.Цэрэндаш, Г.Аким, Р.Юра, С.Хаш-эрдэнэ, С.Пүрэв, С.Одбал, С.Чулуунбат, Б.Батбаяр, Д.Бямбаа, Б.Жамсранжав, Ц.Ганзориг, М.Зээхүү нарын 38 орчуулагч Америкийн 35 зохиолчийн 66 бүтээлийг англи, орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлжээ.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг

Андерсон.Ш “Багш” (орч.Ш.Сумъяа, 1974), “Бродвэйн шөнө” Америк өгүүллэгийн эмхэтгэл (Ред. Л.Дашням, 1974), Гоүлд.М “Нөгөө гайхал ухуулагч” (орч. Д.Нацагдорж, 1974), Драйзер.Т “Харанхуйгаар”, “Цастайд”, “Шуурганаар” (орч. Д.Лхамжав, 1974), Колдүвелл.Э “Охин минь”, “Кристи Такер амь эрсэдсэн

нь” (Оросоос орч.Н.Доржготов, 1974), Күйн.М “Хавьтамгүй эр”, “Хүний адаг хөрөнгийн эзэн” (Оросоос орч.Д.Нацагдорж, 1974), Мальц.А “Замд тааралдсан хүн” (орч. Д.Цэцэгмаа, 1974), “Үд дундын балар ой” (орч. Д.Алтанхуяг, 1974), Ж.Рид “Америк мак”, “Бродвэйн шөнө” (орч. Д.Нацагдорж, 1974), Сандерсон.А “Усны хүмүүс” (орч. Г.Аким, 1974), Сароян.В “Хоньчин охин” (орч. Н.Доржготов, 1974), Эрнест Хэмингуэй “Индианын гацаа” (орч.Н.Доржготов, 1974), “Испаний төлөө нөгцсөн Америкчуудад” (орч.Л.Алтанхуяг, 1974), Эрнест Хэмингуэй “Климанжарогийн цас” (Англиас орч.Л.Алтанхуяг, 1976), Хенри.О “Цэнхэр хувцастан ба мөргөлийн дуулал” (орч. Л.Алтанхуяг, 1974), Хьюз.Л “Түшиглэх юм чинь” (орч. Д.Нацагдорж, 1974), Бредбери.Р “Тэнгэрт гарсан хүн” (орч. М.Зээхүү, 1976), Бредберри.Р “П-гэж пуужин” (орч.Н.Цэвэгмэд, 1977), “Сансрын нисэгч” (орч. С.Чулуунбат 1978), Бухвальд.А “Пентагоны шинэ жилийн үдэш” (орч.С.Хаш-Эрдэнэ, 1978), Драйзер.Т “Мундаг эр” (орч.Ц.Гомбосүрэн, 1973), Райт.Р “Зарц” (орч.С.Пүрэв, 1978), Раскатов.М “Цатгалан муур өлсгөлөн хүмүүсийн дууль” (орч.С.Одбал, 1978), Эрнест Хэмингуэй “Гүүрийн дэргэд суугаа өвгөн” (орч.Д.Алтанхуяг, 1979), Квентин.П “Жо ахыг хэн буудав” (орч.Ц.Цэрэн, 1980), Генри.О “Хайр сэтгэл” (орч.Н.Доржготов, 1984), Лингстон Хьюз “Би негр хүн” (орч. Б.Жамсранжав, 1981), Марк Твен “Тахал” (орч. Ц.Ганзориг, 1981), Шервуд Андерсон “Этгээд хүний тухай ном” (орч.Н.Доржготов, 1984) зэрэг 37 өгүүллэг орчуулсан байна.

Б) Шүлэг

Өргөнгөө Онон “Монгол гэр” (Монголоор бичсэн шүлэг, 1971), “Хэрэв бүх тэнгисийг нэг тэнгис болговол” Хүүхдийн шүлгүүд (орч. Д.Бямбаа, 1978), Лингстон Хьюз “Америк минь бос” (орч. Б.Жамсранжав, 1981), Огден Нэш “Улс төрийн хэнээтэн” (орч. Д.Бямбаа, 1983) зэрэг шүлгүүдийг дурдаж болно.

В) Роман

Драйзер.Т “Амьдралын баатар” (Англиас орч. Б.Пүрэвсүрэн, 1971), “Америкийн эмгэнэлт явдал” (орч. Б.Энэбиш, А.Шархүү, 1974), “Санхүүч” (Англиас орч. Ц.Гомбосүрэн, 1973), Эрнест Хэмингуэй “Африкийн ногоон толгод” (орч. Д.Алтанхуяг, Н.Цэвэгмид, 1979) зэрэг 4 романыг орчуулсан байна.

4. 1986-2005 оны орчуулгын уран зохиолын онцлог

Нийгмийн хувьсалыг даган энэ цаг үеийн орчуулгын бүтээлүүд нь сонголтын хувьд чөлөөтэй болж, орчуулагчдын тоо олширсон бөгөөд бүтээлийг эх хэлнээс нь орчуулах явдал зонхилох болсон ч орчуулгын чанарт тавигдах хяналт үгүй болсонтой уялдан олон тооны доголдлууд ажиглагдах болсон байна. Энэ үед Ц.Цэрэн, Д.Алтанхуяг, Ц.Барадий, Д.Дашмөнх, Д.Лхамжав, П.Чойжил, Б.Пүүшил, Б.Чимэдбат, Г.Аюурзана, Н.Энхбаяр нарын зэрэг 40 орчим орчуулагч Америкийн 53 зохиолчийн 280 гаран бүтээл, үүний дотор 232 өгүүллэг, 21 роман, 6 тууж болон шүлэг найруулал орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг

Энэ үеийн орчуулгын зохиолын дийлэнх хувийг өгүүллэгийн төрөл зүйл эзэлж байна. Үүнд:

- Бухвальд.А “Америк орон ба Америкчууд” (Англиас орч. Ц.Цэрэн нар, 1985)Тус номонд Арт Бухвальдын “Ааваа юу болсон бэ”, “Аяд нийцэхгүй байна”, “Бичиг үсэгт тайлагдаагүй хүний коллеж”, “Муухай юманд зориулсан цэвэр бөмбөг” гэх мэт шилдэг хошин 136 өгүүллэг;

- Генри.О-ийн “Алгаараа соронздогч Жефф Питерс” (Оросоос орч. Б.Чимэдбат, 2002), “Балчрууд ширэнгэнд” (Англиас орч. С.Авирмэд,2002), “Бидний сонгосон зам” (Англиас орч. С.Авирмэд, 2002), “Биедээ татахдаа гарамгай Джефф Питерс” (Англиас орч. С.Авирмэд, 2002) зэрэг 47 өгүүллэг

- Жек Лондоны “Алс тэртээх хязгаарт”, “Амьдралын жам”, “Жис-Укын түүх” зэрэг 13 өгүүллэгийг орос хэлнээс орчуулагч Б.Чимэдбат 2001 онд орчуулж хэвлүүлсэн бол “Амьд явахын хүслэн” (орч. Ж.Дамдинсүрэн, 1998), “Аян замын арга ухаан” (орч. Г.Амар, 2002), “Хүний амь” (орч. Ш.Очирбат, 1997) гэх мэт 6 өгүүллэг монгол хэлнээ хөрвүүлэгдэн бидний гар дээр иржээ.

- Бэрретт.М “Шулмын эзгүй шөнө” (орч. Д.Алтанхуяг, 1992), Айзек Азимов “Ялан дийлэгч машин” (орч. З.Туул, 1989), Шервуд Андерсон “Хувцасны шүүгээ” (Оросоос орч. Д.Бадарч, 1996), Рэй Дуглас Брэдбери “Хог” (орч. Д.Цэрэн, 1989), Эрл Стенли Гарднер “Өмгөөлөгч Перри Мейсон (орч. Д.Алтанхуяг ,1992), “Ууртай гэрч” (орч. Д.Мөнхбаяр, 1992), Кларк Говард. “Амь дэнссэн хэрэг” (Англиас орч. Б.Байгаль, 1992), “Мафи” (Англиас орч. Ц.Барадий,1992), Зингер.И.Б “Золиос” (орч. Г.Аюурзана, 2000), Стивн Кинг “Буг” (орч. Д.Дашмөнх ,1998), Эллери Куин “Жолооны ард хэн байв” (орч. Д.Дашмөнх ,1998), Ричард Льюис “Бодлоо илчилсэн нь” (орч. Д.Бямбацогт, 1993), Мактарроу.Ф “Дуугүй байх бол алт” (орч. Д.Дашмөнх, 1998), Росс Макдональд “Кадилак машинтай хүн” (орч. П.Чойжил, 1997),Эдгар По “Морт гудамжинд гарсан хүн амины хэрэг (орч. П.Чойжил, 1993), Ричард Скот Пратер “Хилэнцийн гудамж” (орч. П.Чойжил, 1997),“Эргэн тойрон луйвар” (орч. Д.Мөнхбаяр, 1996) зэрэг 232 өгүүллэг тус цаг үед орчуулагдсан байна.

Б) Шүлэг

Аллен Гинсберг “Аглаг зэлүүд хадат ууланд” гурван мөрт шүлгүүд (орч. Д.Одонхорлоо, 2004), “Битгий өтлөөрэй” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Бурклины лут ухаантан” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Дөрвөн давхарт шөнөжин захидал бичэхүй дор үүр хаяарлаа” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Хэн Америкийг удирдаж байна вэ” (орч. Д.Одонхорлоо, 2004) зэрэг цөөн тооны шүлгүүд орчуулагджээ.

В) Тууж

Ричард Бах “Жонатан Ливингстон хэмээх цахлай” үлгэр тууж (орч. Н.Энхбаяр, 2005), Дональд Вестлейк “Цагдаа хулгайчид” (орч. Ц.Барадий, 1992), Чарльз Вильямс “Эмэгтэй хүний турьхан гар” (орч. Ц.Барадий, Д.Мөнхбаяр, 1992), Жек Лондон “Догшин араатан” (Оросоос орч. Ж.Дамдинсүрэн, 1994), Уильям Фолкнер “Баавгай” (орч. Г.Аюурзана, 2000),

Раймонд Чандлер “Невадын хорт хий” (орч. Ц.Барадий, 1992) зэрэг 6 тууж орчуулагдсан байна.

Г) Роман

Болдхид.В “Эзний хэргэмд дэвших ёслол” (орч. С.Дашдондов, 1995), Жон Болл “Каролины бүгчим шөнө” (орч. Д.Бямбацогт, 1993), Пол Берховен “Төрөлхийн араншин” (орч. С. Отгонтөгс, 1998), Дональд Вестлейк “Хараал идсэн маргад эрдэнэ” (орч. Д.Бямбацогт, 1993), Чарльз Вильямс “Ням гарагийн тарчлаант шөнө” (орч. А.Эрдэнэтөгс, 1992), Эрл Стенли Гарднер “Өмгөөлөгч Перри Мейсон (орч. Д.Алтанхуяг, 1991), Дэвид Моррел “Рэнбо-1” (орч. Д.Бямбацог, 1994), Рекс Стаут “Одоо устгачих, хөлсийг нь дараа төлнө” (орч. С.Дашдооров 2004), Дональд Уэйстлейк “Цагдаа хулгайч хоёр” (орч. Ш.Янсанжав, 1994), Дешил Хеммит “Их гарын дээрэмчид” (орч. Н.Энхболд, 1992), Питерс Чейни “Хэрэг дууссанд тооц” (орч. Ц.Барадий, 1995), Сидни Шелдон “Багийг нь хуу татагтун” (орч. П.Чойжил, 2005), “Сурвалжлагч Дейна Эванс” (орч. С.Дашдондов, 2004), Виктор Эфтому “Тэнгэр” романы хэсэг (орч. Б.Чимэдбат, 1993) зэрэг 21 роман орчуулагдсан байна.

Дүгнэлт

Судалгаанаас нэгтгэн дүгнэвэл, 1921-2005 оны хооронд Америкийн уран зохиолыг 120 орчим монгол орчуулагчид 130 гаруй зохиолчийн 380 гаруй бүтээлийг орос, англи, герман, чех, румын хэлнээс орчуулжээ. Үүний дотор 50 гаруй зохиолчийн 200 гаруй өгүүллэг, 14 яруу найрагчийн 90 гаруй шүлэг, 60 гаруй роман, 10 гаруй тууж, хэд хэдэн дууль, үлгэр, найраглал, туурийг орчуулсан байна.

Судалгааны явцад хэд хэдэн зүйл ажиглагдлаа. Үүнд:

- 1935-1960 онд их зохиолч Д.Нацагдорж 1935 онд Эдгар Аллан Погийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, монголын ард түмнийг Америкийн уран зохиолтой танилцуулж, орчуулах ажлыг эхлүүлсэн юм. Тухайн үеийн онцлог нь орчуулагчдын тоо харьцангуй цөөн байсан бөгөөд ихэнх зохиол бүтээлүүдийг орос хэлнээс орчуулж байжээ. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим орчуулгын бүтээлүүд тухайн үедээ хэвлэгдээгүй байна.

- 1961-1970 онд орчуулагчдын тоо олширч, үүнийг дагаад орчуулгын уран зохиолын төрөл баяжсан байна. Мөн Америкийн уран зохиолыг орос хэл төдийгүй англи хэлнээс шууд орчуулах хандлага давамгайлах болсон байна.

- 1971-1985 он бол орчуулгын хөгжилд нилээд олол амжилт бүхий үе юм. Энэ үед манай нэрт орчуулагчид америкийн сонгодог бүтээлүүдийг олноор нь орчуулж, хамтран эмхтгэл гаргаж байлаа. Үүний нэг жишээ нь “Бродвэйн шөнө” өгүүллэгийн эмхэтгэлийг нэрлэж болох юм.

- 1986-2005 он бол шинэ үеийн орчуулагчид нилээд төрөн гарсан бөгөөд бүтээлийн тооны хувьд өмнөх үеүдтэй харьцуулахад харьцангуй их юм. Хэдий тийм боловч орчуулгын бүтээлийн төрөл зүйлийн хувьд нилээд

хумигдсан тал ажиглагдаж байна. Мөн орчуулгын чанарт тавигдах хяналт үгүй болсонтой уялдан орчуулгын алдаа дутагдал гарах болж, түүнийг засч сайжруулах асуудал орхигдох болсон байна.

Энэ бүгдээс дүгнэн үзвэл, бид орчуулгын сэтгэлгээ, уламжлалаа хадгалж, цаашид улам хөгжүүлэх асуудал бид бүгдийн өмнө нь зүй ёсоор тавигдаж байна.

Номзүй

1. 1921-1955 онд монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын бүртгэл, Улсын хэвлэлийн газар, УБ, 1957: 8
2. Гадаадын уран зохиолыг монгол хэлээр орчуулсан нь (1956-1960) УБ, 1963:57
3. БНМАУ-д 1961-1964 онд хэвлэгдсэн гадаадын уран зохиолын бүртгэл, УБ, 1966: 61-64
4. Г. Пүрэвдорж, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиолын судлал (1965-1969) , УБ, 1972: 110-112
5. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын судлалын судлалын номзүй (1970-1972) , УБ, 1974: 22-24
6. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиолын судлалын номзүй (1973-1974) , УБ, 1976: 25-28
7. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1975-1976) , УБ, 1978: 10
8. БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1977-1980) , УБ, 1983: 12-14
9. БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1981-1984) , УБ, 1987: 22
10. Yu. Munkh-Amgalan, “A survey of American Literature in Mongolia and its place in Mongolian Education” Mongolian studies: Journal of The Mongolia Society. Volume XXVI (2003/4)
11. Р. Гүрбазар, “Орчуулгын онол, дадлагын үндэс, УБ. 1996

ГЕРМАН-МОНГОЛ, МОНГОЛ-ГЕРМАН ОРЧУУЛГЫН БҮТЭЭЛИЙН ТОЙМ

Ж.Ариун³

Товч утга: 1930-аад онд их зохиолч Д.Нацагдорж “Алтан цох” зохиолыг орчуулснаар герман-монгол орчуулгын бүтээл төрсөн хэмээн баримталдаг байна. Социализмын үед буюу 1990-ээд оны ардчилсан хувьсгал өрнөх үе хүртэл орчуулсан зохиолын дийлэнх нь агуулгын хувьд үзэл сурталжсан байх тул БНАГУ-ын (хуучны социалист герман улс) зохиолчдын бүтээл туурвил байдаг байна. Орчин цагт энэ хандлага нэгэнт үгүй болж нийгэм улс төрийн, шинжлэх ухаан техникийн, үүнд, сэтгэлгээний, гүн ухааны гэх мэт өргөжин тэлж байна. Монгол-герман орчуулгын хувьд Erich Haenisch, Bernhard Julg, Walther Heissig, Erika Taube, Manfred Taube, Klaus Koppe, Barkmann, Udo.B., Renate Bauwe зэрэг судлаачид сонгодог болон орчин цагийн зохиол бүтээл, үлгэр туульсыг орчуулсан байна. Тооны хувьд авч үзвэл сүүлийн жилүүдэд өмнөх цаг үетэй харьцуулахад герман хэлнээс эх хэлнээ орчуулсан бүтээлийн тоо төдийлэн хангалттай бус байгаад их, дээд сургуулиуд, үүнд, МУИС мөн өөрийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт шинэчлэл хийн тусгах шаардлага бий.

Түлхүүр үг: Герман-монгол орчуулгын бүтээлийн төрөл, он дараалал, зарим нэгэн ажиглалт, монгол-герман орчуулгын зохиолын жагсаалт

Хүн төрөлхтний соёл нь хэдийвээр улс үндэстэн, ард түмнүүдийн бие даасан өв сан мөн боловч эцсийн дүндээ нэгдмэл цул шинжтэй үзэгдэл юм. Аль ч ард түмний урлаг уран зохиол нь харилцан бүтээлчээр суралцаж, шинэ шинэ агуулга, хэлбэр, дүр, үзэл санаа, туурвилзүйн арга барил, хэл найруулгын уран чадвар, өвөрмөц онцлогуудаар нэмэн баяжиж төгөлдөржиж байдаг жамтай гэхийн сацуу *менталитет гэж юу вэ?* гэсэн асуулт давхар урган гарч ирнэ. Энэ нь үндэстний онцлог, оюун санаа, сэтгэлгээний хэв маяг гэсэн үг ажээ.

Олон соёлын харилцаанд өөр хоорондоо хүндэтгэлтэй оршин тогтнож хөгжихөд менталитетийн ялгааг ойлгох, ойлгуулахад орчуулагч, орчуулгын бүтээлийн үнэ цэнэ давхар орших нь гарцаагүй хэмээгээд 1930-аад онд их зохиолч Д.Нацагдоржийн орчуулсан “Алтан цох” зохиолыг герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан анхны зохиол хэмээснийг баримталбал цөөнгүй тооны бүтээл байх боломжтой болов уу. Орчуулгын төрөл зүйлээр нь авч үзвэл, нийгэм улс төрийн зохиол бүтээл, шинжлэх ухаан-техникийн зохиол бүтээл, уран зохиолын орчуулгын бүтээл, үүнээс үргэлжилсэн үгийн зохиолын, яруу найргийн, жүжгийн зохиолын, хүүхдийн уран зохиолын бүтээл тус тус байна. Сүүлийн үед герман киног орчуулан үзэгчдэд хүргэж байгаа ч энэ удаагийн

³МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн багш, доктор /Ph.D./

судалгаанд тусгаагүй болно. Орчуулгын бүтээлийг найруулгын төрөл зүйлээр нь багцлан тоймлон харуулбал,

Нийгэм-улс төрийн зохиол бүтээлээс Карл Маркс *“Капитал, I боть”*, *“Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь”*, орч. Б.Бирваа, ред. Х.Лхамдорж, Д.Чойжил, А.Бямбаноров, УБ, 1999 (938 хуудас бүхий), Карл Маркс *“Капитал, III боть”*, *“Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь”*, III дэвтэр, *“Капиталист үйлдвэрлэлийн нийт процесс”*, орчуулагч Б.Бирваа, УБ, 2001 (524 хуудас бүхий), Очирбат Пунсалмаагийн, *“Тэнгэрийн цаг”*, 1996, орчуулсан У.Эрдэнэсанаа, Конрад-Аденауэрийн Сан, 2013, Эрих Фромм, *“Бий эсвэл Байх”*, орчуулагч С.Молор-Эрдэнэ, УБ, 2010, Мартин Хайдеггер, *“Байх ба Хугацаа”*, орчуулагч С.Молор-Эрдэнэ, УБ, 2011, *“Би хэн бэ?”* орчуулагч С.Молор-Эрдэнэ⁴ зэргийг дурдаж болно.

“Бүрэнгийн Бирваа нь “Капитал”-ыг орчуулсан нь Монголын эдийн засгийн сэтгэлгээний хөгжилд төдийгүй нийгэм-улс төрийн зохиолын орчуулгын түүхэнд цоо шинэ хуудас нээсэн юм” хэмээн МУСГЗ, сэтгүүлч Жа.Пүрэв “Монголын нэрт орчуулагчид” номд⁵ дурдсан байна.

С.Молор-Эрдэнэ нь философийн шинжлэх ухаанаар ХБНГУ-д докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийн нэг бөгөөд өрнийн сонгодог суут гүн ухаантнуудын бүтээлд үндэслэн сэтгэлгээний шинэ хэв маягийг оруулж ирэхийг зорин ажиллаж буй судлаач болно.

Шинжлэх ухаан-техникийн зохиол бүтээлийн тухайд Ханнс-Зайделийн сан, Конрад Аденауэрийн сан, *“Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс”* симпозиумын эмхэтгэл, Интерпресс, 1998 (2 хэлээр, 151 хуудас), Баркманн.У.Б, Хайсандай.Л, *“Монгол –Германы харилцаа, Өнгөрсөн үе – Эдүгээ-Хэтийн төлөв”*, МУ, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтсоны 30 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материалын эмхэтгэл, Монголын ШУА, ОУСХ, Монголын “Герман судлал” Төв, УБ, 2004 (2 хэлээр, 354 хуудас), Ханнс-Зайделийн сан, ГТХАН (GTZ), *“Үндсэн хууль ба ардчилсан эрхзүйт төр”* бага хурлын баримт материалын эмхтгэл, УБ, 2004 (429 хуудас), Конрад Аденауэрийн сан, Монгол-Германы чуулган, *“Иж бүрэн түншлэлийн төлөө”*, Конрад Аденауэрийн сан, Монгол-Германы чуулган хамтран зохион байгуулсан бага хурлуудын баримт материалын эмхтгэл, УБ, 2004 (2 хэлээр, 398 хуудас), Монгол-Германы гүүр ТББ, *“МУ-ын эдийн засгийн хөгжилд Германд төгсөгчдийн оруулж буй хувь нэмэр”*, Монгол-Германы гүүр ТББ, АГЕФ Берлин хамтран зохион байгуулсан Германд төгсөгчдийн 3-р өдрүүдийн баримт материалын эмхтгэл, Ган Принт, 2006 (116 хуудас), Баркманн У.Б, Саруул.А, Алтай.Г, *“Чингис хаан хийгээд түүний өв”*, ХБНГУ-ын Урлаг, Үзэсгэлэнгийн Их Танхимд гаргасан “Чингис

⁴https://mn.wikipedia.org/wiki/Санжаадоржийн_Молор-Эрдэнэ

⁵Монголын нэрт орчуулагчид, 28-р тал, Мөнхтэнгэр дэлхийн эв нэгдлийн холбоо, УБ, 2005 он

хаан хийгээд түүний өв – Монголчуудын дэлхийн гүрэн” Бонн 2005.6.16 – 9.25 үзэсгэлэнд зориулж ДААД болон DFG-ээс зохион байгуулж хийлгэсэн бага хурлуудын материал, ДААД болон Германы Судалгааны нийгэмлэг, Монгол Судлалын Төв, МУИС, УБ, 2007 (2 хэлээр, 383 хуудас), БаркманнУдо Б., “Монгол-Германы харилцаа-Өнөөгийн байдал ба хэтийн төлөв” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд, УБ, 2013 (2 хэлээр, 306 хуудас), Исаак Якоб Шмидт, “Монгол хэлний хэлзүй” (орчуулгын зохиол), УБ, 13х.х, орчуулсан Г.Лувсан, Ж.Ариун, М.Одонтуяа, Ц.Доржнямбуу, Г.Эрдэнэ-Наран, Ч.Сэлэнгэмөрөн гэх мэт нэрлэж болно.

Эдгээр эмхэтгэлд монголын хийгээд германы нэр хүнд бүхий монголсудлаачид, тухайлбал, К.Загастер, Х.Г.Хюттель, М.Вайерс, У.Б.Баркманн, Ш.Чоймаа, С.Дулам, Ж.Болдбаатар, Ж.Чимиддорж (Өвөр Монголын Их Сургууль, Хөх Хот, БНХАУ), орчин цагийн эрхзүйчдийн гол төлөөлөл болох Б.Чимид, Г.Совд, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, С.Жанцан, улс төрийн хүчний төлөөллүүд, үүнд, П.Очирбат, Н.Багабанди, С.Батболд, Д.Лүндээжанцан, Б.Батбаяр (Баабар), М.Энхсайхан, Л.Гүндалай, Л.Болд төдийгүй ХБНГУ-ын төрийн дээд албан тушаалтнуудын судалгаа, илтгэл, баяр хүргэж хэлсэн үгс багтаж байна.

Монгол судлаач Удо Баркманн нь МУИС-ын төгсөгч бөгөөд германчууд дундаа өөрчлөлт шинэчлэлийн үеийн “Mongolei-Experte” буюу “монголоор дагнасан судлаач” хэмээн цоллуулдаг олон жилийн туршлага хуримтлуулсан арвин бүтээлтэй эрдэмтэн тул герман хэлний орчуулагч, судлаач бэлтгэн гаргах үйлст хувь нэмэр нь гарцаагүй өндрөөр үнэлэгдэж таарна.

Уран зохиолын орчуулгын талаар герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан анхны уран зохиолын орчуулгыг их зохиолч Д.Нацагдоржийн орчуулсан “Алтан цох” зохиол хэмээн зарим судлаачид үздэг бөгөөд МУИС-ийн багш Г.Эрдэнэнаран 2009 онд хийсэн бүтээлийн судалгаандаа мөн он хүртэл герман хэлнээс монгол хэлрүү орчуулсан нийт 70 орчим бүтээл байгааг, мөн эдгээр орчуулгын зохиолыг герман хэлнээс шууд буюу орос хэлнээс дам орчуулсан байнагээд герман хэлнээс шууд орчуулгыг Д.Нацагдорж, Д.Гонгор, Г.Сосор, Д.Хандмаа, Ч.Галсан, Д.Алтанхуяг, Д.Наваан-Юндэн нарын орчуулагч, зохиолчид хийсэн байна⁶” хэмээжээ. Багш Г.Эрдэнэнаран 2007 он хүртэл хийсэн орчуулгийг үндсэн гурван төрлөөр ангилжээ. Харин энэхүү судалгааны хүрээнд орчуулгын бүтээлийг *үргэлжилсэн үгийн, яруу найргийн, жүжгийн, хүүхдийн уран зохиолын* хэмээн шинээр ангилан түүвэрлэж, тухайн орчуулгын бүтээл хэвлэгдэн гарсан он дарааллын дагуу жагсаан оруулав.

Үргэлжилсэн үгийн зохиолоос 1964 он Петцольд.Ц.И., “Агуу их бүтээл”, орчуулсан Д.Гонгор, редактор Ц.Энэбиш, Хардер.Г., “Нугат хөндийн айлд”,

⁶Герман уран зохиолыг монгол хэл рүү орчуулах уламжлалаас, эрдэм шинжилгээний илтгэл, МУИС, ГХСС, Багш нарын ЭШБХ, УБ, 2007 он

орчуулсан Д.Гонгор, редактор Ш.Очирбат, 1967 он Нойч.Э, “Чулуун мөр”, орчуулсан Д.Гонгор, редактор Ц.Шүгэр, 1968 он Келлерманн.Б, “Далд зам”, орчуулсан Г.Сосор, редактор Ц.Шарав, 1970 он Нойманн К., “Гезине охин”, орчуулсан Д.Хандмаа, 1972 он, Апитц Б., “Араатны дунд гар хоосон”, орчуулсан Д.Хандмаа, редактор Г.Лувсан, Тухольский К., “Бүү хүлээ”, орчуулсан Ч.Галсан, редактор Д.Алтанхуяг, 1974, Петерсен Я., “Урхи”, орчуулсан Х.Гомбо, Улаан-Од, 1974 оны 11 сарын 2, дугаар 88, Манн Х., “Боол”, орчуулсан Г.Сосор, Ч.Галсан, редактор Г.Лувсан, 1976 он, Зегерс А., “Долоо дахь загалмай”, орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 1978 он “Үнэн үнэнээрээ л байх сайхан” (шог өгүүллэг), орчуулсан Ч.Галсан, “Хөдөлмөр”, №46, 1979 он, Зегерс А., “Зэгсэн гуурс” (өгүүллэг), орчуулсан Д.Алтанхуяг, “Цог”, №6, 141-150 тал, Тёрнеквист Г. “Манаач”(шог өгүүллэг), орчуулсан Д.Гонгор, “Хөдөлмөр”, №130, Хардер Г., “Аавтайгаа уулзах хориотой”, орчуулсан А.Цэрэнчулуун, редактор Н.Наваан-Юндэн, Финкер Курт, “1944 оны 7-р сарын 20-ны хуйвалдаан”, орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 1980 он, Вийнер Р., “Хотын зах дахь бяцхан байшин”, орчуулсан А.Алтанхуяг, “Тоншуул”, №12, 1982 он, Вельм А., “Пуговица буюу түлхүүртэй мөнгөн цаг”, орчуулсан Ц.Шарав, редактор Д.Алтанхуяг, УБ, СнХК, 1983 он, Ганс Арнольд, “Бараагаа сурталчилсан нь”, орчуулсан Х.Мэргэн “Цог” №1, 86-ртал, Леонхард.Р, “Хот, дуу хоолой хоёр”, орчуулсан Д.Алтанхуяг, “Утгазохиол, урлаг” №17, 1988 он, Хермлин С., “Үдшийн гэгээ”, орчуулсан Ч.Галсан⁷, Ш.Цогт, Кестнер Э., “Эрхийн чинээ эр”, орчуулсан Д.Хандмаа, редактор Ц.Сүхбаатар, 2002 он, Теодор Эрнст, Амадеус Хоффманн “Самар цөмүүр ба хулганы хаан” орчуулсан Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 2009 он, Штефан Цвайг, “Танихгүй эмэгтэйн захидал”, 2010 он, Н.Лувсандорж, “Geschichten – Үгүүллэгүүд” (2 хэлээр) байхын сацуу 2013 онд бакалаврын төгсөлтийн ажлын хүрээнд МУИС-ийг Герман судлалаар төгсөгч Ц.Мөнхбуянт Гётегийн “Залуу Вертерийн шаналан” романыг орчуулжээ.

Н.Лувсандоржийн “Үгүүллэгүүд” эмхэтгэлийн тухайд “Хэрвээ уран зохиолыг бусдын соёлыг харах цонх хэмээвээс энэхүү түүвэр онцгой юм. ...цаг хугацааны хувьд 200 гаруй жил, сэдвийн хувьд маш өргөн хүрээг хамарч байна. Герман зохиолын хэсэг соён гэгээрүүлэлтийн болоод сонгодог үе (18-р зуунаас 19-р зууны эхэн)-ийн ёгт үлгэр, үгүүллэгээр эхэлж улс төрийн эргэлт ба дахин нэгдсэн 1990 оноос хойших үеийн бүтээлүүдээр төгсөж байна. Монголын үгүүлэхүйн урлагийн төлөөлөл болгож Д.Нацагдорж, С.Эрдэнэ, Л.Түдэв нарын бүтээлийг Ч.Галсангийн орчуулгаар оруулжээ. Чинагийн Галсан бас энэхүү төлөөлөлд орж байна” хэмээн ГЭСА-ны дэмжлэгээр хэвлэгдсэн хоёр дахь түүврийн өмнөх үгийг тэрлэгч Детлеф Гертнер өгүүлжээ⁸. Эмхэтгэлд *Готтхолд Еффраим Лессингийн 5, Йоханн Вольфганг фон Гётегийн 1, Йоханн Петер Хебелын 2, Хайнрих фон Клайстын 1, Роберт Валзерын 1, Альфред Дёблиний 1,*

⁷ Geschichten-Үгүүллэгүүд, 6-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2010 он

⁸ Gedichte-Шүлгүүд, 5-р тал, БИТ ПРЕСС ХХК, 2009 он

Франц Кафкагийн 2, Вольфганг Хилдесхаймерын 1, Ервин Штриттматтерын 1, Хайнрих Бөллийн 1, Дийтер Хилдебрандтын 1, Эрих Көөлерын 1, Ирмтрауд Моргнерын 1, Хеннинг Фенскегийн 1, Моника Зек-Агтегийн 1 өгүүллэг, тэрчлэн, Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс”, С.Эрдэнэ “Малын хөлийн тоос”, Л.Түдэв “Багтай танилцсан минь”, Ч.Галсан “Die Tiwa sagen”, “Тетро” өгүүллэгүүд багтсан байна.

Яруу найргийн бүтээлд Д.Алтанхуягийн орчуулсан Кирш Райнер “Лилиягийн домог”, “Чи бид”, Утга зохиол урлаг, 1974 оны 9 сарын 27, дугаар 40, Хайне Х., “Герман орон (Өвлийн нэгэн үлгэр)”, редактор Б.Бирваа, УБ., УХК, 1978, 79-р тал, Шайбнер.Э., “Малчны хүү буюу тэмээ унах нь”, “Утга зохиол урлаг”, 1980 оны 9 сарын 9, №37, Георг Маурер, “Амраг минь чи жаахан хүлээ!”, “Утга зохиол, урлаг” 1981 оны 4-р сарын 17, №16, Нето А., “Шүлгүүд”, редактор Б.Пүрэвбаатар, Ева Штриттматтер, “Чамдаа”, “Утгазохиол, урлаг” 1982, 10-р сарын 8, №41, Бартш К., “Яруу найраг”, “Утга зохиол, урлаг”, 1983 оны 4 сарын 22, №17, Трампе В., “Өршөөл гуйхгүй”, “Утгазохиол, урлаг”, 1983 оны 4-р сарын 22, №17, Фуйман Ф., “Нибелунгуудын тухай дуулал”, редактор З.Түмэнжаргал, УБ, СнХК, 1983, 134-р тал, Курт Барч, “Төрд падгүй нэгэн хүнд зориулсан оршлын бичээс”, “Утга зохиол, урлаг”, 1984 оны 10-р сарын 5, №41, Курт Барч, “Үүд”, “Утга зохиол, урлаг” 1984 оны 10-р сарын 5, №41 болно. 2009 онд Н.Лувсандорж “*Gedichte-Шүлгүүд*” хэмээх бүтээлийг дуун хөрвүүлж, эмхэтгэсэн нь герман хэл суралцагсдад чамгүй үнэтэй гарын авлага болсон нь дамжиггүй. Намжилдоржийн Лувсандоржын “Шүлгүүд” эмхэтгэлийн тухайд Н.Лувсандорж шүлгүүдийг шилж сонгон, нилээд хэсгийг орчуулсан байна. Тэрээр Ц.Дамдинсүрэн, Н.Наваан-Юндэн, С.Доржпалам, Б.Бааст, Б.Явуухулан, Д.Чимэддорж, Ц.Хасбаатар, М.Ширчинсүрэн, Г.Алтай, Ч.Галсан нар герман болон орос хэлнээс урьд өмнө орчуулж энд тэнд тарж тархсан болон хэвлэгдээд олдохгүй болсон шүлгүүдийг цуглуулан эмхэтгэжээ. Үүнээс гадна, огт нийтлэгдэж байгаагүй Шиллерийн “Амьдрал хэмээх жүжиг” (Ч.Мөнхөөгийн орчуулга) болон Ч.Галсангийн шүлгүүдийг (А.Цэрэнчулууны орчуулга) мөн хамруулан оруулжээ. Хөлдөрлиний зарим шүлгүүд Ч.Галсангийн орчуулгаар анх удаа нийтлэгдэж байгаад бид баяртай байна. Бас Д.Нацагдоржийн шүлгүүдээс Ч.Галсан, Г.Алтай, Н.Лувсандорж нар орчуулсан нь энд содон байна”⁹ хэмээн номын оршил хэсэгт уг бүтээл төрөхөд чамгүй хувь нэмрийг оруулсан тухайн үеийн ГЭСА-ны багш Детлеф Гэртнер тэмдэглэсэн байна. Уг бүтээлд Гётегийн 51 шүлэг, Шиллерийн 18 шүлэг, Хөлдөрлиний 10 шүлэг, Хайнегийн 43 шүлэг, Д.Нацагдоржийн 8 шүлэг, Ч. Галсангийн 6 шүлэг орчуулгын хамт багтжээ.

Жүжгийн зохиол бүтээлийн тухайд Монсудар хэвлэлийн газраас 2007 оноос эхлүүлэн дэлхийн сонгодог уран зохиол, шинэ үеийн уран зохиолуудаас

⁹ Ариун Жадамбын, Герман-монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй УНӨ-ийн зэрэгцүүлсэн судалгаа, дисс., 136-167 тал, УБ, 2004 он

сорчлон түүвэрлэж орчуулан хүргэх ажил амжилттай хэрэгжиж буйн хүрээнд 2009 онд “*Фауст*” жүжгийн зохиолын энэ удаагийн орчуулгын хувилбар гарсан байна. Энэхүү бүтээлийг герман хэлнээс С.Батбилиг орчуулсан байна. Йоханн Вольфганг фон Гёте энэхүү зохиолоо 1770 онд эхлүүлэн 1833 онд хэвлэлтэнд шилжүүлэн 60 жилийг зориулсан байна.

Хүүхдийн уран зохиолоос герман хэлнээс орчуулсан 1990-ээд оны өмнөх хүүхдийн зохиол, тэр дундаа үлгэрүүд ахин шинээр хэвлэгджээ. Эдгээрээс ах дүү Гриммийн болоод В.Гауфийн үлгэрүүд нилээдгүй багтсан байна.

Герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан Ах дүү Гриммийн “*Чөтгөр ба түүний эмээ*”, Рудольф Эрих Распэ “*Мянгуужингийн адал явдал*”, Отфрид Пройслер “*Бяцхан шулам*”, Феликс Залтен “*Бэмби ба ойн амьдрал*” зэрэг бүтээлүүд нь сүүлийн жилүүдэд манай нэрт орчуулагчдын эмхэтгэн, орчуулж гаргасан “Хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан 108 боть”-д багтжээ. Эдгээр бүтээлүүд нь австри, германы хүүхдийн сонгодог зохиолчдын туурвил бөгөөд тэдний энэхүү үнэт зохиолууд дэлхийн хүүхдийн уран зохиолын сонгодог бүтээлд багтдаг байна.

Сүүлийн үед герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан хүүхдийн зохиолуудыг авч үзвэл жилд дунджаар 1-2 зохиол хүүхдийн гар дээр очдог гэсэн албан бус статистик баримт байна.

Германы алдарт зохиолч Михайл Эндегийн “*Момо*” хэмээх хүүхдийн бүтээлийг герман хэлнээс монгол хэл рүү залуу орчуулагч Х.Хулан, Швейцарын утга зохиолын хамгийн шилдэг номоор шалгарсан, өнгөрсөн зууны дэлхийн хүүхдийн уран зохиолын хамгийн шилдэг 10 бүтээлийн тоонд зүй ёсоор орох Ж.Спайрийн “*Хэйди охин*”-ыг бүрэн эхээс нь монгол хэл рүү орчуулагч Г.Ариунцэцэг орчуулжээ. Үүний зэрэгцээ 1973 он “*Амтат будаа*” (Герман ардын үлгэр), орчуулагч Ч.Сэрээнэндорж, “*Тиль Ойленшпигелийн адал явдал*”, орчуулсан Ч.Галсан, “*Таван хуруу*” герман ардын үлгэр, орчуулсан Г.Ловор, “*Газар газрын үлгэр*”, 1974 он, Штриттматтер Э., “*Педро хэмээх одой азарга*”, орчуулсан Ч.Галсан, редактор Г.Лувсан, Эрих Кестнер, “*Эрхийн чинээ эр*”, орчуулсан Д.Хандмаа, редактор Ц.Сүхбаатар, 1976 он, Распе Э., “*Мянгуужинд тохиолдсон явдлууд*”, редактор Б.Мягмаржав, Теодор Эрнст, Амадеус Хоффманн, “*Самар цөмүүр ба хулганы хаан*”, орчуулагч Д.Хандмаа, редактор Д.Алтанхуяг, 2015 онд бакалаврын төгсөлтийн ажлын хүрээнд МУИС-ийн Герман судлалын ангийн суралцагч Ц.Энхмөрөн Эрих Кестнерийн “*Emil und die Detektive*” буюу “*Эмиль мөрдөгч болсон нь*” хүүхдийн романыг орчуулжээ.

Герман хэлнээ орчуулсан монгол зохиолын хувьд 2002 онд МУИС-ын 60 жилийн ой, Олон улсын монголч эрдэмтдийн VIII их хуралд зориулан МУ-ын гавьяат багш агсан, доктор Гэндэний Лувсан болон доктор С.Алимаа нарын хэвлүүлсэн “Германы монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт”-ыг нэрлүүштэй. 239 хуудас бүхий уг бүтээлд монгол судлалын талаар дагнан

мэргэжсэн 35 судлаач, эрдэмтдийн бүтээлийг цагаан толгойн дэсээр жагсаан харуулсан байна. Монгол-герман орчуулгын бүтээлийн орчин цагийн содон жишээ гэвэл Тавдугаар гэгээн ноён хутагт Данзанравжаагийн “Саран хөхөөний намтар” дуулалт жүжгийн орчуулга болох *Fünfte Noyan Khutukhtu Danzanrabjai, Das Leben des Mondkuckuck, aus dem Mongolischen* Petra Szemacha, ZDM PRINTING in Ulaanbaatar, 2008 юм. Бүтээлийг Лайпцигийн Их Сургуулийн доктор Petra Szemacha орчуулсан бөгөөд 2002-2003 онд МУИС-д монгол хэл судалж байсан бөгөөд түүний дипломын ажлын сэдэв нь “Тавдугаар Гэгээн ноён Хутагт Данзанравжаа. Саран Хөхөө. Шашины уламжлал хийгээд урлагийн бүтээлч сэтгэлгээ” ажээ. Монгол-герман орчуулгын бүтээлийг <https://de.wikipedia.org/wiki> сайтаас хайлт хийн хавсралтаар оруулав. (Хавсралт 1)

Дүгнэлт

- Социализмын үед монгол хэлнээ орчуулсан зохиолуудын дийлэнх нь нийгэм- улс төрийн үзэл сурталжсан чиг хандлагатай байна. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш БНАГУ-ын зохиолчдын бүтээлийг нэн тэргүүнд сонгон орчуулдаг байжээ.
- Орчин цагийн орчуулгын бүтээл агуулгын хувьд баяжин, дан ганц уран зохиолын орчуулгаар үл хязгаарлагдан философи, түүх, соёл, эдийн засаг, эрхзүй зэрэг өргөн хүрээг хамрах болсон нь нэн сайшаалтай.
Төвд хэлнээс ном судар орчуулж байсан эхэн үед харь үгийг аль болох орчуулах, төвд үгийг хуулбарлан авах бус, харин санскритаар сэргээн орчуулж байсан онцлогтой. Энэ нь тухайн үед буддын шашны ном зохиолыг орчуулахад уйгарын орчуулгын нөлөө хүчтэй хэвээрээ байсныг илтгэн харуулна. Тухайн

¹⁷ Ц.Дамдинсүрэн, Два колофона монгольской книги “Золотой блеск”, - Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 164.

¹⁸ “Банзрагч”-ийг Чойжи-Одсэр орчуулсан эсэх талаар судлаачид санал зөрж байна. Харин төвд, монгол сурвалж бичгийн мэдээнд орчуулсан гэж тэмдэглэсэн буй.

үед буддын шашин, буддын утга зохиолын нэр томъёоны орчуулга нэг мөр болж хэвшин тогтоогүй, санскрит үг хэллэг зонхилж байсан билээ¹⁹.

16-18 дугаар зууны үед төвд хэлнээс ном судар орчуулах үйл далайцтай өрнөсөн байна. Энэ үед Хөх хотын Ширээт гүүш, харчины Аюуш гүүш, халхын Алтангэрэл увш, ойрадын Зая бандид Намхайжамц нарын зэрэг нэртэй орчуулагчид бүтээлээ туурвиж байв. Орчуулгын сэдвийн тухайд авч үзвэл шашин гүн ухааны ном судраас гадна түүх, уран зохиол буюу иргэний чиглэлийн ном судрыг орчуулж байжээ. Энэ үеийн орчуулгын томоохон төлөөлөгчийн нэг болох Ширээт гүүш цорж өмнөх үеийн уран яруу орчуулгын өвийг уламжлан авч, монгол хаад ноёд, хатдын дуртгаснаар олон сайхан орчуулгаа туурвижээ²⁰. Харчины Аюуш гүүш бол нэртэй орчуулагч²¹ байснаас гадна али-гали хэмээх санскрит, төвд үгийг галиглах монгол үсгийн тогтолцоог боловсруулж, харь гаралтай үгийг хөрвүүлэн асуудлыг шийдсэн юм. Монголчуудын дунд дэлгэрч нийт ард түмний шүтээн төдийгүй хүртээмж болсон олон хөлгөн судрыг халхын Алтангэрэл увш²² орчуулсан нь сонгодог бичгийн өмнөх үеийн монгол хэлний дурсгалыг судлах чухал хэрэглэгдэхүүн болохоос гадна төв халхын орчуулгын дэгийг судлахад ч ач холбогдолтой. Энэ үеийн орчуулгын томоохон төлөөлөгчийн нэг болох ойрадын Зая бандид Намхайжамц шавь нарын хамт 200 гаруй ном судрыг орчуулсан нь тод бичгээр уламжилж ирснийг онцлон дурдах ёстой²³. Зая бандид Намхайжамцын орчуулга нь төвд нэр томъёог санскритаар сэргээх уламжлалт орчуулгын аргыг баримтлаагүй, харин төвдүүдийн санскрит нэр томъёог зээлж авах бус, орчуулдаг уламжлалыг даган мөрджээ. Өөрөөр хэлбэл, төвд орчуулгын дэгийг чанд баримталсан гэж хэлж болно. Энэ нь Зая бандид Намхайжамцын шашин номын үзэлтэй холбоотойгоос гадна “үгчилсэн орчуулгын зарчмыг тогтоосон” тухайд онцлог юм²⁴.

Энэ үеийн орчуулгын нэг томоохон ололт бол 13-14 дүгээр зуунаас эхэлсэн төвд Ганжуур, Данжуурын орчуулгыг эцэслэн дуусгаж, хянан тохиолдуулж барласан явдал юм. Энэтхэгийн санскрит болон пали хэлээр уламжилж ирсэн буддын утга зохиолын дурсгалыг төвдүүд эмхтгэж Ганжуур, Данжуур хэмээн нэрлэсэн билээ. Ганжуур гэдэг бол зарлигийн орчуулга хэмээсэн утгатай төвд үг бөгөөд Бурхан багшийн зарлиг сургаалын эмхтгэл юм. Түүнд энэтхэгийн аман зохиолын үлгэр домог, адилтгал зүйрлийг ашиглан

¹⁹ Д.Бүрнээ, “Үлгэрийн далай”-н монгол орчуулгуудыг хэлшинжлэлийн үүднээс харьцуулах нь,- Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт орчуулгын судлалд, УБ., 2003, 9.

²⁰ Д.Бүрнээ, “Үлгэрийн далай”-н монгол орчуулгуудыг хэлшинжлэлийн үүднээс харьцуулах нь,- Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт орчуулгын судлалд, УБ., 2003, 35-51.

²¹ Д.Бүрнээ, Ганжуурыг орчуулахад Аюуш гүүшийн оруулсан хувь нэмэр, Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Ulaanbaatar, 2007, Vol.7 (291), pp.149-155.

²² Ц.Дамдинсүрэн, ХҮП зууны үеийн орчуулагч Алтангэрэл увшийн тухай зарим мэдээ, - Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 117-125.

²³ Х.Лувсанбалдан, Тод үсгийн дурсгалууд, УБ., 1975, 125-128.

²⁴ Л.Хүрэлбаатар, Орчуулгын товчоон /сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд/, УБ., 1995, 61.

тайлбарласан буддын шашин гүн ухааны агуулгатай олон түүх цадиг багтан орсон учир буддын утга зохиолын дээж бичиг гэж үзэж болно. Төвд Ганжуурыг Лигдэн хааны зарлигаар монгол хэлнээ орчуулахад хэдэн хэлмэрч гүүш оролцсон тухай Дарма гүүшийн бичсэн "Алтан хүрдэн мянган хигээст" хэмээх сударт тэмдэглэжээ. Түүнийг иш татвал "...Гунгаа-Одсэр хэлмэрч эхлэн гучин гурван гүүш нараар Ганжуурыг монгол хэлэнд орчуулан алтаар бичвэй" гэсэн байна²⁵. Түүнээс гадна Ганжуурын төгсгөлийн үгд 50 гаруй хэлмэрч гүүш оролцсон тухай тэмдэглэжээ²⁶. Ганжуурыг Алтан хааны үед буюу 1602-1607 оны хооронд анх бүрэн орчуулж дуусаад, 1628-1629 онд ариутган шүүж, 1717-1720 онд хэвлэхэд урьд орчуулсан олон хүний нэрийг дурдаагүй орхижээ. Тийнхүү нэр дурдаагүй орчуулагчдийг олж мэдэхэд монгол бичмэл Ганжуур бидэнд тус болж байна. Тухайлбал, манай нийслэл хотын Үндэстний номын санд хадгалагдаж буй бүрэн бус бичмэл Ганжуурын 25 зохиолын төгсгөлийн үгээс бид хэлмэрчийн нэрийг мэдэж авч байгаа билээ²⁷. Нөгөөтэйгүүр, Ганжуурын зарим орчуулагчийн нэргүй зохиолыг тухайн зохиолын нийтэд дэлгэрсэн гар бичмэл эхээс тодруулсан туршлагыг ч бид анхаарч үзэх нь чухал юм²⁸.

Ганжуурыг орчуулахад Аюуш Ананд, Ширээт гүүш, Гунгаа-Одсэр, Дархан лам Самдансэнгэ, Шаравсэнгэ нарын зэрэг олон гүүш оролцжээ. Ганжуурыг орчуулахаас гадна хэвийг бүтээх, ариутган шүүх, хуулан бичихэд 129 хүн оролцсон байна²⁹.

1000 гаруй ном судрыг багтаасан төвд Ганжуурын орчуулгыг хэвлэхийн өмнө ариутган шүүсэн нь нарийн учиртай ажээ. Ганжуурын орчуулга бүр 13-14 дүгээр зуунаас эхэлсэн түүхтэй. Тиймээс хуучны олон зохиолыг багтаасан, нөгөөтэйгүүр олон үеийн орчуулагчийн барьж орчуулсан төвд эх судар нэгэнт устаж олдохгүй болсон, газар газрын орчуулагчийн хэл найруулга өөр өөр байсан зэрэг нь Ганжуурыг ариутган шүүхэд ихээхэн бэрхшээл учруулсан ажээ. Тиймээс хянан тохиолдуулахын тулд юуны өмнө тодорхой арга зарчмыг тогтоож түүнийгээ даган мөрдөх шаардлага тулгарсан байна. Хамгийн гол асуудал бол ямар төвд эхийг барьж засах тухай асуудал байсан болов уу. Ямар ч

²⁵ Дарма гүүш, Алтан хүрдэн мянган хигээст, монгол бичгээс хөрвүүлж оршил тайлбар, хавсралт хийсэн Т.Жамъянсүрэн, Л.Халиун, УБ., 2006, 86.

²⁶ Ш.Чоймаа, Ганжуур, Данжуур хийгээд монгол орчуулга, түүнийг судлахын ач тус,- Билгийн гэгээ, Ганжуур, Данжуурын судалгаа, эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал, 2013, 22; Ч. Хишигтогтох, Монголын эртний утга зохиолын шинэ судлал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998, 381 /монгол бичгээр/.

²⁷ Д.Бүрнээ, Үндэсний номын сангийн монгол бичмэл Ганжуурын төгсгөлийн үгээс орчуулагчийг тодруулах нь, Олон улсын монголч эрдэмтэдийн X их хурлын илтгэлүүд, II боть, Монгол хэл соёлын тулгамдсан асуудлууд, УБ., 2012, 45-47.

²⁸ Монголчуудын дунд "Үлгэрийн далай" хэмээн алдаршсан зохиолыг Хөх хотын Ширээт гүүш орчуулсан болохыг ОХУ-д хадгалагдаж буй гар бичмэл судрын төгсгөлийн үгээс Б.Я.Владимирцов тодруулсан билээ.

²⁹ Ч.Хишигтогтох, Монголын эртний утга зохиолын шинэ судлал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998; Catalogue du Kanjur Mongol Impime, par Louis Ligeti, Budapest, 1942-44, 342.

байсан Бээжин барын төвд Ганжуурыг баримталж зассан байх бөгөөд ийнхүү засахдаа хуучин орчуулгыг хэл найруулгын талаас нэлээд өөрчлөн засахад хүрсэн нь тухайн орчуулгын төгсгөлд орчуулагчийн нэрийг хүртэл бичилгүй орхиход хүргэсэн байж болзошгүй³⁰. Ганжуурын зарим зохиолын монгол орчуулгыг тус зохиолын хамгийн анхны орчуулга гэж үзэхэд түвэгтэй тул тухайн орчуулгын бичмэл, дармал хуулбар, хувилбар зэрэг олон эхийг харьцуулан үзэж, анхны эх мөн эсэх, биш бол анхны эхээс хэр зэрэг өөр болсон буюу хөгжил хувьслын түүхийг ажиглах боломжтой. Төвд хэлнээс ном судар орчуулахад зориулж орчуулгын толь болох даяг буюу дохионы бичиг, ариун бичиг буюу даг-ег хэмээх зүйл хуваасан толь бичиг, дүймин хэмээх түүвэр нэрийн толь буюу хатуу үгийн толь, дадол буюу бэрх үгийн толь тэргүүтэн толь бичиг³¹ гарсан ч нэр томъёоны тусгай толь бичиг, гарын авлага байгаагүй учир Ганжуурын орчуулгууд үг хэллэгийн хувьд ялгаа зөрөөтэй болсон ч ямар нэг хэмжээгээр төвд хэлнээс монгол хэлнээ орчуулах арга барил, дадлага туршлага хэрхэн хуримтлагдаж байсныг судлах чухал хэрэглэгдэхүүн болж чадах юм³².

Данжуур гэдэг бол шастирын орчуулга хэмээсэн утгатай төвд үг бөгөөд дуун ухаан, тэжээхүй ухаан, урлахуй ухаан, учир шалтгааны ухаан, дотоод ухаан зэрэг их таван ухаан, одон зурхай, зохист аялгуу, илт өгүүлэхүй, эвсүүлэн найруулах, дуурайн бүжиг зэрэг бага таван ухааны 3000 гаруй ном зохиолыг багтаасан буддын утга зохиолын их цоморлиг юм. Түүнийг орчуулахад олон эрдэм ухааны нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоох шаардлага тулгарсан учир энэ зорилгод нийцүүлэн "Мэргэд гарахын орон" нэрт толь бичгийг зохиосон байна. Тус толь бичгийн оршилд төвд хэлнээс монгол хэлнээ ном судар орчуулах арга зарчим тухайлбал үгсийн сан, хэлзүйн орчуулгын онолын асуудал, орчуулгын хувиргалын тухай товч өгүүлэхээс гадна орчуулагчийн ёс зүйтэй холбоотой асуудал, уран сайхны орчуулгын тухай, шүлгэлсэн ба үргэлжилсэн үгийн орчуулгын онцлог, орчуулгын зорилго, үнэн зөв орчуулахын ач тус, буруу зөрүү орчуулахын гэм хор, орчуулагч хүний наад захын баримтлах ёс журмын талаар өгүүлэхээс гадна учир шалтгааны ухаан, билиг барамид, мадхьямика, авидарма, винай, тарнийн аймгийн нэр томъёо болон дуун ухаан, урлахуй ухаан, тэжээх ухааны нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоосон байна³³.

³⁰ Л.Хүрэлбаатар, Судар шастирын билиг, УБ., 2002, 73; Д.Бүрнээ, Монгол Ганжуурыг ариутган зассан тухай асуудалд, Монгол судлал, ЭШБ, боть XXXVII (392), УБ, 2013, 153-157.

³¹ Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний толь зүйн уламжлал,- Толь бичгийн судлал, Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, УБ., 1986, 194-196; A review of the Tibetan-Mongolian lexicographical tradition, The Mongolia-Tibet interface, PIATS 2003: Tibetan Studies, Proceedings of the Tenth Seminar of the International Association for Tibetan Studies, Oxford, 2003, Managing editor: Charles Ramble. pp.371-379.

³² Д.Бүрнээ, Ширээт гүүш юмын судрыг орчуулсан тухай, Лам нарын сэтгүүл, 12 сар, №3, 2010, 115-118.

³³ "Мэргэд гарахын орон" толь бичиг дэх орчуулгын онолын холбоотой хэсгийг бүрэн эхээр нь монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн хэвлүүлсэн билээ. Үз.: Д.Бүрнээ, Д.Энхтөр "Уламжлалт орчуулгын асуудалд", УБ., 2003, 300-303.

Данжуурыг орчуулж эхэлсэн нь 13-14 дүгээр зуун бөгөөд 1742-1749 оны хооронд нэгэнт бэлэн байсан хуучин орчуулга дээр шинэ тутам орчуулсан орчуулгыг нэмж, засан найруулж хэвлүүлсэн байна. Данжуурыг орчуулахад Авгын Дай гүүш Агваандампил, гүүш Лувсанлүгдэн, Халхын гүүш Гэлэгжалцан, гүүш Рашижамц, Рагу хутагтын хувилгаан Лувсанчүлтэм нарын зэрэг 200 гаруй алдарт гүүш оролцжээ. Данжуурын орчуулга нь монголын сонгодог бичгийн хэлний орчуулга, түүний дотор утга зохиолын хэм хэмжээ, нэр томъёо зэргийг тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн байна³⁴. 108 боть Ганжуур, 225 боть Данжуурын 5000 гаруй зохиолыг багтаасан буддын утга зохиолын цоморлигийг орчуулсан нь монгол орчуулгын түүх, соёлын амьдралд гарсан томоохон үйл явдал болсон юм.

Ганжуур, Данжуурын орчуулга бол санскрит хятад хэлээр уламжилж ирсэн буддын утга зохиолын төвд орчуулга бөгөөд монголчууд тэрхүү төвд орчуулгаас дам монгол хэлнээ орчуулсан хэрэг юм. Тэгвэл монголчууд төвд утга зохиолыг бас шимтэн уншиж, “Гэсэрийн тууж”, “Үлгэрийн ном”, “Милын намтар”, “Милын буман дуулал”, “Бадмагатан”, “Гатан дэн-а”, “Цагаан лянхуан баглаа”, түүний тайлбар, “Субашид” болон түүний тайлбар, “Шидэт хүүрийн үлгэр” зэрэг төвд ардын аман зохиол, уран зохиолыг эх хэлнээ орчуулжээ³⁵. “Мааньгамбум”-ыг Зая бандид Намхайжамц, Авгын Цүлтэмлодой нар, “Субашид”-ийн тайлбарыг Цахар гэвш Лувсанчүлтэм, Номтын Ринчен, “Молон тойны эхийн ач хариулсан судар”-ыг Ширээт гүүш, Сөнөдийн Дамбадаржаа гүүш, Халхын Алтангэрэл увш, Зая бандидын шавь Цүлтэмжамц нар орчуулжээ. Түүнээс гадна монголчуудын дунд нэрд гарсан зохиолыг олонтаа орчуулж байжээ. Тухайлбал, Сажа бандид Гунгаажалцангийн зохиосон “Субашид” хэмээх иргэний яруу найргийн зохиол, монголчуудын шашин номын шүтээн болсон “Жадамба” буюу “Найман мянгат” хэмээх зохиолын арав орчим орчуулгыг дурдаж болно. Нэг зохиолын ийнхүү олон орчуулга гарсан нь монголын нүүдлийн аж амьдралтай холбоотой, өөрөөр хэлбэл хэн, хаана ямар ном орчуулж буй талаар мэдэх боломж муутай байснаас үүдэлтэй, мөн тухайн орчуулгыг цаг үеийнхээ хэл найруулгад ойртуулан дахин шинээр орчуулах эрэлт хэрэгцээ байсантай ч холбоотой болов уу. Ямар ч атугай нэг зохиолын олон орчуулга гарсан нь орчуулгын хэл найруулгын хөгжил хувьсал, монгол орчуулгын түүхийг судлахад бас чухал баримт болох юм.

Төвд хэлнээс ном судар орчуулах үйлсэд төв халх, өвөрлөгчид, ойрад, буриад зон олон бүгд оролцож, өөр өөрсдийн орчуулгын арга дэгийг буй болгосон байна³⁶. Өмнө дурдсан Зая бандид Намхайжамц болон түүний шавь нарын төвд эхийн хэлзүйг буулгах үгчлэн орчуулах дэгээс гадна буриадын Агын

³⁴ Ш.Чоймаа, Ганжуур, Данжуур хийгээд монгол орчуулга, түүнийг судлахын ач тус,- Билгийн гэгээ, Ганжуур, Данжуурын судалгаа, эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал, 2013, 25.

³⁵ Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм II, УБ., 1976, 500-504.

³⁶ Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон /сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудал/, УБ., 1995, 121.

аймгийн Дэлгэрийн Галсанжамба, Хорын аймгийн Номтын Ринчен хэмээн алдаршсан Лувсанринчен, Агваанлэгшид, Онон Цүүгэл дацангийн ширээт Төгөлдөрийн Галсанжамба нарын зэрэг буриадын эрдэмтэн гүүш нарын орчуулга “толгой тэгшлэн орчуулах зарчим”-ыг баримталсан бие даасан дэг сургууль байсныг Л.Хүрэлбаатар дурджээ³⁷.

Төвд-монгол орчуулгын түүх, ялангуяа иргэний номын орчуулгын түүхэнд гарсан нэг онцгой үйл явдал бол Цахар гэвшийн /1740-1810/ орчуулга юм. Түүний бүтээл өмнөх үеийн Шаравсэнгэ /13-14 зуун/, Агваандампил /1700-1780/ нарын орчуулгын уламжлалыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ харийн соёлыг монгол хөрсөнд буулган идээшүүлсэн, жинхэнэ уран сайхан орчуулгын хувьд онцлон тэмдэглүүштэй. Түүний “Субашид”-ийн орчуулгыг өмнөх үеийн болон хожуу үеийн орчуулгуудтай харьцуулбал төвд эхийн хэлбэрт огт баригдаагүй, төвд шүлгийн хэлбэрийг монгол шүлэгчийн чөлөөт сэтгэмжээр ургуулан бодож буулгасан утга төгс уран яруу орчуулга болсон билээ. Тиймээс ч тус орчуулгыг эрдэмтэн Ц.Дамдинсүрэн³⁸ төвд эхийн санааг нэмэн дэлгэрүүлж баяжуулсан, бас шашны утга санааг иргэншүүлсэн, Л.Хүрэлбаатар төвд эхийн санааг авч дуурайлган зохиосон шинжтэй болохыг онцлон тэмдэглэсэн хэрэг юм.

Төвд-монгол орчуулгын түүхэнд аман орчуулгын уламжлал байсныг бас онцлон дурдах ёстой. Энэ нь аливаа төвд номын орчуулгыг цээжээрээ дуудаж хэлдэг, аман бичгийн сонгодог орчуулга юм. Энэ төрлийн орчуулга сургаалын зохиолоос гадна эрдэм ухааны бусад салбар тухайлбал, уран зохиол, тэжээх ухаан, одон зурхай, яруу найргийн онолын хүрээнд ч гарч байсан байна. Аман орчуулга бол судрын орчуулгаас ялгаатай, нийт ард олонд хүртээмжтэй, ойлгомжтой, бас уран яруу орчуулга байсан бөгөөд түүнийг багшаас шавьд амаар уламжлан өвлүүлж байжээ. Төвд хэлнээс орчуулсан номын дийлэнх нь шашин номын агуулгатай, төвд эхийн хэлбэрийг буулгасан үгчилсэн орчуулга байсан бөгөөд тэрхүү орчуулгыг судрын орчуулга ч гэж нэрлэж заншсан билээ.

19 дүгээр зууны сүүл 20 дугаар зууны эхэн үеийн төвд монгол орчуулгын түүхэнд С.Шагж /1886-1938/, Ц.Дорж нарын орчуулгыг онцлон дурдах хэрэгтэй. Ардын хувьсгалын дараа байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн төвд үсгийн орчуулагч, хожим нь Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, “Монгол үгийн тайлбар толь” болон “Эрэхүй хялбар болгон зохиосон үгийн тайлбар чандманийн эрих”, “Монгол бичиг сурах дөт зам” хэмээх сурах бичиг зохиосон С.Шагж төвд хэлнээс хэд хэдэн ном орчуулжээ. Тэр бээр Их Хүрээний хамба Агваанхайдавын “Хонь, ямаа, үхэр гурвын яриа”, Зая бандид Лувсанпэрэнлэйн зохиосон “Өндөр гэгээний намтар”-аас гадна Туган Лувсанчойжинямын /1737-1802/ “Шэлжи мэлон” хэмээх буддын шашин гүн ухааны онолын чанартай алдартай зохиолыг орчуулсан юм. Энэхүү зохиолыг

³⁷ Мөн тэнд, 129.

³⁸ Ц.Дамдинсүрэн, О некоторых особенностях деятельности Чахар-гэвши,- Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 142-147.

гадаадын олон эрдэмтэн судалж өндрөөр үнэлж, тус зохиолоос англи, орос, герман зэрэг хэлнээ хэсэглэн орчуулсан³⁹ бол эрдэмтэн С.Шагж тус зохиолыг эх хэлнээ бүрэн орчуулсан нь манай Үндэстний номын санд хадгалагдаж байна⁴⁰. Тус орчуулгад төвд үг олон орсон байдаг нь тухайн цаг үеийн онцлогтой холбоотой. Энэ үе бол манай оронд шарын шашны сүм хийдийн нийгмийн үүрэг, нэр нөлөө их байсан, хүрээ хийдийн газар лам нар нэг дор төвлөрөн сууж, хэл яриандаа төвд үг олноор оруулж ярьж байсан нь бичгийн хэлэнд нэвтрэн орсон байна. Тиймээс ч “Алтангэрэл”, “Сундуй”, “Банзрагч”-ийг уншихад тааралддаггүй төвд үг шинэ үеийн зохиолчид болох Д.Нацагдорж, Д.Намдаг нарын зохиолд тааралдаж байна гэж эрдэмтэн Ц.Дамдинсүрэн бичжээ⁴¹. Түүнээс гадна манай Үндэстний номын санд С.Шагжийн бас нэг өөр зохиолын орчуулга хадгалагдаж байна. Энэ нь “Номын богд цогт их Гамбобагийн тууж чандмань эрдэнэ бүхнээ түгээмэл яруу банжид нирваан эрдэнийн дээд чимэг” хэмээх зохиол юм. Гамбоба /1079- 1153/ бол төвдийн алдарт яруу найрагч Мила богдын /1040-1123/ шавь байжээ. Тус орчуулгын төгсгөлд “... хэмээсэн үүнийг Монгол улсын Олноо өргөгдсөний дөрөвдүгээр он хөх хулгана жилийн цагаан сарын шинийн сайн өдөр нийслэл Их Хүрээний газраа өтөл хуврагийн дүрст Шагж хэмээх бээр төвдөөс монгол үсэгт орчуулан бичиж төгсгөв”⁴² гэсэн бол “Болорын толь” орчуулгынхаа төгсгөлд “...хэмээх үүнийг Монгол Ардын намын судар бичгийн хүрээлэнгийн төвд орчуулагчийн хүнд нэрийг хүлээсэн хуврагийн дүрст Шагж хэмээх бээр арван тавдугаар машид гарсны модон хулгана жилийн мэргэшир сарын арван тавнаа төгсгөн орчуулав” гэжээ. Түүнээс гадна төвдийн алдарт даяанч эмэгтэй Мажиг Лавдонмаагийн /1055-1143/ намтрыг бас орчуулжээ.

МУИС-ийн төвд хэлний багшаар ажиллаж байсан Ц.Доржийн орчуулгаас бидэнд мэдэгдэж буй нь Зава Дамдины түүхийн сэдвээр бичсэн “Сэржи дэвтэр” буюу "Алтан дэвтэр" хэмээх томоохон хэмжээний түүхэн шастир болон түүний хураангуй болох “Өлзийт лавай мөшөөсөн дуун” хэмээх судрын орчуулга болно⁴³.

1937-1938 оны хэлмэгдүүлэлтийн үеэр эрдэмтэн лам нарыг олноор хороож, монголын оюуны соёлд ихээхэн гарз хохирол болж төвд-монгол орчуулгын түүхэнд ч зогсонги үе болсон билээ. Харин 1950 он гарсаар дэлхий дахинд

³⁹ Туган Лувсанчойжиням, Болорын толь, орчуулсан С.Шагж, монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн, оршил тайлбар, үгийн хэлхээс хийсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, УБ., 2006, 9.

⁴⁰ Лувсанчойжиням, Болорын толь, төвд хэлнээс орчуулсан С.Шагж, монгол бичгээс хөрвүүлэн, оршил, тайлбар бичсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, УБ., 2006.

⁴¹ Ц.Дамдинсүрэн, Монгол хэлэнд орсон төвд үгс,- Монгол хэлэнд орсон санскрит, төвд үг, УБ., 2007, 112.

⁴² Номын богд цогт их Гамбобагийн тууж чандмань эрдэнэ бүхнээ түгээмэл яруу банжид нирваан эрдэнийн дээд чимэг, Үндэстний номын сангийн гар бичмэл номын хөмрөг, гар бичмэл судар, 102а тал

⁴³ Зава Дамдин, Умар зүгийн монгол оронд дээд ном эрдэнэ гарах ёсны домог өлзийт лавай мөшөөсөн дуун эгшиг хэмээх оршвой, төвд монгол хадмал, гар бичмэл,- Лавайн эгшиг, 1998 оны №2, 3-68.

хүйтэн дайны үе намжсан нь монголын улс төр болон оюуны соёлд нааштай уур амьсгалыг авчирчээ. Гандан хийдийн дэргэд Номын гэр, ШУА-ийн дэргэд төвд судлалын тасаг байгуулагдаж, Ардын эмнэлгийн хүрээлэн, ШУА-ийн Түүх, Философийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагад монголчуудын төвд хэлээр бичсэн ном судрыг судлах, орчуулах ажил ч сэргэсэн билээ. Гандан хийдийн Номын гэрийг эрхэлж байсан хамба С.Гомбожав “Бадарчин Гомбодорж”, “Хөгшин үнээний үг”⁴⁴ зэрэг сургаалын зохиолоос гадна монголын эрдэмтэн баарин Дармадалагийн төвд хэлээр бичсэн түүхэн сурвалж бичгийг монгол хэлнээ орчуулжээ. Монгол аман орчуулгын урын санд С.Гомбожав тэргүүтэй лам нар ихээхэн хувь нэмэр оруулсныг шавь нар нь талархан дурсдаг. Дээр дурдсан Номын гэрээс төвд хэлнээс ном судар орчуулах ажлыг эрхлэн гаргаж байсны нэг жишээ бол “Зориуд өгүүлэхүй цоморлиг ба номын бадаг хоёрыг хавсарч судалсан шастир” бөгөөд тус номыг орчуулах үйлд гавж Т.Данзан-Одсэр, гэвш Ш.Ламаажав, С.Иштавхай, Дашдамба нар оролцож С.Гомбожав хянан тохиолдуулж, 1966 онд хэвлүүлсэн байна. Түүнчлэн Эрдэнэпил хамбын орчуулсан Калидасын “Үүлэн зардас”-ын орчуулга, Өндөр гэгээн Занабазарын төвд хэлээр бичсэн “Жинлав цогзолма” буюу “Адистидийн дээдийг хайрлагч эх”-ийн Х.Гаадан хамбын орчуулга гарсан билээ⁴⁵. Далай лам Цанъянжамын “Янагийн дуулал”-ын Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, Л.Хүрэлбаатар⁴⁶, Д.Ёндон⁴⁷ нарын монголчуудын төвд хэлээр бичсэн сургаалын зохиол, уран шүлгийн орчуулга төвд уран зохиолын орчуулгад томоохон байрыг эзлэх юм. Төвдөч Ч.Алтангэрэл төвд хэлнээс уран зохиол, зохист аялгууны онолоор бичсэн яруу найргийг орчуулах талаар ихээхэн хүч хөдөлмөрөө зориулсан уран бүтээлч юм. Тэр бээр Цахар гэвш Лувсанчүлтэм, Агваанхайдав, Ишданзанванжил нарын төвд хэлээр бичсэн уран зохиолоос түүвэрлэн орчуулахаас гадна Ноён хутагт Данзанравжаагийн бүтээлээс 40 орчим яруу шүлгийг монголчлон буулгажээ⁴⁸.

1990 оны ардчилсан хөдөлгөөний нөлөөгөөр Монгол оронд үндэсний соёл, ёс зан заншлаа судлах ажил сэргэхийн сацуу төвд хэлнээс ном судар орчуулах, уламжлалт орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэн буулгах ажил ч өрнөн дэлгэрэв. 1990 оноос өмнө буюу социализмийн үед тухайн үеийн үзэл суртлын нөлөөгөөр зонхилон уран зохиолын чиглэлийн ном судрыг орчуулж байсан бол шинэ үед төвд хэлнээс уран зохиол төдийгүй буддын гүн ухаан, тэжээх ухаан,

⁴⁴ Алтан хүрдэн, Монгол зохиолчдын төвд хэлээр туурвисан бүтээлийн дээжсийн цоморлиг, хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар, УБ., 1992, 69-71.

⁴⁵ Тус зохиолыг Ш.Бира, Ш.Чоймаа нар монгол хэлнээ бас орчуулжээ.

⁴⁶ Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Цэнгээн наадмыг тэвчих дуун”, Найман Жамбалдоржийн “Уулын ном” тэргүүтэн шүлэг найргийн орчуулгын түүвэр гарав,- Алтан хүрдэн, УБ., 13-17, 22-23, 34-47, 48-68, 90-103 дугаар тал. Мөн Жамьянгаравын зарим шүлэг найргийн орчуулгыг Жамьянгарав судлалын тэргүүн ботид Д.Ганболд эмхтгэн 2013 онд хэвлүүлжээ.

⁴⁷ Ноён хутагт Данзанравжаа, Агваанхайдав нарын шүлгийн Д.Ёндонгийн түүвэр орчуулга,- Алтан хүрдэн, УБ., 17-22, 76-90.

⁴⁸ Ч.Алтангэрэл, Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл, I дэвтэр, УБ., 1967, II дугаар дэвтэр /Д.Равжаа/, УБ., 1968.

урлахуй ухаан, одон зурхай зэрэг олон салбар ухааны ном судрыг орчуулах ажил сэргэсэн билээ. Тухайлбал түүхийн чиглэлээр төвдийн түүхч Даранатын “Жагар чойнжун” буюу “Энэтхэгийн түүх”-ийг Л.Тэрбиш /2000 он/, Цэмбэл гүүшийн “Хорчойнжун” буюу “Монголд шашин ном дэлгэрсэн” тухай өгүүлсэн түүхэн сурвалжийг Л.Тэрбиш, Р.Бямбаа нар /1997 он/, Гүн Гомбожавын “Жанаг чойнжун” буюу “Хятадын түүх”-ийг Д.Цэдэв /1996 он/, Сүмбэ хамба Ишбалжирын “Цо онбы лоржүй” буюу “Хөх нуурын түүх”-ийг Д.Дашбадрах /1997 он/, Зава Дамдины “Алтан дэвтэр”-ийг С.Гантөмөр /2014 он/, төвдийн түүхч Браггон шавдүн Гончогдамбаравжайгийн “Чойнжун намтаржи товъёог” буюу “Түүхийн номын товъёог”, тавдугаар Далай лам Лувсанжамцын “Жалва ави дэвтэр” буюу “Тавдугаар ялгуусны дэвтэр” хэмээх сурвалж бичгийн монголын түүхэнд хамаатай хэсгийг Д.Бүрнээ, Д.Энхтөр /2003 он/, “Бодь мөрийн явдал ёсны шимийг хураангуйлсан гарын авлага” /2004 он/, “Очроор огтлогч нэрт хөлгөн судар”-ыг Г.Мягмарсүрэн /2009 он/, Өндөр гэгээн Занабазарын төвд намтрыг Ш.Бира, Ш.Сонинбаяр нар /1995 он/, Дамцигдоржийн намтрыг Ш.Сонинбаяр /2011 он/, Зонхавын намтрыг Д.Наранцэцэг /2012/, Зава Дамдины намтрыг Ш.Сонинбаяр, Сүмба хамба Ишбалжирын намтрыг Л.Тэрбиш /2011 он/, бандид хамба Жамьянгаравын намтрыг Ч.Ганболд /2013/ нар тус тус орчуулжээ. Түүнээс гадна буддын гүн ухааны чиглэлээр Шантидэвагийн “Бодьсатвын явдалд орохуй” /1998 он/, Лувсанбалдан гавжийн “Бодьсатвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар” /2009 он/, Зонховын “Их бодь мөрийн зэрэг” /2004 он/, энэтхэгийн гүн ухаантан мэргэдийн зохиосон “Хутагт хос судрын номын зүйл”-ийн /2009 он/ Т.Булганы орчуулга гарсан билээ. “Бага бодь мөрийн зэрэг”-ийг бурханч лам Г.Пүрэвбат /2002 он/, “Бодь мөрийн зэргийн хөтөлбөр амар мөр”-ийг С.Гантөмөр /2014 он/, Зонхавын “Бодь мөрийн зэрэг”-ийг П.Бадрал /2006 он/⁴⁹, Батаа равжамбын “Рашааны үсэрвэр” хэмээх “Бодь мөрийн зэрэг”-ийн тайлбарыг Ж.Ерөөлт, Павонхагийн “Гэтлэхүйн гарын авлага”-ыг Ц.Сансарбат /2011/, Зонхавын “Сайн номлолын зүрхэн”-ийг С.Мөнхтайван /2010 он/, Зава Дамдины гүн ухааны зохиолоос түүвэрлэн С.Янжинсүрэн, Р.Алтансүх, Б.Ариунзул нар /2012/ тус тус орчуулжээ. Уран зохиолын чиглэлээр энэтхэгийн алдарт сургаалын зохиол “Дармапада”-гийн төвд хэлээр уламжилж ирсэн эхийг Л.Тэрбиш /2008 он/, Гүнтэн гэгээний зохиосон “Гал, ус, салхи, модны шастир”-ыг И.Дэмбэрэл /2012/, Зая бандид Лувсанпэрэнлэйн бичсэн “Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй эсэрваагийн хөвгүүнийг баясгах дуун эгшиг” зохиолоос Д.Бүрнээ /2012 он/, “Субашид” болон түүний тайлбарыг Д.Мөнх-Эрдэнэ /2001/, Бичээч цорж Агваандоржийн “Эрхэм их хэрэгт үгийн тэмдэглэл”-ийг Б.Няммыгмар, Дагпу Лувсандамбижалцангийн “Саран хөхөөний тууж”-ийг С.Гантөмөр /2006 он/, “Энэтхэг орны тэмдэглэл”-ийг Г.Мягмарсүрэн /2010 он/ нар орчуулсан байна. Зурхайн ухааны чиглэлээр “Үрийн зурхай болор толь” тэргүүтэй гурван

⁴⁹ П.Бадрал, Непко хэвлэлийн газраас эрхлэн гаргаж буй Агнистын гэгээ цувралаар буддын шашин, гүн ухаан, уран зохиол болон зан үйлийн холбоотой 15 номыг төвд болон бусад хэлнээс монгол хэлнээ орчуулжээ.

боть номыг Л.Тэрбиш /2000 он/, Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Увидасын утгын хураангуй” хэмээх бүтээлийг Д.Даваасүрэн /2010 он/ орчуулжээ. Түүнчлэн шашны зан үйлийн чиглэлээр Ч.Хатанбаатар “Дара эх бурханд өргөн дөрвөн хот мандал тахил”-ыг /2002 он/, “Улаан сахиусны гар дэвтэр”-ийг Б.Батсанаа /2005 он/, “Бурхан багшийн лагшнаа сүншүг өргөсөн ёсны тэмдэглэл тунгалаг тодорхой толь”-ийг Г.Мягмарсүрэн /2010 он/, Дара эхийн гарал үүсэлтэй холбоотой ном судар болон Дара эхийн холбоотой магтаал, уншлагыг Ч.Гүнзээ /2015 он/, бандид Цэвэлванчигдоржийн “Хишиг дуудах” судрыг Я.Ганзаяа /2015 он/, Дэсрид Санжаажамцын “Газрыг шинжих ёсны тухай” судрыг Б.Няммягмар /2015 он/ нар тус тус орчуулжээ.

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр ном судар орчуулах үйлд Ч.Баавгай, И.Дэмбэрэл, түүх, гүн ухааны зохиолын орчуулгад С.Лодой нарын ахмад үеийнхэн хувь нэмрээ оруулсныг энд онцлон тэмдэглэх ёстой. Тухайлбал, монголын алдарт маарамба Лүнриг Дандарын “Монголын уламжлалт анагаах ухааны түүх” /1993/, “Анагаах ухааны дөрвөн үндсийн тайлбар оршвой”, /1996 он/, “Лхантавын бэрх үгийн тайлбар алтан өнгөт арүүрийн эрихэс” /1993 он/ тэргүүтэн судрыг И.Дэмбэрэл орчуулжээ. Лүнриг Дандарын “Халуун хүйтэн өвчнийг магадлан шинжлэх нь” судрыг Б. Болдсайхан /1993 он/, Сүмбэ хамба Ишбалжирын /1704-1788/ “Рашааны цагаан шүүдэр”-ийг Ш.Болд, Дагва нар /1999 он/, Тарган бандид Цэвэлванчигдоржийн “Малын өвчний судар”-г Д.Цэдэв /1992 он/ товчлон орчуулжээ.

Монголчуудын төвд хэлээр бичсэн номын бүртгэлийг С.Гомбожав анх хийсэн бөгөөд түүнийг Р.Бямбаа үргэлжлүүлж “Монголчуудын төвд хэлт бүтээлийг судлах монгол билиг” нэрт цувралаар 2004-2013 оны хооронд нийт 9 ботийг гаргаж, зохиогчдийн сүмбүмийн гарчигийг орчуулж, зарим зохиогчдийн намтрын холбоотой мэдээ баримтыг оруулжээ. Монголчуудын төвд хэлээр бичсэн бүтээлийг сурталчлах, судлах талаар Гандан хийдийн дэргэдэх “Лавайн эгшиг” хэмээх бурхан шашны судлал, мэдээллийн сэтгүүл чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. 1996 оноос өдгөө хүртэл гарсаар байгаа тус сэтгүүлийн дугааруудад буддын шашин, утга зохиолын холбоотой ном зохиолын орчуулгаас хэвлэн нийтэлж ирснийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Түүнчлэн ШУА-ийн ХЗХ-ийн Төвд судлалын тасгаас 2011 оноос эрхлэн гаргаж буй Төвд судлалын 15 цувралаар монгол, төвд мэргэдийн эрдэм ухааны төрөл бүрийн салбараар бичсэн бүтээлийн хуучин орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэх, хуучин орчуулгыг эхээр нь хэвлэх, шинэ тутам төвд хэлнээс эх хэлнээ орчуулан хэвлэн нийтэлж, олон түмний хүртээл болгох талаар чармайн ажиллаж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Монголчуудын төвд хэлнээс орчуулсан судар номын дийлэнх нь худам монгол бичгээр уламжилж ирсэн учир өдгөө зарим номыг төвд хэлнээс шинэ тутам орчуулахаас гадна монгол бичгээр бүхий хуучин орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэх ажил 1990 он гарсаар идэвхжсэн билээ. Үүнд анагаах ухаан,

одон зурхай, зохист аялгуу, урлахуй ухаан гээд буддын утга зохиолын салбар ухаан тус бүрийн холбоотой орчуулгын хөрвүүлэг гарч байна. Тухайлбал, “Цогт цагийн хүрдэн” соёлын төвөөс монгол дармал Ганжуур, Данжуурыг монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн нийтлэх ажлыг 2011 оноос эхэлснийг дурдууштай. Энэ нь манай улсад 1990 оноос хойш буддын шашны сүм хийдийг дахин сэргээн байгуулж, сүм хийдийн дэргэдэх дацан сургууль, зарим Их, дээд сургуульд төвд хэл бичгийг заан сургах болсон, эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнгүүд уламжлалт шашин соёлын судалгаанд анхаарлаа хандуулах болсон зэрэг нийгмийн эрэлт хэрэгцээтэй холбоотой гэж үзэж байна.

Ийнхүү төвд хэлнээс эрт дээр үеэс өдгөө хүртэл үргэлжилж буй монгол орчуулгыг тоймлон үзвэл манай үе үеийн хэлмэрч орчуулагчид монгол орчуулгын урын санг баяжуулахад ихээхэн хувь нэмэр үзүүлжээ⁵⁰. Нэн ялангуяа монгол бичиг, тод бичгээр уламжилж ирсэн арвин их орчуулгын дурсгал бол бидний монголчуудын оюуны соёлын асар том өв болох билээ. Эдгээр орчуулгын зарим нь манай улсад байхгүй зөвхөн гадаадын ном санд хадгалагдаж буй учир бид тэдгээр орчуулгыг цаашид хуулбарлан авах, судлах ажлыг бас орхигдуулахгүй хийх ёстой байна. Түүнээс гадна уламжлалт орчуулгын хэл найруулгаас өнөө үеийн хэлмэрчид бас давхар суралцах ёстой болов уу. Ялангуяа “Мэргэд гарахын орон” толь бичгээр тогтоосон нэр томъёог орчуулгадаа мөрдөж байгууштай. Учир нь төвд хэлтэй гэгдэх хүн бүр дур зоргоороо нэр томъёог буулгаснаас болж, нэг нэр томъёоны олон орчуулга гарч, уншигчдыг төөрөлдүүлж байна. Монгол бичгээс хөрвүүлэх ажлыг ор нэрийн төдий хийсэн байдал ч мэр сэр ажиглагдах тул хэлний мэргэжлийн хүмүүст үзүүлж, засаж залруулахыг анхааруулж байна. Шашин номоо бодсон ч тэр, хувь хүний ажлын хариуцлагыг бодсон ч тэр төвд хэлнээс ном судар орчуулах ажилд чин сэтгэлээс хандан, эх монгол хэлээ сайтар судалж, уламжлалт орчуулгын сонгодог зохиолоос сайтар суралцаж, үгд бус, утгад шүтэн орчуулахыг залуу орчуулагч нартаа уриалъя.

Резюме

Монголы имеют богатую переводческую традицию. Начиная с 13-14 века по сегодняшний день монголы перевели с тибетского языка большое количество сочинений. Переводы этого периода отличаются от последующих переводов тем, что слова и термины не переводятся с тибетского, а ставится их санскритское заимствование. В истории монгольского перевода 17-18 век был знаменателен тем, что в этот период был завершён перевод тибетского Канджура, и Танджура. В переводе Канджура, в котором содержатся наставления Будды Шакьямуни, буддийские легенды и джатаки, приняли участие как свидетельствуют исторические сочинения тридцать три

⁵⁰ Энэхүү өгүүлэлд орчуулагчдийн зарим төлөөлөгчийг оруулсан бөгөөд бүх орчуулагчийг дурдах боломж байсангүй. Өвөр монголчууд сүүлийн үед төвд хэлнээс ном судар их орчуулж буй тухай тусгайлан өгүүлэх хэрэгтэй гэж үзсэн учир энд мөн оруулсангүй.

переводчика. В переводе Танджура, который содержит богатую буддийскую литературу, охватывающей литературу по логике, философии, филологии, искусству и медицине приняли участие более чем 200 переводчиков. При переводе Танджура был составлен тибетско-монгольский словарь специальных терминов буддийской литературы "Мэргэд гарахын орон" /Источник мудрецов/, который явился важным руководством для переводчиков приехавших из разных регионов тогдашней Монголии. Учёные считают, что именно при переводе Канджура, Танджура и оформился классический монгольский письменный язык.

Перевод буддийских сочинений этого периода является по большей части дословным, который является свидетельством верности тибетскому оригиналу. Перевод же сочинений имеющих светский характер отличается художественностью и образностью языка.

В истории монгольского перевода тридцатые годы 20 века отмечаются периодом застоя, вследствие политической репрессии охватившей Монголию. В 50-е годы, особенно начиная с 90-х годов начинается возрождение тибетско-монгольского перевода. Если в 50-90-е годы были переведена по большей части тибетская литература имеющая светский характер, то в 90-е годы преобладает перевод религиозной литературы.

МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН ФРАНЦ ЗОХИОЛ, БҮТЭЭЛ

Б.Алтангүл⁵¹

Монгол Францын харилцаа эртнээс улбаатай билээ. Илхаан Аргун, Өлзийт нар Францын Гоо Филиппт захидал илгээж, IX Луй вангийн санал сэдлээр Рубрук Монголын эзэнт гүрэнд XIII зуунд зорчиж, анхны элчийн харилцааны хэлбэртэй байсан. 1965 онд БНМАУ, БНФУ-ын хооронд дипломат харилцаа тогтоож, Монгол, Франц улсын төв хэвлэлүүдэд албан мэдээ нийтлэгдсэн байдаг.

1921 оны Хувьсгалын дараа “Өрнөд Европын улсуудаас Герман, Англи зэрэг улстай юуны өмнө худалдаа хөгжүүлэхийг зорьж байсан бол Франц улстай соёл боловсрол, шинжлэх ухааны салбарт харилцах зорилт тавьж байжээ. 1927 оны эхээр Д.Аюурзана, Ж.Дүгэрсүрэн, Намсрай, Б.Уртнасан нарыг Франц улсад суралцуулахаар илгээжээ. Эдгээр оюутнуудыг эдийн засгийн чиглэлээр голлон сургахыг зорьсон байна. Мөн Франц улс бол Монгол улсыг НҮБ-д элсэхийг анхнаас нь дэмжсэн Өрнөд Европын анхны улс байжээ”⁵².

Ер нь “Европ дахины олон улсын дотроос шашны хүрээгээр бус улс төрийн хүрээнд Монголыг анх анхааран судласан орон гэвэл Франц бөлгөө” хэмээн эрдэмтэн Ц.Шагдарсүрэн онцлон тэмдэглэсэн байдаг нь уг хоёр орны харилцааны тухайд их чухал санаа хөндсөн байна.

Бид энэ удаад Франц зохиол бүтээлийн орчуулгын тоймыг он дарааллаар нь авч үзэхийг зорьсон юм.

XX зууны эхэн үеэс өрнө зүгийн тэр тусмаа францын уран зохиолын орчуулга асар хурдтай хөгжиж, олон арван бүтээл уншигчдад хүрчээ.

“Дэлхий дахины утга зохиолд гүнзгий нөлөөлдөг утга зохиолуудын нэгэнд Францын утга зохиол орно. Раблэ, Мольер, Вольтер, Дидро, Бальзак, Гюго, Стендаль, Флобер, Мопассан, Золя, Франс, Роллан болон Францын бичгийн бусад их хүмүүсийн нэр улс болгонд түгэж уншигч бүрийн зүрхийг донсолгож, сэтгэлийг баясган, ядрах цагт хүчийг нэмж, нойрмоглох үед ухааныг сэргээж байна” хэмээн орчуулагч Ж.Намсрай⁵³ дурьдсан байна.

Ер нь монгол хэлнээ орчуулсан франц бүтээлийг орчуулсан он дарааллаар нь доорхи байдлаар авч үзэж болох талтай гэж бид үзэж байна.

- а. 1913-1960 (орчуулгын суурь баттай тавигдсан үе)
- б. 1960-1975 (орчуулгын оргил үе)
- в. 1975-1990 он
- г. 1990 оноос өнөөг хүртэл.

⁵¹ МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

⁵² Оюунгэрэл Л, *Монгол, Францын харилцаа*, УБ, 2003.

⁵³ Намсрай Ж, *Францын утга зохиолын түүх*, УБ, 1997, 2-р тал.

а. 1913-1960 оны үеийн орчуулгын бүтээлийн онцлог

XX зуунд Монголын орчуулгын түүхэнд эргэлт гарч орчуулгын үйл хэрэг дорно зүгийн соёлын хүрээнээс халин гарч түүний олон төрөл зүйл мэдлэгийн бүх салбарыг хамарч эрч хүчтэй хөгжсөн.

1921 оны сүүлчээр хэсэг сэхээтэн санаа зорилгоо нэгтгэж, улс орныхоо хоцрогдлыг арилгах, ард түмнээ соён гэгээрүүлэх, бичиг үсэг, соёл боловсролтой болгохын тулд шинжлэх ухааны зүйл бүрийн салбарыг үүсгэн хөгжүүлэх зорилго бүхий Номын (Судар бичгийн) хүрээлэн байгуулах санал боловсруулж Ардын засгийн газарт өргөн барьсан нь өнөөгийн Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн үндэс суурь болсон билээ.⁵⁴ Ийнхүү үндэсний сэхээтнүүд шинэ Монгол улсын ард түмнийг гэгээрүүлэх ажилд гар бие оролцсон бөгөөд шинэ мэдлэг, ойлголтыг монгол хэлээр хүргэхэд орчуулга чухал үүрэг гүйцэтгэсэн байгаа юм. Мөн цаг үеийн шаардлагаар сэхээтнүүд орчуулагч болж байсан тухайд “... энэ үед орчуулга шинэ шатанд гарч, цаг үе олон авьяаслаг орчуулагчдыг төрүүлэн гаргасан ... 30-аад онд би хөгжимчин болох хүсэлтэй байлаа. Гэтэл намайг “чи хүссэнээ хийх биш, хэрэгтэйгий нь хийх шаардлагатай байна” гээд театрын орчуулагч болгосон юм” хэмээн ахмад орчуулагч Э. Оюун дурсжээ.⁵⁵

1913 оноос “Шинэ толь” сэтгүүлд, 1915-1920 оны хооронд “Нийслэлийн хүрээний сонин бичиг” сонинд дэлхийн байдал, олон орнуудын түүх, аж ахуй, зан заншлын тухай нийтлэг мэдээлэл гардаг байсан. “Шинэ толь” сэтгүүлд Леон Каны (Lyon Cahun) “Хөх Монголын Хөх Туг” (La bannière bleue) хэмээх түүхэн романы хэсэг нийтлэгджээ. Энэ нь өрнө зүгийн утга зохиолоос орчуулагдсан анхны үргэлжилсэн үгийн зохиол хэмээн үзэж болох юм.⁵⁶ Уг зохиолыг Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайдын алба хашиж байсан Ж.Цэвээн орчуулжээ. Тэрбээр Жюль Верний “Арван таван наст капитан” хэмээх адал явдалт романыг 1937 онд орос хэлнээс монгол бичиг рүү орчуулсан бөгөөд уг зохиолыг 2 дахь удаагаа 1959 онд хэвлүүлэн өсвөрийн залуу уншигчдад өргөн барьсан юм.

Энэ үед эрдэмтэн, зохиолч Б.Ринчен, зохиолч, орчуулагч Д.Нацагдорж, орчуулагч Ж.Цэвээн, Б.Энэбиш, Г.Дамдин, Н.Жамбалсүрэн, Ж.Намсрай, Ш.Доржготов, Д.Самдан, зохиолч, орчуулагч Ч.Чимид, Ц.Цэдэнжав, Д.Сэнгээ нар голлох үүргийг гүйцэтгэжээ. Тэд намын үзэл бодлыг ард түмэнд хүргэх, шинээр тогтсон Хувьсгалын үйл явцыг дэмжих, хүмүүсийг боловсруулан мэдлэгийг нь дээшлүүлэх, танин мэдэхүйн чиглэлийн бүтээлийг сонгон орчуулж байсан нь тохиолдлын чанартай бус, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг ухамсарлаж байсныг харуулж буй юм.

Их эрдэмтэн Б.Ринчен Ги дө Мопассаны “Гар”, “Өвгөн”, Альфонс Додегийн “Алтан тархитай хүний домог” өгүүллэгийг нь 1935 онд орчуулж

⁵⁴Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 58-р тал.

⁵⁵Дашдаваа Д, М. *Горькийн зохиолын монгол орчуулгын тухай*, УБ, 1984, 18-р тал.

⁵⁶Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 58-р тал.

“Шинэ толь” сонины 1, 2-р дугаарт, 1944 онд Бомаршегийн “Ухаангүй өдөр буюу Фигарогийн гэрлэсэн нь” жүжгийг орчуулж “Цог” сэтгүүлд хэвлүүлж Францын жүжгийн зохиолын орчуулгын эхийг тавьсан гэж үзэж болохоор байгаа юм.

Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж Альфонс Додегийн “Алтан тархитай хүний домог”, Мопассаны “Аглагч”-ийг орос хэлнээс тус тус орчуулжээ. Энэ үед 50 гаруй франц бүтээлийг монголчилсоны дотор 10 гаруй роман, 2 жүжиг, 4 тууж, 2 туурь, 9 өгүүллэг, 9 шүлэг, 1 найруулал, 1 дуу орчуулсан гэсэн тоо гардаг.

Энэ үеийн бас нэг онцлог бол 1945 оноос Монгол улсын гадаад харилцаа эрс өргөжихийн хэрээр франц хэлтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх цаг үеийн шаардлага гарч ирсэний дагуу ЗХУ-д франц хэлтэй мэргэжилтэн бэлтгэх үндэс тавигдаж Б.Хэнмэдэх, Г.Батсүх, Ж.Намсрай, Т.Пүрэвжал нар төгсчээ.

1950 он хүртэл шинэ хувьсгалын үйл явцыг ард түмэнд таниулах, танин мэдэхүйн чиглэл зохиолын орчуулга зонхилж байсан бол 1950-1960 оны хооронд нам ард түмэн, энх тайван, эв хамтыг магтан дуулах, энх тайвнаар зэрэгцэн орших, дайны аюулыг сэрэмжлүүлсэн утгатай бүтээлийн орчуулга голлох байр суурь эзэлсэн байдаг. Энэ үед дэлхийн 1, 2-р дайнд оролцож явсан Луй Арагоны “Мянга есөн зуун дөчин зургаан он” шүлгийг Ц.Цэдэнжав, “Шүлэгчээс намдаа” шүлгийг Ж.Намсрай нар тус тус монголчилсон байна.

6.1960-1975 оны үеийн орчуулгын бүтээлийн онцлог

Энэ үед хэл хэлний уран зохиолын орчуулга Монгол оронд ид хүчээ авч байсан бөгөөд ХХ зуунд соёл, эрдэм мэдлэгийн хүрээнд асар их амжилт олсны нэг гол үр дүн бол манай сэхээтнүүд гадаадын олон хэл эзэмшиж эхэлсэн явдал байв. Тавиад оны дунд үе хүртэл манайд голчлон орос хэлээр дамжуулан бусад орны уран зохиолын бүтээлтэй танилцаж байсан байлаа. Энэ бол тухайн нөхцөл байдалд зайлбаргүй туулж өнгөрөх зурвас үе байсан бол яваандаа орос орчуулга хичнээн сайн боловч түүнээс дам орчуулах нь олон талаар сөрөг нөлөөтэй байсан нь амьдралд батлагдсан учраас эх хэлнээс шууд монгол хэлэнд орчуулах эрмэлзэл давамгайлах болжээ.⁵⁷

Монголчууд Европын соёл иргэншилтэй танилцахад Францын сонгодог зохиолчдын зохиол бүтээлүүд чухал үүрэг гүйцэтгэснийг цохон тэмдэглэх хэрэгтэй билээ.⁵⁸

Энэ үед нэгэнт тогтсон хувьсгалын үйл явцыг улам цааш нь бэхжүүлэхийг уриалсан, ард түмний бодит амьдралыг харуулсан, хайр дурлалыг магтан дуулсан агуулгатай дэлхийн сонгодог зохиолыг франц эхээс нь орчуулах явдал хүчээ авч эхэлсэн байдаг. Дэлхий дахинд алдаршсан Жюль Верн, Ги дө Мопассан, Анатоль Франс, Виктор Гюго, Стендаль, Оноре дө Бальзак, Проспер Мериме, Раблэ, Эмиль Зола, Жорж Сименон, Альфонс Доде, Александр Дюма

⁵⁷Гүрбазар Р, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996, 72-73 дахь тал.

⁵⁸Оюунгэрэл Л, *Монгол Францын харилцаа*, УБ, 2003, 85-р тал.

зэрэг зохиолчдын бүтээлийг орчуулагч Ж.Намсрай, Т.Пүрэвжал, С.Адийхүү, Т.Төмөрхүлэг, Ц.Батцэвэл, Д.Даш, Ш.Очирбат, М.Цэдэндорж, Г.Амар, Б.Хэнмэдэх, П.Намсрайжав, Л.Чойжилсүрэн, С.Цэрэнрагчаа, Г.Аким нар монголчилсон.

1963 оноос МУИС-ийн Хэл бичгийн факультетад багш орчуулагчийн мэргэжлээр франц хэлний мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн нь эх хэлнээс орчуулах явдалд дөхөм болжээ. Б.Пүрэвбаатар “Монте-Кристо гүн”, “Инээмтгий хүн” зэрэг романыг франц хэлнээс өмнө орчуулсан эхтэй нь тулган дахин орчуулсан байдаг. Мөн эх хэлнээс Ж.Намсрай Анатолий Франсын “Кренкебиль” туурь, “Шүүгчид” өгүүллэг, Гюгогийн “Парисын Дарь эхийн сүм”, “Зоригт далайчид” роман, Стендалийн “Улааныхан ба Харынхан” роман, Бальзакийн “Хүүхэд” өгүүллэг, Флоберийн “Бовари хатагтай” романыг тус тус орчуулан уншигчдын хүртээл болгосон юм.

Энэ үед эрдэмтэн, зохиолч Х.Пэрлээ Францын ардын аман зохиолын баялаг өв, баатарлагийн туульс “Роландын дуулал”-ыг 1969 онд орос хэлнээс орчуулснаар олонд хүрсэн билээ.

Энэхүү алтан үед үргэлжилсэн үгийн роман, тууж, өгүүллэгийн орчуулгын тоо эрс нэмэгдэж 100 гаруй бүтээлээс нь 30 гаруй роман, 2 жүжиг, 50 гаруй өгүүллэг, 6 тууж, 1 туурь, 1 дуу, 5 шүлэг, 2 найраглал зэрэг уран зохиолын бүхий л төрлийн орчуулга байгаа нь харагдаж байна. Жил алгасалгүй аль нэгэн орчуулгын бүтээл уншигчидад хүрч байсан нь ихээхэн онцлогтой явдал юм.

в. 1975- 1990 онхүртэлхүеийнорчуулгын онцлог

Өмнөх үеийг бодоход жил бүр орчуулгын бүтээл олны хүртээл болоогүй хэдий ч монголчилсон бүтээлийн ихэнхийг франц эхээс буулгасан. Д.Пүрэвдорж, Т.Төмөрхүлэг, Б.Пүрэвбаатар, Ц.Сүхбаатар, С.Дулам зэрэг франц хэлт орчуулагчид орчуулгыг эрхлэх болсон нь онцлог явдал болов.

Өрнө зүгийн уран зохиолын орчуулгын ажил нэлээд цэгцэрч, орчуулагчдын тоо өсч, орчуулгын онолын асуудал хурцаар тавигдах болсон үед орчуулгын чанарыг сайжруулах, орчуулагчдын ур чадварыг дээшлүүлэхэд шүүмж судлал онцгой үүрэг гүйцэтгэх болсон байна. 1972 оноос эхлэн гаргасан “Орчуулах эрдэм” цуврал бүтээл бүх хэлний орчуулгын бүтээлийн шүүмж судлалд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ.

Францын уран зохиолыг орчуулах ажил үргэлжлэн, төрийн шагналт, зохиолч Д.Пүрэвдорж МУИС-ийн франц хэлний оройн ангид суралцан Пуррагийн “Урт хамарт гүнжийн үлгэр” гэх үлгэрийн номыг франц хэлнээс, Т.Төмөрхүлэг “Ертөнцийн нэгэн гал голомтын түүх” хэмээх өгүүллэгийн түүвэр 1976 онд франц хэлнээс, М.Шатар “Балар цагийн хуучин явдал” романыг 1978 онд тус тус орчуулжээ.

Орчуулагч Ц.Сүхбаатар “Франц өгүүллэгүүд” хэмээх өгүүллэгийн түүвэр 1980 онд, Шарль Перрогийн “Үлгэрүүд” түүврийг 1983 онд тус тус хэвлүүлсэн байдаг.

МУИС-д бэлтгэгдсэн анхны монгол мэргэжилтний нэг, орчуулагч Б.Пүрэвбаатар 1978 оноос Улсын хэвлэлийн нэгдсэн редакцид орчуулагч-редактор хийх үеэс францын шилдэг бүтээлийг сорчлон орчуулж эхэлсэн юм. Додегийн “Тартарен Альпийн нуруунд” (1982), Меримегийн “Коломба” (1983), “Зуурдын тамын сүнс” (1983), “Давхар алдаа” (1983), Мопассаны “Монт-Ориол”(1983), Сименоны “Шар нохой” (1985), “Хүний амь” (1985), “Негрийн хороолол”(1985), Дюмагийн “Монте-Кристо гүн” (1990), Гюгогийн “Инээмтгийн хүн”(1985) зэрэг роман, тууж, өгүүллэг гаргасан байдаг.

Дидрогийн “Гэлэнмаа” гэх алдарт романыг Т.Төмөрхүлэг франц хэлнээс 1984 онд орчуулж гаргасан нь уншигчдийн анхаарлыг зүй ёсоор татсан юм.

С.Дулам Бодлерийн “Үдшийн дуурьсал”, “Этгээд анхилуун”, “Бүсгүйн салхинаа” гэх шүлгийг анх орчуулан “Утга зохиол, урлаг” сонинд 1988 онд хэвлүүлжээ.

Энэ үед бичлэгийн шинэ төрөл эссэ, нийтлэл, сургааль үгс, абстракт жүжгийг уншигчдад өргөн барьсан. 200 гаруй бүтээлийг монголчилсон хэдий ч үргэлжилсэн үгийн романы тоо эрс цөөрсөн нь харагдаж буй юм. 1975 оноос 1990 он хүртэл тасралтгүй орчуулгын ажлыг эрхэлж байсан хэдий ч 1990-ээд оны нийгэм, улс төрийн өөрчлөлтийн гадуур орчуулгын салбарүлдээгүй. 90-ээд оны эхэн үед голдуу садар самуун, адал явдалт өгүүллэгийн орчуулга зонхилж, танин мэдэхүйн шинжтэй зохиолын орчуулга бараг зогсонги байдалд орсон нь орчуулгын зохиолыг орчуулах нэгдсэн бодлого үгүйлэгдэж байсныг гэрчилнэ.

г. 1990 оноос өнөөг хүртэл

Нийгэм, улс төрийн огцом өөрчлөлт болсноор гадаадын уран зохиолыг нэгдсэн нэг бодлоготой орчуулах бодлого алдагдаж эхэлсэн. Энэ үеийн нэг онцлог гэвэл урьд өмнө хэвлэгдэж, олны хүртээл болж байгаагүй, өмнөх нийгэмд хориотой байсан сэдвийг хөндсөн, эсвэл, дэлхийн утга зохиолын салбарт онцгой үүрэг гүйцэтгэсэн зохиолчдын бүтээлийг сонгон орчуулах хандлага түлхүү байв.

90-ээд оны дунд үеэс Францын орчин үеийн зохиолчдын бүтээлийн орчуулга мэр сэр харагдах болов. Артур Рамбо, Поль Верлэн, Жак Привер, Гийом Аполлинер, Самуэл Беккет зэрэг орчин үеийн утга зохиолын бүтээлийн шинэ урсгалын бүтээл орчуулгыг чимэх болсон байна.

Монгол улсын гурав дах Ерөнхийлөгч асан Н.Энхбаярын санаачилгаар Дэлхийн сонгодог утга зохиолын 50 боть номыг хэвлүүлэхэд францын Вольтерийн “Жамаараа яваа ертөнц”, Дидрогийн “Гэлэнмаа”, Оноре де Бальзакийн “Эцэг Горио”, “Гобсэк”, В.Гюгогийн “Парисын Дар эхийн сүм”, Г.Флоберийн “Бовари хатагтай”, Сартрын “Үг ба бусад зохиолууд”, Камюгийн “Этгээд хvн”, С.Беккет, Ю.Ионеско, А.Арто нарын “Абсурд театр” гэх зохиолыг сонгон дахинхэвлэсэн байна.

Орчуулагч А.Баасандорж асар богино хугацаанд “Суутны үхэл”(2005), “Шувуудын үүрнээс дурлалын жиргээ дуурсана” (2005), “Ялалтын роман”(2006), “Алтан нохой” (2007), “Диана, зүрх сэтгэлийн гүнж” (2009), “Согтуу хөлөг

онгоц” (2009) номыг франц хэлнээс тус тус орчуулан хэвлүүлсэн байна. 2009 онд “Согтуу хөлөг онгоц” ном хэвлүүлж “Алтан өд” шагналын орчуулгын төрлийн шилдэг бүтээлээр шалгарсан.

Зохиолч, орчуулагч Ю.Аюурзана францын алдарт зохиолч, үргэлжилсэн үгийн зохиолч Мишель дө Монтений “Сонгомол эссээнүүд”-ийг англи эхтэй нь тулган 2004 онд монголчилжээ.

Дэлхийн хүүхдийн зохиолын сор бүтээлийн нэг Сант-Екзюперийн “Бяцхан хунтайж” зохиолыг орчуулагч Ц.Сүхбаатар 2001 онд орчуулж, 2008 онд дахин хэвлүүлсэн. Уг бүтээлийг Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ном”, “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сурагчдын унших ёстой номын жагсаалтанд багтаан гурав дах удаагаа хэвлэсэн нь хүүхэд багачуудын унших дуртай номын нэг болсон юм.

2007 онд Нээлттэй нийгэм форум, “Монсудар” хэвлэлийн газраас Монголын нийгэмд хэрэгцээтэй, үлгэр жишээ болохуйц ном сурах бичиг орчуулах төслийг Франц хэлний монгол багш нарын холбоотой хамтран хэрэгжүүлсэн билээ. Францын улс төр судлаач Морис Дювержегийн “Улс төрийн байгууламж, үндсэн хуулийн эрхзүй” нэртэй онолын номыг франц хэлнээс орчуулахад Г.Баялаг-Эрдэм, Л.Бямбадолгор, Г.Цэвэлсүрэн, Д.Алтанцэцэг, Д.Баасанжаргал, Б.Алтангүл, Г.Буяннэмэх, Г.Сарнай, О.Тунгалаг нар оролцон, орчуулагч Т.Төмөрхүлэг хянан тохиолдуулж хамтын бүтээл туурвисан билээ.

2010 онд Сартрын “Огиудас” зохиолыг Б.Баттогтох орчуулсан. М.Отгонбаяр, Б.Онон нар феминизмийн үзлийг дэлхий нийтэд таниулсан Симон дө Бовуарын “Дайвар хүйстэн” зохиолыг орос, англи эх сурвалжаас нь харьцуулан орчуулжээ.

2010 онд Монсудар хэвлэлийн газраас Нобелийн шагналт зохиолчдын бүтээлийг орчуулах ажлыг санхүүжүүлэн дэмжсэн тул 2008 оны уран зохиолын салбарын шагналт Францын зохиолч Лө Клезюгийн “Алтан загас” романыг Б.Алтангүл орчуулж олны хүртээл болгосон байдаг.

Энэ бүхнээс авч үзэхэд ХХ зуунд Францын уран зохиолын орчуулгын эх суурь баттай тавигдаж, Монголын орчуулгын уран зохиолын салшгүй нэг хэсэг болсон байна.

Ашигласан бүтээл:

- Б. Алтангүл, *Répertoire des oeuvres françaises traduites en langue mongole*, УБ, 2004.
- Б. Алтангүл, *Францын уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага*, нэг сэдэвт зохиол, УБ, 2004.
- Ш. Базар, *БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиол судлалын ном зүй*, 1974, 1976, 1978, 1983, 1987.

- М. Баянзул, *1921-1955 онд Монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын бүртгэл*, УБ, 1957.
- Д. Галбаатар, *Уран зохиол, онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь*, УБ, 2012.
- Р. Гүрбазар, *Орчуулгын онол, дадлагын үндэс*, УБ, 1996.
- Д. Дашдаваа, *М. Горькийн зохиолын монгол орчуулгын тухайд*, УБ, 1984.
- Ж. Намсрай, *Францын утга зохиолын түүх*, УБ, 1997.
- Л. Оюунгэрэл, *Монгол, Францын харилцаа*, УБ, 2003.

Résumé

La traduction est inscrite dans la culture mongole depuis des temps immémoriaux. Il n'est pas étonnant que, parmi les premières œuvres françaises traduites en mongol, ait figuré *La Chanson de Roland* traduite par Kh. Perlee (1960), moins encore que parmi elles figure le roman historique de Léon Cahun, *La bannière bleue* dont le héros est Gengis khan. En 1913, ce premier ouvrage français a été publié en langue mongole par J. Tseveen, un des traducteurs expérimentés du russe en ancienne écriture mongole.

Depuis, plus de quatre cents œuvres de la littérature française, tous genres confondus et donc des romans, des nouvelles, des récits, des pièces de théâtre, de poèmes, des chants, des contes, des essais, ont été traduites en langue mongole directement du français ou à partir de version russe entre 1913 et 2016.

ОРОСООС БУСАД СЛАВ ХЭЛТЭН УЛСУУДЫН УРАН ЗОХИОЛ МОНГОЛД

Д. Энхжаргал⁵⁹

Resume: *In this research paper we have discussed translated works from slavonic languages into Mongolian except Russian and given the research-based information. Translated literature from slavonic languages into Mongolian were found in the libraries, namely: The National Library of Mongolia, Ulaanbaatar Public Library of Natsagdorj. Dand the Library of National University of Mongolia. The overview of the translated works was done. The paper has following parts: An introduction, Belorussian literature, Bulgarian literature, Polish literature, Slovak literature, Ukrainian literature, Czech literature and the Conclusion.*

Түлхүүр үгс: *Белорусс, Болгар, Словак, Польш, Украин, Чех, уран зохиол, орчуулга*

Оршил

Энэхүү өгүүлэл Монгол улсын төв номын сан, Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сан, МУИС-ийн номын сангуудад түшиглэн оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиол Монгол улсад хэрхэн дэлгэрснийг тогтоох, орчуулагчдын судалгааг хийх, мөн түүнчлэн орчуулагдсан бүтээлийн тоймыг гаргах зорилготой. Слав олон хэл гарвалзүйн хувьд Энэтхэг-Европын хэлний бүлд багтдаг. Энэ бүлийн Слав хэлний дэд бүлэгт орос, украин, белорусс (зүүн слав), словен, серб-хорват, македон, болгар (өмнөд слав), чех, словак, польш (баруун слав) хэлнүүд хамаарна. Бид энд буй хэлнүүдээс орос хэлийг авч үзээгүй. Украин, белорусс, болгар, чех, словак, польш зэрэг зургаан улсын уран зохиол Монголд орчуулагдаж, нийтийн хүртээл болсон тухай өгүүлэх болно. Бусад улсуудын уран зохиол Монголд төдийлөн дэлгэрээгүй байна.

1. Белоруссын уран зохиол Монголд

Белоруссын утга зохиолоос анх 1957 онд орос хэлнээс “Хөнгөн ажил” нэртэй, Белорусс ардын үлгэрийг Б.Лувсан орчуулж, “Пионерийн үнэн” сонины 8-р сарын 6-ны дугаарт нийтлүүлж байжээ. Үүний дараагаар 1959 онд Я.Коласын “Хавар” хүүхдийн шүлэг, Мавр Ливкогийн “Модон халбага” өгүүллэг, 1966 онд Белоруссын цоморлиг, “Үерийн дохио”, 1984 онд “Белоруссын зохиолчдын өгүүллэг”, 1987 онд П.Бровкагийн “Үүлс: шүлэг”, Н.Гилевичийн “Домогт партизануудын алдрын өлгий: шүлэг”, 1988 онд П.Бровкагийн Марат Казей: Найраглал, И.Шамякины “Итгэлээр амилсан

⁵⁹ МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/

зүрх”зэрэг нийт 11 бүтээл хэвлэгджээ. Хэмжээний хувьд И.Мележийн “Намагт нутгийнхан”, “Үерийн дохио”, И.Шамякины “Итгэлээр амилсан зүрх” зэрэг нь нилээд зузаан романууд байна. Орчуулагчдын хувьд дагнасан байдал ажиглагдахгүй байна. Үлгэр-1, шүлэг-3, өгүүллэг-1, цоморлиг-1, роман-3, найраглал-1 байна. Белоруссын уран зохиолыг монголчууд орос хэлнээс голлонорчуулжээ. Зохиолын сэдвийн хувьд хүний амьдрал, хувьсгалын үйл хэрэг, сайхан сэтгэл, сургамж гэх мэт байна.

Хүснэгт №1

№	Зохиолч, зохиолын нэр	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Белоруссын цоморлиг	Д.Гомбожав, З.Сандагаа, Ц.Цэдэнжав, УХХЭХ, 1966	тодорхойгүй.
2	Белоруссын зохиолчдын өгүүллэг	Г.Амар, УБ, УХГ, 1984	тодорхойгүй.
3	Бровка П. Үүлс:шүлэг	С.Баясгалан //Октябрийн гэрэл, 1987	орос хэлнээс
4	Бровка П. Марат Казей: Найраглал	Ч.Лхагва, УБ, АБЯ, 1988	орос хэлнээс
5	Гилевич Н. Домогт партизануудын алдрын өлгий: шүлэг	Х Мэргэн. //Октябрийн гэрэл, 1987	орос хэлнээс
6	Колас Я. Хавар, Хүүхдийн шүлэг	Г.Дамдин, УБ, 1959	орос хэлнээс
7	Мавр Ливко“Модон халбага” өгүүллэг”	“Соёл утга зохиол” 1959, 1-р сарын 1	орос хэлнээс
8	Мележ.И “Намагт нутгийнхан	Ш.Очирбат, УБ, УХГ, 1978	орос хэлнээс
9	Мележ.И“Үерийн дохио”	Ш.Очирбат, УБ, УХГ, 1978	орос хэлнээс
10	“Хөнгөн ажил”, Белорусс ардын үлгэр	Б.Лувсан, Пионерийн үнэн, 1957, 8-р сарын 6	орос хэлнээс
11	Шамякин.И “Итгэлээр амилсан зүрх”	Ё.Шийхар, УХГ, 1988	орос хэлнээс

2.Болгарын уран зохиол Монголд

Болгарын уран зохиолоос хамгийн анх монгол хэлнээ 1953 онд “Болгарын үгүүлэл найраглалууд” нэртэй номыг Дашдорж орчуулан хэвлүүлжээ. Болгарын уран зохиолоос нийтдээ 100 гаруй зохиолчийн 300 орчим бүтээл болгар, орос, герман хэлнээс орчуулагдаж, нийтийн хүртээл болсон байна. Болгар хэлнээс монгол хэлэнд орчуулж байсан орчуулагчид нь А.Самбалхүндэв, Н.Лхагва, Г.Донид, Б.Жамъянбаатар нар бөгөөд нийтдээ 50 орчим бүтээлийг эх хэлнээс нь монгол хэлэнд буулгажээ. Орчуулагч А.Самбалхүндэв Д.Овадиягийн “Комиссарын тухай дурсамж”, “Партизаныуд-Хурим”, “Уулзалт” зэрэг яруу найргийн бүтээлүүдийг, орчуулагч Н.Лхагва П.Лазаровын “Дархан аварга” (1974), мөн Г.Донидын хамт Л.Левчевийн “Мөнхийн дуулал”, (40 гаруй яруу найраг, 1986), Б.Жамъянбаатар “Улаан сарнай” (1974), Караславов.Г “Ном амссан хулганууд” (1977), Е.Станевын “Намуун орой” (1980) зэрэг бүтээлүүдийг болгар хэлнээс монгол хэлнээ хөрвүүлжээ.

2005 онд Болгарын яруу найрагчдын бүтээлийн цомог “Цэнхэр Пиринийн дуулал” нэртэйгээр Улаанбаатар хотноо хэвлэгдсэн бөгөөд өмнө нь орчуулагдаж байсан 73 зохиолчийн 220 орчим шүлэг, яруу найраг оржээ. 1953-2015 он хүртэлх хугацаанд монголчууд Болгарын 230 орчим яруу найргийн бүтээлийг орчуулсан байна. 1950-1960 онд 25 бүтээл, 1960-1970 онд 11, 1970-1980 онд 9, 1980-1990 онд 48, 1990 оноос хойш 10 бүтээл, тэр дунд 220 гаруй яруу найргийн бүтээл бүхий “Цэнхэр Пиринийн дуулал” багтана. Хүснэгт №2-т болгарын уран зохиолоос монгол хэлнээ орчуулагдсан бүтээлийн тоймыг үзүүлэв.

Хүснэгт №2

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Болгарын үгүүлэл найраглалууд	Дашдорж, УХҮ, УБ, 1953	тодорхойгүй
2	Стефанова Лиляна “Родопын уулс сүндэрлэж байна”	Ч.Лхамсүрэн, Г.Дамдин УБ, УХГ, 1955,	орос хэлнээс
3	“Танхил хүүхэн”, УБ, УХГ,	Г.Дамдин, УБ, 1956,	тодорхойгүй
4	Ботев Х. Хагацан салахад, шүлэг	С.Доржпалам, “Цог”, 1956, №4, 65-66-р талд	тодорхойгүй
5	Вазов И. Ажиллацгаая-Эхдээ	Д.Чимиддорж, “Утга зохиол”, 1956 оны 9 сарын 15	тодорхойгүй

6	Вапцаров Н. Шүлгүүд	Хэн орчуулсан нь тодорхойгүй, УБ,УХГ, 1956	тодорхойгүй
7	Радев Р. Хүний хүсэл зоригоор (найруулал)	Хөдөлмөр, 1956, 9-р сарын 15	тодорхойгүй
8	Анчин хүү-Гал халуун дурлал, Болгар ардын аман зохиолоос	Б.Энэбиш, Утга зохиол, 1957, 9 сарын 15	орос хэлнээс
9	“Залхуу охин” Болгар ардын үлгэр	Д.Содномдаржаа, //Таван хархүү” ном, 1957, 6-8-р тал	орос хэлнээс
10	Мэхтэй хүү- Их зантай хүн, Болгар ардын шог ярианаас	Г.Амар, “Соёл утга зохиол”, 1958, 9-р сарын 3	орос хэлнээс
11	Методиев Дмитрий. Эхнэртээ (Шүлэг), орчуулсан	Б.Энэбиш, “Утга зохиол, 1957, 9-р сарын 15	орос хэлнээс
12	Орлинов О. Болгар эр, (Шүлэг),	Б.Энэбиш, “Утга зохиол, 1957, 7-р сарын 15	орос хэлнээс
13	Овадия Д. Комиссарын тухай дурсамж (Шүлэг)	А.Самбалхүндэв, “Утга зохиол, 1957, 11-р сарын 20	болгар хэлнээс
14	Овадия Д. Партизанууд-Хурим (Шүлэг)	А.Самбалхүндэв, Үнэн, 1957, 10-р сарын 12	болгар хэлнээс
15	Овадия Д. Уулзалт (Партизаны тухай шүлгээс)	А.Самбалхүндэв, “Утга зохиол, 1957, 11-р сарын 7	болгар хэлнээс
16	Овадия Д. Хүү (Шүлэг)	А.Самбалхүндэв, “Соёл утга зохиол”, 1958 оны 7 сарын 2	болгар хэлнээс
17	Ван Босилек О. Ухаантай тариачин (Болгар ардын үлгэр)	А.Самбалхүндэв, “Соёл утга зохиол”, 1958, 9-р сарын 17	орос хэлнээс
18	Вапцаров Н. Ботев, шүлэг	Л.Түдэв, Соёл утга зохиол, 1959, 12-р сарын 3	орос хэлнээс
19	Вазов И. Амьд түүх, шүлэг	Соёл утга зохиол, 1959, 9-р сарын 10	тодорхойгүй

20	Вазов И. Амьд түүх, шүлэг	Сталинч, 1960, 10-р сарын 15	тодорхойгүй
21	Ботев Х. Цэрэг эрчүүл, шүлэг	Ш.Цэндгомбо, “Соёл утга зохиол”, 1960 оны 9-р сарын 9	тодорхойгүй
22	Ботев Х. “Гайдукууд”, шүлгүүд	орчуулагч Ц.Цэдэнжав, УБ, УХГ 1964	тодорхойгүй
23	Баланов П. Торойнууд, хошин өгүүллэг	орч. Ч.Мөнхбаяр//Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
24	“Баян ядуу хоёр” болгар ардын үлгэр	М.Бадарч, Алтан алим үлгэрүүд, 2005	герман хэлнээс
25	Вазов И “Талхинд”	Ш.Доржготов, УБ, УХГ, 1976	орос хэлнээс
26	Вешим М. Саятны төлөөх ангуучлал	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
27	Винаров И. Нууц фронтын дайчид: Баримтат эсээ	Д.Дашдаваа	орос хэлнээс
28	Влайков Тодор. Славчо өвгөний ач охин	Ц.Шагдар, Соёл утга зохиол, 1960 оны 10 сарын 15	орос хэлнээс
29	Вежинов П. “ <u>Мөр үлдсэн нь</u> ”	Г.Дамдин, УБ УХГ 1958	орос хэлнээс
30	Вежинов П. “Хэмжигдэхүүн” орч.	Ц.Шарав, // Оготор шар байшин, УБ, 1984	тодорхойгүй
31	Гуляшки А. “Гэрэлт зам”	Д.Самдан, УБ, УХГ 1966	орос хэлнээс
32	Димов Д. “Тамхи”	Ш.Доржготов, УБ, УХГ, 1967	орос хэлнээс
33	Димов Д. “Тамхи”, дэд дэвтэр	Ш.Доржготов, УБ, УХГ, 1971,	орос хэлнээс
34	Калчев К. Дахиад бас таван сар болж, дахиад бас цэцэг дэлгэрнэ:	Г.Хадбаатар //Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй

35	Караславов Г. “Ном амссан хулганууд”	Б.Жамъянбаатар, УБ АБЯ-ны хэвлэл 1977	болгар хэлнээс
36	Ламар. 9-р сарын 9, шүлэг,	Сталинч, 1960, 10-р сарын 15	тодорхойгүй
37	Лазаров П. “Дархан аварга”	Н.Лхагва, УБ, УХГ, 1974	болгар хэлнээс
38	Левчев Л “Мөнхийн дуулал” яруу найргийн цоморлиг	Г.Донид, Н. Лхагва, УБ, УХГ, 1986	болгар хэлнээс
39	Льочев П. Сугарын дун: Зөгнөлт өгүүллэг	Ц.Хатантөмөр, УБ, 1989	тодорхойгүй
40	Минков С. “Сүрлэн дарга”	Г.Амар, УБ, УХГ, 1959	тодорхойгүй
41	Мишев Г. “Зуслангийн дэнж”, тууж	Ц.Шарав//Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй
42	Младен Исаев “Оргилд хүрэх зам” Шүлэг	М.Ширчинсүрэн, Соёл утга зохиол, 1960, 4-р сарын 21	тодорхойгүй
43	<u>Мөнхийн дууны домог</u>	УБ, УХГ, 1973, тодорхойгүй.	тодорхойгүй
44	Наковский А “Залуу нас осолдуузай”	М.Дэчин, УБ, УХХЭХ 1968	тодорхойгүй
45	Пеев Д. “Болор аяганы нууц” өгүүллэг	Пунцаг, 1991	тодорхойгүй
46	Пеев Д. “Болор аяганы нууц”	Ц.Цэрэн, УБ, УХГ, 1992	тодорхойгүй
47	Пелин Е. Ян Бибиянд тохиолдсон ер бусын явдал	Н.Намжилдорж УБ, 1966,	тодорхойгүй
48	Пелин Е. Ян Бибиян саранд аялсан нь	Ц.Сандаг, УБ, 1976	тодорхойгүй
49	Петров Ивайло “ Нонагийн дурлал”	Д.Цэрэндаш, УБ, УХХЭХ, 1966	орос хэлнээс
50	Пушков И. Хамгийн сайхан цэцэг (найруулал)	“Залуучуудын үнэн”, 1958, 7 сарын 2	тодорхойгүй

51	Радевский Х. Гомдол эрсэн гахай (Шүлэг)	С.Жамбалдорж, “Матар” 1959 №10	орос хэлнээс
52	Стефанова Лиляна Тэр бид хоёр (Шүлэг)	Цэдэнжав “Соёл утга зохиол”, 1958, 5-р сарын 6	тодорхойгүй
53	<u>Станев Е.</u> ” Намуун орой”,	Б.Жамъянбаатар, УБ, УХГ, 1980	болгар хэлнээс
54	Станев Е <u>“Иван Кондарев”</u> , тэргүүн дэвтэр	Ш.Доржготов, УБ, УХГ 1982	орос хэлнээс
55	<u>Станев Е.Иван Кондарев</u> , дэд дэвтэр	Ш.Доржготов, Д. Самдан, УБ, УХГ, 1984	орос хэлнээс
56	Станев Э. “Цасан гэр”	Л.Далхсүрэн, УБ, УХГ, 1970,	тодорхойгүй
57	Станев Е. Дорго: тууж	Ч.Лхагва, //Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй
58	“Тангараг”, Болгарын зохиолчдын шүлэг, өгүүллэгийн эмхтгэл	Ш.Доржготов, Л. Түдэв гэх мэт олон орчуулагч. УБ, 1970	тодорхойгүй
59	Туманов В. Уран бүтээлийн зовлон: хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
60	Улаан сарнай, УБ, УХГ, 1974	Б.Жамъянбаатар	болгар хэлнээс
61	Цэнхэр Пиринийн дуулал, Болгарын яруу найрагчдын бүтээлийн цомог, 73 зохиолчийн 220 орчим шүлэг, яруу найраг	Олон орчуулагчтай, УБ, 2005	болгар, орос
62	Хайтов Н. “Край буюу гэрлэхийн учир”	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
63	Цонев К. Нэн сонирхолтой ном, хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр//Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй

Монгол хэлнээ орчуулагдсан Болгарын уран зохиолын сэдэв нь залуу нас, хайр сэтгэл, ажил хөдөлмөр, эх орон, хувьсгал, дэлхийн дайн, байгаль дэлхий, шог хошин, уран зөгнөл гэх мэт өргөн хүрээг хамарчээ.

3.Польшийн уран зохиол Монголд

Польш хэлнээс анхлан монгол хэлэнд 1955 онд нэрт дуун хөрвүүлэгч, зууны манлай эрдэмтэн Б.Ринчен “Адам Мицкевич” гэсэн номыг хөрвүүлжээ. Польшийн уран зохиолыг монголчууд польш, орос, эсперанто, солонгос хэлнээс орчуулсан байна. Б.Ринчен польш хэлнээс “Гурван алим (УБ, 1966), “Солонго” (1970), “Чандруу Алмас хоёр” (1978) зэрэг бүтээлүүдийг, Д.Ким “Хамгаас хөөрхөн” (1967), “За одоо ууцгаая” (1990), “Өглөөгүүр шуурга өнгөрлөө” (1989) зэргийг, Р.Санжаасүрэн “Эрхэм Жонс та хүн мөн үү?” (1967), С.Аюуш “Осол” (1983) бүтээлүүдийг польш хэлнээс монгол хэлэнд орчуулсан байна. Орчуулагч Ч.Догсүрэн П.Болеславын “Фараон” романыг 1981, 1983 онд эсперанто хэлнээс орчуулан гаргажээ. Х.Сенкевичийн “Күо Вадис” (2010) романыг М.Амартайван солонгос хэлнээс орчуулсан байна. 1955-2015 оны хугацаанд польшийн уран зохиолоос 40 орчим бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлэн нийтийн хүртээл болгосон ажээ. 1953-1960 онд 12, 1961-1970 онд 6, 1971-1980 онд 8, 1981-1990 онд 6, 1990-2000 онд огт орчуулаагүй. 2004 оноос өнөөг хүртэл 5 орчуулгын бүтээл тус тус хэвлэгджээ.

Хүснэгт №3

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он,	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Адам Мицкевич	Б.Ринчен, УБ, УХГ, 1955	польш хэлнээс
2	Андшеевский И. “Чандруу Алмас хоёр”	Б.Ринчен, УБ, УХГ, 1978	польш хэлнээс
3	Анитц Б. “Араатны дунд гар хоосон”	УБ, 1972	тодорхойгүй
4	Билински В. “Осол”	С.Аюуш, УБ, УХГ, 1983,	польш хэлнээс
5	Болеслав П. “Фараон”	Ч.Догсүрэн, УБ, УХГ, 1981, 1983	эсперанто хэлнээс
6	Болеслав П. “Фараон”	Ч.Догсүрэн, УБ, УХГ, 1983	эсперанто хэлнээс

7	Броневский Б. “Шүлгүүд”	Ц.Цэдэнжав, УБ, УХҮ, 1953	орос хэлнээс
8	Броневская Я.” Суманд сөгдөөгүй хүний тухай”	Ж.Аминдаваа, УБ, УХХЭХ, 1955,	орос хэлнээс
9	Болжморын шаахай, Польш ардын үлгэр	Д.Содномдаржаа, Таван хархүү ном, 1957	орос хэлнээс
10	Ванда Василевска “Солонго”	Б.Ринчен, УБ, УХГ, 1970	польш хэлнээс
11	Галчинский К. И. Чөлөөт Варшав (шүлэг)	Г.Дамдин, Соёл, утга зохиол, 1959, 10-р сарын 23	орос хэлнээс
12	Генрих Сенкевич “Гурван хүүхдийн хувь заяа”	З.Саарал,УБ, УХГ, 1968	тодорхойгүй
13	Гисгес Ян Марина. Улаанбаатар дээрх саран (шүлэг)	Хэн орчуулсан нь тодорхойгүй. Үнэн, 1960, 5-р сарын 15	тодорхойгүй
14	Гурван алим	Б.Ринчен, УБ, УХГ, 1966	польш хэлнээс
15	Сат-ок “Нууц мөрөөр”	Д.Догсомжав, УБ, Мөнхийн үсэг, 2006	тодорхойгүй
16	Сат-Ок “Давст хадны хөндий”	Д.Догсомжав, УБ, Мөнхийн үсэг, 2006	тодорхойгүй
17	Домбровска М. “За одоо ууцгаая”	Д. Ким, УБ, УХГ, 1990	польш хэлнээс
18	Кертиес И.”Хүн заяа ноогдоогүй нь”	Г.Бошигт, 2005, УБ, УХГ	тодорхойгүй
19	Корчак Я. “Эргээд хүүхэд болсон чинь”,	С.Галсан, УБ, АБЯ, 1976,	тодорхойгүй
20	Котович В. “Фронтын зам”	С.Аюуш, УБ, УХГ, 1980,	тодорхойгүй

21	Лем С. “Эрхэм Жонс та хүн мөн үү?”	Р.Санжаасүрэн, УБ, УХГ, 1967	польш хэлнээс
22	Маринович А. “Тодорхойлолт гурван шүлэг”	Л.Отгон, “Матар” 1960 №10	орос хэлнээс
23	Махеек В. “Өглөөгүүр шуурга өнгөрлөө”	Д.Ким, УБ, УХГ, 1989	польш хэлнээс
24	Мокрский Я. Үнэн юм биш байгаа: Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр, Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй
25	Наранцэцэг: польш шүлэг, өгүүллэгийн түүвэр	Л.Дашням, УБ, УХГ, 1974	польш хэлнээс
26	Овсяный Г. “Дайн үүссэн нууц”	Хэн орчуулсан нь тодорхойгүй, 1974 он	польш хэлнээс
27	Остроменский. Б. Захидал-Шаахай (шүлгүүд)	Ш.Цэндгомбо, Соёл утга зохиол, 1958, 11-р сарын 19	орос хэлнээс
28	Тариачны өргөдөл, Польш ардын үлгэр	Д.Содномдаржаа, Таван хархүү ном, 1957	орос хэлнээс
29	Тувим Ю. Жийв жийв (шүлгүүд),	С.Бадраа, УБ, 1956	орос хэлнээс
30	Ружевич Т. Хүсэл, Тадеуш Боровскийн дурсгалд, (шүлэг)	Хэн орчуулсан нь тодорхойгүй. Утга зохиол, 1957, 4-р сарын 17	орос хэлнээс
31	Сенкевич Х. “Күо Вадис”	М.Амартайван, УБ, Мөнхийн үсэг, 2010	солонгос хэлнээс
32	Фидлер А. Бяцхан Бизон	Б.Чимид-Очир, УБ, АБЯ, 1970	тодорхойгүй.
33	Шельбур-Зарембина Э. “Хамгаас хөөрхөн”	УБ, Д.Ким, 1967	польш хэлнээс
34	Шмаглевска С.	Ц.Шүгэр, УБ, УХГ,	орос хэлнээс

	“Биркенаугийн утаа”	1975	
35	Юлиан К. Сорви, өгүүллэг	Б.Сүрэн, Залгамжлагч, 1960 №6	орос хэлнээс
36	Янчарский Ч. Дэлдэн бамбаруушийн хөгтэй явдал	Хэн орчуулсан нь тодорхойгүй. УБ, УХГ, 1978	тодорхойгүй.

Монгол хэлнээ орчуулагдсан Польшийн уран зохиолын гол сэдэв нь Фашизмын эсрэг Польшийн ард түмний хийсэн тэмцэл, Дэлхийн I, II дайн, эх орноо хамгаалах үзэл, уран зөгнөл, хөгтэй явдал, түүх домог зэрэг байна.

4. Словакийн уран зохиол Монголд

Чехословак улс 1955 онд Монгол улстай дипломат харилцаа тогтооход Чех, Словак хоёр хамтдаа холбооны бүтэцтэй улс байсан тул ихэнх тохиолдолд чех, словак уран зохиолыг ялгалгүй хамтад нь орчуулж байсан. Гэхдээ Монголд хэвлэгдсэн Словакийн уран зохиол Чехийн уран зохиолыг бодвол тооны хувьд цөөн байдаг. Анхны словак зохиолууд нэрт орчуулагч Д.Алтангэрэлийн чех болон словак хэлнээс орчуулсан “Тэнгэрийн элч”, УБ, 1970 бүтээлд анхлан хэвлэгдсэн. Үүний дараагаар Д.Алтангэрэл “Төөрөлдсөн хүнтэй уулзсан нь”, “Учрал” (Чех, Словакийн зохиолчдын өгүүллэг, УБ, УХГ, 1987) зэргийг орчуулан гаргасан. 1985 онд Ц.Цэрэн Я.Есенскийн “Братиславын булшнаа”, 1987 онд орчуулагч Д.Алтанхуяг В.Завадагийн “Алдар нэрийг би горилохгүй”, Я.Кострагийн “Братиславын хавар” (Утга зохиол, урлаг №19) зэргийг орчуулан нийтлүүлжээ. Словак хэлнээс уран зохиолыг голчлон орчуулсан хүн бол Д.Алтангэрэл болно.

Хүснэгт №4

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он,	Монгол хэл рүү орчуулсан хэл
1	Есенский Я. “Братиславын булшнаа”	Утга зохиол, урлаг №19, 1985, орч. Ц.Цэрэн	тодорхойгүй.
2	Завада В. “Алдар нэрийг би горилохгүй”	Д.Алтанхуяг, 1987 (Утга зохиол, урлаг №19)	тодорхойгүй
3	Клара Я. “Төөрөлдсөн хүнтэй уулзсан нь”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1986	словак хэлнээс

4	Костра Я. “Братиславын хавар”	Утга зохиол, урлаг №19	тодорхойгүй.
5	Учрал” Чех, Словакийн зохиолчдын өгүүллэг	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1987	чех болон словак хэлнээс
6	“Тэнгэрийн элч”	Д.Алтангэрэл, УБ, 1970	чех болон словак хэлнээс

Монгол хэлнээ орчуулагдсан Словакийн уран зохиолын сэдэв нь Дэлхийн I, II дайн, дайны үеийн баатрууд, эх орныхоо төлөө тэмцсэн ард түмний тэмцэл гэх зэрэг байна.

5.Украины уран зохиол Монголд

Украины уран зохиолоос хамгийн анх 1956 онд украины зохиолч О.Кравецкийн Ханьпугийн охин, зохиолыг Шаравжамц орчуулжээ. Үүнээс хойш Д.Гомбожав Т.Г.Шевченкогийн “Зарц бүсгүй” (УБ, 1964), Д.Дашдаваа М.В.Гаршины “Дөрвөн хоног” (УБ, 1965), 1968 онд М.Дарамваанчиг М.Стельмахын “Хүний цус ус биш” зохиолыг, Д.Чойжил Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” (УБ, 1969), Л.Түдэв М.Стельмахын “Хун цэнгийн цуваа” (УБ, 1970), Ч.Лхагваа, Ю.Яновскийн “Морьтон” (УБ, 1972), Г.Амар О.Гончарын “Хонх” (УБ, УХГ, 1976), Д.Алтангэрэл Р.Кочарын “Хүү эргэж ирлээ” (1986), Б.Энэбиш В.Сосюрагийн “Украин минь” (УБ, 1987), С.Баясгалан Н.Бажаны “Намрын хөгжим” (УБ, 1987), Д.Баасанжав В.Орлёнокгийн “Буун дуугүй операц” (УБ, 1989) гэх зэрэг бүтээлүүдийг орос хэлнээс орчуулж, нийтийн хүртээл болгосон байна. Украины уран зохиолоос нийтдээ 20 орчим бүтээл монгол хэлэнд орчуулагдсан байна. Эдгээрээс хамгийн алдартай нь Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” зохиол болно.

Хүснэгт №5

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Бажан Н. “Намрын хөгжим”, шүлэг	С.Баясгалан, УБ, 1987	орос хэлнээс
2	Гаршин М. В. “ Дөрвөн хоног”	Д.Дашдаваа, УБ, УХХЭХ, 1965	тодорхойгүй.
3	Гончар О. “Хонх”	Г.Амар, УБ, УХГ, 1976	орос хэлнээс
4	Дольд Михайлик Ю. “Ганц дайчин	Д.Чойжил, УБ, УХГ, 1969	орос хэлнээс

	ганцаардахгүй”		
5	Жванецкий М. “Мэс засалч”, Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
6	Жванецкий М. “Шлягер” Флюгерийн эсрэг, хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйнгайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
7	Кочар Р. “Хүү эргэж ирлээ” өгүүллэг	Д.Алтангэрэл //Мөнхийн дурсгал, 1986	орос хэлнээс
8	Кравець О. Ханьпугийн охин	Шаравжамц, УБ, УХГ, 1956	тодорхойгүй.
9	Макивчук Ф. “Оносон нэрд би дуртай”, Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
10	Орлёнок В. “Буун дуугүй операц”	Д.Баасанжав, УБ, УХГ, 1989	тодорхойгүй.
11	Руденко Б. “Бурхан нуур” уран зөгнөлт өгүүллэг	Пүрэвдагва // уран зөгнөлт тууж өгүүллэгүүд, УБ, 1984	тодорхойгүй.
12	Сосюра В. “Украин минь”, шүлэг	Б.Энэбиш, Октябрийн гэрэл, УБ, 1987	тодорхойгүй.
13	Стельмах М. “Хун цэнгийн цуваа”	Л.Түдэв, УБ, АБЯ, 1970	тодорхойгүй.
14	Стельмах М.”Хүний цус ус биш”	М.Дарамваанчиг, УБ, 1968	орос хэлнээс
15	Украинка Л. “Тариан түрүүхэн”	Ц.Шагдар, УБ, 2011, Содпресс	орос хэлнээс
16	ШевченкоТ.Г.“Зарц бүсгүй”	Д.Гомбожав, УБ, УХХЭХ, 1964	тодорхойгүй
17	Яновский Ю “Морьтон” роман	Ч.Лхагваа, 1972, УБ, УХГ	орос хэлнээс

Украины уран зохиолоос монгол хэлнээ орчуулагдсан бүтээлүүдийн сэдэв нь Дэлхийн I, II дайн, дайны үеийн тагнуулын бодлого, ажил хөдөлмөр, баатарлаг үйлс зэрэг байна.

6. Чехийн уран зохиол Монголд

Чехийн уран зохиолоос хамгийн анх 1951 онд Б.Ринчен Ю.Фучикийн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” номыг орчуулсан байна. Чехийн уран зохиолыг монголчууд орос, чех, герман хэлнээс орчуулсан бөгөөд чех хэлнээс орчуулж байсан орчуулагч нар нь Б.Ринчен, Д.Алтангэрэл, Г.Дашдаваа, Б.Энэбиш, П.Нямаа нар болно. Б.Ринчен Алойс Йираасекийн “Эртний чех домог тууж”-ийг 1965 онд, “Чехийн эртний домог II”-ийг 1968 онд тус тус орчуулан хэвлүүлсэн.

Д.Алтангэрэл чех, словак хэлнээс Юлиус Фучикийн “Коммунизмын тугийн дор”, Марије Пуймановагийн “Амьдрал”, Иржи Марекийн “Уулзахын ерөөл”, Вацлав Ржезачийн “Долоон танк”, Ян Дрдагийн “Байлдагч Станда”, Марије Маеровагийн “Хотын захын хориглолт”, Людвик Ашкеназийн “Сонгино”, Франтишек Куфкагийн “Цэцгийн багц”, Петр Йилемницкийн “Тэнгэрийн элч”, Рудольф Калчикийн “Ганцаардал”, Владимир Миначийн “Шийдэхийн өмнөхөн” зэрэг өгүүллэгүүдийг Д.Бадарчийн хамт орчуулан “Тэнгэрийн элч” (УБ, 1970) гэсэн нэрээр гаргав. Чехийн зохиолч Ян Отченашекийн “Ромео, Жульетта хоёр харанхуйд” буюу “Romeo, Julie a tma” (1958) бүтээлийг 1975 онд, Козакийн “Михал дарга” зохиолыг 1981 онд, Карел Чапекийн “Тожмой луутай тулалдсан нь” 1988 онд Д.Алтангэрэл орчуулан Улаанбаатар хотноо хэвлэсэн байна.

Г.Дашдаваа Пуйманова Мариегийн “Галаар наадвал” роман (УБ, 1974), Божена Немцовагийн “Эмээ” (УБ, 1987) романыг чех хэлнээс орчуулж, нийтийн хүртээл болгожээ. Витезслав Незвалын “Энх тайвны дуу” яруу найргийн түүвэр (орч. Х. Пэрлээ, УБ, 1954), Дрда Яны “Өгүүллэгүүд” (УБ, 1952), Марек Иржигийн “Манайд үүр гийлээ” (УБ, 1955), “Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд, (УБ, 1956), Ян Амос Коменский (УБ, 1958), Ярослав Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” (УБ, 1965, 2009), Юлиус Фучикийн “Холбоочны гурван үсэг”(УБ, 1966), Ян Ленчогийн “Дурсамж” (УБ, 1989), Карла (УБ, 1956) Карел Чапекийн “Илд бамбай” (1993), Франц Кафкагийн “Шүүх ажиллагаа” (УБ, 2009) зэрэг бүтээлүүдийг монгол хэлнээ хөрвүүлжээ. Чехийн уран зохиолоос Монголд алдаршсан нь орчуулагч Ш.Очирбатын орос хэлнээс орчуулсан Ярослав Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” болно. 1951-1960 онд 20, 1961-1970 онд 5, 1971-1980 онд 4, 1981-1990 онд 28, 1991-2000 онд 9 бүтээл орчуулагдаж нийтийн хүртээл болжээ. 2010 онд МУИС-ийн чех судлалын төгсөгчид багшийн хамтаар “Чехийн шилдэг үлгэрүүд” номыг орчуулж нийтийн хүртээл болгожээ.

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулсан
1	Адам Иржи. Марианы Лазнид байгаа Улаанбаатарын оюутнууд, найруулал	Залуучуудын үнэн, 1957, 4-р сарын 6	тодорхойгүй
2	Алоис Й. “Эртний чех домог тууж”	Б.Ринчен, УБ, УХХЭХ, 1965	чех хэлнээс
3	Алоис Й. “Чехийн эртний домог”	Б.Ринчен, УБ, УХХЭХ, 1968	чех хэлнээс
4	Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд	У.Лийгаа, УБ, 1956	тодорхойгүй
5	Алин Лайчиах. “Ильичийн байранд” шүлэг	Б.Жамц, Соёл утга зохиол, 1960 4-р сарын 21	тодорхойгүй
6	Буриан Э. Ф. Шинэ жилээр болсон явдал: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
7	Вайсс Я. Цуутай нохой: өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
8	Гаск Иржи “Төвийг сахьсан нутаг”	Д.Алтангэрэл, УБ, 1983	чех хэлнээс
9	Гашек Я. “Нэргүй захидал”, өгүүллэг	Д.Даш, “Туяа”, 1958 №1 18-р талд	орос хэлнээс
10	Гашек Я. Барон Клейнгамплийн аж ахуйн өөрчлөлт, өгүүллэг	Г.Амар “Матар”, 1959 №11, 8-р талд	орос хэлнээс
11	Гора И. “Улаан талбайд” шүлэг	Г.Дамдин, Соёл, 1957 №3, 12-р талд	орос хэлнээс
12	Дрда Я. “Өгүүллэгүүд”	Хэн орчуулсан нь тодорхойгүй. УБ, 1952	тодорхойгүй
13	Дрда Я. Гурав дахь фронт: өгүүллэг	Б.Энэбиш, //Учрал, УБ,	чех хэлнээс

		УХГ, 1987	
14	Запотоцкий А. “Барунка” өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
15	Илемницкий П. “Салхи эргэлээ”	Г.Дашдаваа, УБ, 1979	чех хэлнээс
16	Кайнер И. “Чехийн эрмэлзэл”	М.Цэрэндорж, Утга зохиол, 1957 4-р сарын 5	орос хэлнээс
17	Козак. Я. “Михал дарга”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1981	чех хэлнээс
18	Кальчик Р. Мариенка, өгүүллэг	орч. Б.Энэбиш, //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
19	Кожик Ф. Ажилчин: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
20	Козак Я. Алдарт ой: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
21	Кубка Ф. Хөгжмийн уянга	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
22	Ленчо Я. “Дурсамж”	П.Нямаа, УБ, 1989	чех хэлнээс
23	Маерова Марие “Хөгжөөнт үлгэрийн цоморлиг”	Хэн орчуулсан нь тодорхойгүй, УБ, АБЯ, 1979	тодорхойгүй
24	Марек Иржи “Манайд үүр гийлээ	Ц.Дүгэрсүрэн, УБ, 1955	тодорхойгүй
25	Марек Иржи. “Нэгэн эхийн яриа” өгүүллэг	Д.Намдаг, Цог, 1960 №6 40-46 талд	герман хэлнээс
26	Майерова М. Улаан туг: өгүүллэг	Б.Энэбиш, //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
27	Мориц Ю. Ягаан муурын нууц, 61 шүлэг,	олон орчуулагчтай. УБ, 1991	тодорхойгүй
28	Незвал В. “Энх тайвны дуу”	Х.Пэрлээ, УБ, 1954	тодорхойгүй

29	Незвал В. “Хамгийн сайхан үнэр, гэвэл...” шүлэг	Соёл утга зохиол, 1959, 10-р сарын 15	тодорхойгүй
30	Немцова Б. “Эмээ”, роман	Г.Дашдаваа, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
31	Новый К. 1945 оны майн нэгэн, өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
32	Отченашек.Я “Ромео Жульетта хоёр харанхуйд”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1975	чех хэлнээс
33	Ольбрахт И. Оросын пролетарийн хувьсгалд талархдаг минь: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
34	Отченашек Я. Бухал өвсний яриа: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
35	Пуйманова М. “Галаар наадвал” роман	Г.Дашдаваа, УБ, 1974	чех хэлнээс
36	Пуйманова М. Учрал: өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
37	Плухарж З. Бороонд бүүвэйлэгдсэн нь: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
38	Ржиха Б. Азарган тахиа: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
39	Руми И. “Хүү нь болох төвөгтэй” өгүүллэг	Д.Гомбодорж, Сүхбаатарын зам, 1960, 5-р сарын 1	орос хэлнээс
40	Сватоплук Г. Готвальдад бичсэн захидал: өгүүллэг,	орч. Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
41	Секера Й. Партизаны элч: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
42	Стрнадель И. Цонхны доор цуурайтна: өгүүллэг	орч. Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
43	Сургуультай нохой, Чех ардын үлгэр	Д.Содномдаржаа, 1957	орос хэлнээс
44	Томан Й. Замын эхэн:	Д.Алтангэрэл //Учрал,	чех хэлнээс

	өгүүллэг	Уб, УХГ, 1987	
45	Тэнгэрийн элч, чех, словакийн зохиолчдын өгүүллэг	Д.Алтангэрэл, УБ, 1970	чех, словак хэлнээс
46	Флариан М. Улаан цэрэг Рудо армейци, шүлэг	Б.Ринчен, “Утга зохиол, 1957, 7-р сарын 28	чех хэлнээс
47	Франц Кафка, Шүүх ажиллагаа	Ц.Сүхбаатар, Дэлхийн сонгодог зохиол, 19-р боть, Монсудар, УБ, 2009	орос хэлнээс
48	Фрид Н. Хавх: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, Уб, УХГ, 1987	чех хэлнээс
49	Фучик Ю. Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл	Б.Ринчен, УБ, 1951	чех хэлнээс
50	Фучик Ю. “Холбоочны гурван үсэг”	орч. Д.Хишигжаргал, УБ, 1966	тодорхойгүй
51	Фучик Ю. Мөнх орших үйлс	А.Самбалхүндэв, Соёл утга зохиол, 1960, 4-р сарын 21	тодорхойгүй
52	Фучик Ю. Бодит өгүүллэг	Б.Энэбиш//Учрал, Уб, УХГ, 1987	чех хэлнээс
53	Хашек Я.Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал	Ш.Очирбат, УБ, УХГ, 1965, Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган, 36-р боть, УБ, Монсудар, 2009	орос хэлнээс
54	Хнеупек Б. Арслангийн одонт генерал: сурвалжлага, найруулал	орч. Б.Дашцэрэн, 1987	тодорхойгүй
55	Чапек К. “Тожмой луутай тулалдсан нь”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1988	чех хэлнээс
56	Чапек К. Хүний аминд халдсан нь: өгүүллэг, 1991	Д.Алтанхуяг //Алмас эрдэнийн хулгайч, Илд бамбай ХГ, УБ,	тодорхойгүй
57	Чапек К. Жүжигчин алга	орч. Ц.Барадий //Илд	тодорхойгүй

	болсон нь: өгүүллэг	бамбай, 1992	
58	Чапек К. Ноён Гиршийн сураг тасарсан нь: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
59	Чапек К. Оплатагийн мөхөл: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
60	Чапек К. Профессор Роусын туршилт: хошин детектив	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
61	Чапек К. Тасалбар: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
62	Чапек К. Шуудан дээр гарсан гэмт хэрэг: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
63	Чапек К. Яруу найрагч: өгүүллэг	Д.Алтанхуяг //Алмас эрдэнийн хулгайч, Илд бамбай ХГ, УБ, 1991	тодорхойгүй
64	Шайнер Д. Магтаал дуутай адил буюу: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
65	Чехийн шилдэг үлгэрүүд	Д.Энхжаргал болон бусад, 2010	чех хэлнээс
66	Эрдэмтэй нохой, Чех ардын үлгэр, “Унших бичиг”	Бага сургуулийн 4-р ангид үзнэ. 1959	тодорхойгүй
67	Ян Амос Коменский	Тодорхойгүй. УБ, 1958	тодорхойгүй

Монгол хэлнээ орчуулагдсан чехийн уран зохиолын сэдэв нь түүх домог, дэлхийн I, II дайн, шүүх, гэмт хэрэг, хууль, хувьсгал, хайр сэтгэл, байгаль дэлхий, чехийн ёс заншил, хөдөөгийн амьдрал гэх зэрэг байна.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд Украин, Белорусс, Болгар, Чех, Словак, Польш зэрэг зургаан улсын уран зохиол Монголд орчуулагдаж, нийтийн хүртээл болсон тухай өгүүлж байна. Эдгээр улсын уран зохиолын орчуулга дараах онцлогийг агуулж байна.

- Бидэнд буй судалгааны материалаас үзэхэд, Украин болон Белоруссын уран зохиолыг орос хэлнээс орчуулсан байна. Оросоос бусад слав хэлтэн

- улсуудын уран зохиолыг монголчууд болгар, орос, герман, словак, чех, польш, эсперанто, солонгос хэлнээс монгол хэлэнд хөрвүүлжээ. Монголчууд Оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос 500 орчим бүтээлийг орчуулан, хэвлэсэн байна.
- Нийт бүтээлүүдийг ямар хэлнээс орчуулсныг мэдэх боломжгүй байна. Учир нь зарим бүтээлүүдэд аль хэлнээс орчуулсныг заагаагүй байна. Монгол улсын төв номын сан, Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сан, МУИС-ийн номын сангуудад байгаа бүтээлүүдийн зарим нь аль хэлнээс орчуулагдсан нь тодорхойгүй, тэр бүү хэл урагдаж хуучирсан, орчуулагчийн талаарх мэдээлэл байхгүй зэрэг нь судалгаанд хүндрэл учруулж байна.
 - Украин, Белорусс, Болгар, Чех, Словак, Польш зэрэг 6 улсын уран зохиолоос монголчууд орчуулахдаа ихэнхийг нь орос хэлнээс орчуулсан байна.
 - Орчуулагдсан бүтээлийн тооны хувьд хамгийн олон бүтээлийг Болгарын уран зохиолоос орчуулжээ. Зохиолын хэмжээгээр белорусс, болгар, чех, польш, украины уран зохиолоос нэлээд томоохон хэмжээтэй романууд орчуулагдсан нь ажиглагдаж байна.
 - Оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос болгар, чех, польшийн уран зохиолыг тухайн эх хэлнээс нь орчуулж байсан байна. Польш, Чехийн уран зохиолыг польш, чех хэлнээс эрдэмтэн Б.Ринчен орчуулжээ.
 - Польшийн уран зохиолыг польш хэлнээс дагнан орчуулж байсан орчуулагч нь эрдэмтэн Б.Ринченгээс гадна Д.Ким байна. Словак, Чех, Украины уран зохиолыг словак, чех, орос хэлнээс Д.Алтангэрэл орчуулсан байна. Болгар хэлнээс монгол хэлэнд дагнан орчуулж байсан орчуулагчид нь А.Самбалхүндэв, Н.Лхагва, Г.Донид, Б.Жамъянбаатар нар байна. Белорусс, украин хэлнээс орчуулсан баримт олдсонгүй.
 - Монгол хэлнээ орчуулагдсан оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолын нийтлэг сэдэв нь дэлхийн I, II дайны үеийн түүх, хувьсгал, эх орон үндэстний төлөө тэмцэл зэрэг байна.
 - Монгол хэлнээ орчуулагдсан оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос хамгийн ихээр нийтэд түгэн дэлгэрч, нэрд гарсан бүтээлүүд нь Чехийн зохиолч Ю.Фучикийн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл”, Я.Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал”, Украины зохиолч Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” зэрэг бүтээлүүд болно.

Номзүй

1. Гадаадын уран зохиолыг монгол хэлээр орчуулсан нь (1956-1960), Эмхтгэсэн Д.Бүрэндалай, УХХЭХ, 1963

2. Монгол улсад хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүйн бүртгэл (1985-2005), УБ, 2007
3. Шархүү А.Дагвадорж, Ч.Галбаяр, Г.Гүн-Үйлс, Дэлхийн уран зохиолын бага нэвтэрхий толь
4. Энхжаргал.Д (2010) Монголын уран зохиол Чехэд, Гадаад хэл соёл судлал, №333(14), 65-74
5. Энхжаргал.Д(2015) “Монгол хэлнээс чех хэлэнд, чех хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан бүтээлүүд”, Acta Mongolica, ISSN:20741014, vol.16 (426), 254-263 <http://ims-num.org/acta-mongolica> -сэтгүүл-боть15/ open access

СОЛОНГОСЫН УТГА ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТОЙМ

Г. Эрдэнэчимэг⁶⁰

Товч утга: Солонгосын уран зохиолыг монгол хэлээр орчуулсан бүтээлийг 1990-ээд оноос өмнөх ба хойшихи гэж хоёр ангилж болно. 1990-ээд оныг зааг болгон авч үзсэний учир нь энэ үеэс солонгос хэлтэй үндэсний мэргэжилтэй боловсон хүчинг Монголын их дээд сургуулиудад бэлтгэж эхлэсэнтэй холбоотой. Энэхүү өгүүлэлд 1990-ээд оноос хойшихи Солонгосын утга зохиолыг монгол хэлээр орчуулсан байдлыг тоймлон өгүүлэв. Дипломат харилцаа тогтоосноос хойшихи хугацаанд чамгүй тооны бүтээлийг орчуулж, монгол уншигчидад танилцуулсан бөгөөд үүнд БНСУ-ын утга зохиолын орчуулгын сангуудын дэмжлэг тусалцаа чухал үүрэг гүйцэтгэв. Ялангуяа Солонгосын эртний сонгодог уран зохиолын хоёр ч бүтээлийг монгол сонгодог бичгийн хэлээр чадварлаг орчуулсан нь анхаарал татаж байна. Үүний зэрэгцээ чанарын хувьд тун тааруухан бүтээл ч гарсаар байгаа нь орчуулгын шүүмж хөгжихгүй байгаагаар тодорхой хэмжээгээр холбоотой тул сүүлийн хорь гаруй жил солонгос хэлнээс орчуулга хийж, туршилага хуримтлуулсан орчуулагч нар энэ чиглэлээр манлайлан ажиллах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Монгол солонгос орчуулга, солонгос монгол орчуулга, яруу найргийн орчуулга, үргэлжилсэн үгийн зохиолын орчуулга, эртний сонгодог уран зохиол

Социализмын үед монгол уншигчид гадаадын уран зохиолтой танилцахдаа голцуу орос хэлнээс монгол хэлээр орчуулсан бүтээлтэй танилцаж ирсэн бөгөөд тухайн үед орчуулгын бүтээл хатуу цензур дамжисны дараа хэвлэгдэн олон нийтийн гарт хүрдэг байсан тул уншигчидад дэлхийн сонгодог уран зохиолын амт шимтийг зүй ёсоор нь мэдрүүлсэн гайхамшигтай бүтээлүүд гарч байжээ. 1990-ээд оноос Монгол улс нийгмийн шинэ тогтолцоо руу шилжин орсноор утга зохиолын орчуулга ч бас хөгжлийн өөр шат руу шилжин оров. Хоёр дахь гадаад хэлээр орос бус англи хэлийг сонгосноос хойш урьд өмнө нь хаалттай байсан дэлхийн олон орны уран зохиолыг англи юм уу тухайн хэлнээс нь монгол хэлээр орчуулж эхлэлээ. Хуучин системийн үед уран зохиолын орчуулгыг голцуу авьяас билгээрээ тодорсон зохиолч нар хийдэг байсан бол энэ үеэс гадаад хэлийг тодорхой хэмжээнд эзэмшсэн бол хэн ч хийх боломжтой болов. Шинэ үеийн орчуулагч нарын орчуулах ур чадвар, орчуулгын чанар ахмад

⁶⁰ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн багш, докторант

үеийнхний түвшинд хүрэхгүй байгааг шүүмжлэн хэлэх дуу хоолой ч цөөнгүй сонсогдож байна.⁶¹

2005 онд ШУТИС-ийн багш Н.Мэнд МУИС-ийн ГХСС-ийн Солонгос судлалын тэнхмээс эрхлэн гаргасан “Солонгос судлал” сэтгүүлд “Монгол хэлээр орчуулсан Солонгосын уран зохиолын тойм” хэмээх өгүүлэл хэвлүүлсэн юм. Уг өгүүлэлд 1921-1990 онд монголоор орчуулсан гадаадын уран зохиолын болон монгол номын бүртгэл, номзүйн цуврал ном болон 1990 оноос хойш гарсан төвийн сонин сэтгүүлийг шүүрдэн нягталж, монгол хэлээр орчуулсан солонгосын уран зохиолын номзүйг гаргахыг зорьсон байна.

2010 онд доктор Д.Сайнбилэгт “Монгол хэлээр орчуулсан Солонгосын уран зохиолын тухай” илтгэлийг солонгос хэлээр тавьсан. Дээрхи хоёр судлаачийн судлагаанд 1990-ээд оноос өмнөх орчуулгын талаар дэлгэрэнгүй дурдсан тул 1990-ээд оноос хойшхи орчуулгын талаар голлон авч үзье.

1990 онд БНСУ-тай Монгол улс дипломат харилцаа тогтоож, 1991 оноос Монголын их дээд сургуулиудад солонгос хэлтэй үндэсний боловсон хүчин бэлтгэж эхлэсэн билээ. Энэ үеэс эхлэн монгол уншигчид Өмнөд Солонгосын уран зохиолын шилдэг бүтээлтэй танилцаж эхлэв. Солонгосын дунд, ахлах сургуулийн уран зохиолын хичээлийн хөтөлбөрт тусгагдсан 1930-аад оны шилдэг өгүүллэгүүдээс дээжлэн орчуулж “Солонгос өгүүллэгийн дээжис” эмхтгэлийн 1-р дэвтэрийг 1997 онд гаргасан бөгөөд орчуулгыг доктор Б.Лхагваагийн удирдлагаар МУИС-ийн анхны солонгос хэлний ангийн оюутнууд гүйцэтгэсэн юм. 2000 онд “Солонгосын шилдэг өгүүллэгийн дээжис” эмхтгэлийн 2-р дэвтрийг гаргасан ба түүнд 1920-оос 1990-ээд оны утга зохиолын шагнал хүртсэн өгүүллэгүүд оржээ.

Яруу найргийн орчуулга мөн багагүй хийж ирсэн ба 1997 онд яруу найрагч Гү Жүнъ хой-н “Өмнөд Солонгосоос нисч ирсэн шувуу” (орчуулсан Ж.Баттөр, Д.Сайнбилэгт, Сон Ыи минь) хэмээх шүлгийн эмхтгэл гарав.

Монголоор орчуулсан яруу найргийн бүтээл дундаас хамгийн их анхаарал татаж буй нь “Солонгосын сонгодог яруу найраг”, “Орчин цагийн Солонгосын шүлэг” (орчуулсан Квөн Сон хүн, Д.Дамба тэргүүн дэвтэр, 2005, дэд дэвтэр 2007, Мэргэн үгс ХХК) болно. Солонгосын яруу найргийг монгол хэлээр уран яруу орчуулсан, орчуулгын чанарын хувьд хамгийн сайн болсон бүтээл юм. Үүнээс гадна “Солонгосын шилдэг 50 шүлэг” (орчуулсан И Анна, Улаанбаатар ИС, 2006), Ким Соверийн шүлгийн түүврийн орчуулга болох “Агарууны цэцэг” (орчуулсан Д.Нармандах) зэрэг эмхтгэл бий. Сүүлийн жилүүдэд Монгол ба БНСУ-ын зохиолчдын хооронд хамтын ажиллагаа хөгжсөөр байгаа бөгөөд тэр хэрээр яруу найргийн орчуулга ч бас шинэ шатанд дэвшинэ хэмээн найдаж байна.

⁶¹ D.Sainbiligt. 「몽골어로 소개된 한국문학 및 번역에 대한 고찰」, 2010.

2006 онд Д.Сайнбилэгт “Чүнгхянг бүсгүйн домог” хэмээх эртний сонгодог уран зохиолыг монгол хэлээр орчуулав. Хятадын сонгодог уран зохиолын нөлөө ихтэй уг зохиолыг монгол хэлээр орчуулах нь орчуулагчийн яс чанарыг шалгасан бэрх ажил байсан нь тодорхой. Монгол сонгодог бичгийн сайхан хэлээр орчуулсан уг бүтээл нь уран зохиолын төдийгүй соёл, орон судлалын чиглэлээр мэргэшиж буй оюутан сурагчидад тун сайн гарын авлага болж буй. Мөн 2008 онд Солонгосын ард түмний оюуны бахархал болсон “Утгыг тайлж хялбаршуулсан Хүнмин жонгым” зохиолыг монгол хэлээр орчуулсан. Уг зохиол нь 1962 онд БНСУ-ын Үнэт өвийн 70-рт бүртгэгдсэн бөгөөд 1997 онд ЮНЕСКО-гийн дэлхийн бичиг үсгийн өвд бүртгэгдсэнээр солонгосчууд төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татах болжээ.⁶² Хэн, хэрхэн зохиосон нь тодорхой цөөхөн бичиг үсгийн нэг болох хангыл-солонгос үсгийг зохиох болсон хэрэгцээ шаардлага, зарчим зэргийг тайлбарласан уг номыг монголоор орчуулсан нь Монголын Солонгос судлалын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Ийнхүү өндөр үнэлж болох бас нэг бүтээл бол Ц.Цэрэндоржийн орчуулсан Солонгосын түүхийн тулгуур сурвалжийн нэг болох “Гурван улсын нөхсөн судар” юм. Уг судар нь түүх, археологи, хэл шинжлэл, угсаатны зүй, шашин, философи, газар зүйн судлагааны үнэт хэрэглэгдэхүүн бөгөөд Корйё улсын сүүл үед Ирийёнъ (1206-1289) хэмээх их хуврагийн зохиосон албан бус түүх юм. Түүнийг орчин цагийн солонгос хэлээр хөрвүүлсэн хэдэн арван орчуулга гарснаас гадна япон, англи, герман хэлээр орчуулжээ. Тэдгээрийн дотроос Солонгосын нэрт түүхч, эрдэмтэн И Бйёндон-гийн орчуулга хамгийн сайнд тооцогдох агаад түүнд голлон тулгуурлаж орчуулсан бөгөөд зохиогчийн болон орчуулагчийн тайлбар, нанхиад үсгээс бичсэн эртний солонгос эхийн хамтаар хэвлэн гаргажээ.⁶³ Хэр баргийн орчуулагч бэрхшээдэг эртний сонгодог уран зохиолын орчуулгад хүчээ сорьсон Ц.Цэрэндорж Хө гюнь-ий “Хон гил дон нэрт шаштир”-ыг монгол хэлээр орчуулсан нь монгол уншигчидад Солонгосын уран зохиолын их өвтэй танилцах бас нэгэн боломжийг олгов.

Өмнөд Солонгосын улс төрч, бизнесмэн зэрэг алдартай хүмүүсийн намтрыг орчуулсан бүтээлийн тоо нэлээн хэдэд хүрээд байна. ОУХДС-ийн багш Ж.Баттөр солонгос хэлнээс арав гаруй ном орчуулсны бараг тэн хагасыг намтар зохиол эзлэдэг. Өргөн мэдлэг, шаргуу хөдөлмөр, тэсвэр тэвчээр шаарддаг энэхүү ажилд нэлээд гаршсан тэрбээр орчуулагч хүн бол орон судлаач байх ёстой хэмээн үздэг.⁶⁴

1. Ким Ү жүн, “Хорвоо дэлхий уудам, хийх ажил их байна”, орчуулсан

⁶² БНСУ-ын Үндэсний хэлний хүрээлэн, “Утгыг тайлж хялбаршуулсан Хүнмин жонгым”, орчуулсан Д. Сайнбилэгт, 2008.

⁶³ Ирийёнъ, “Гурван улсын нөхсөн судар”, орчуулсан Ц. Цэрэндорж, Ж. Гантулга, Улаанбаатар 2009.

⁶⁴ <http://old.24tsag.mn/content/32287.shtml> Ж. Баттөр, “Орчуулагч орон судлаач болох нь”

- Б.Лхагваа, 1993
- И Мёнбаг, “Ажлаар амьсгалсан он жилүүд”, орчуулсан Ж.Баттөр, 2009, КОМЕХ.
 - Ким Гү, “Солонгосын баатар Ким Гү-гийн дурдатгал” орчуулсан Ж.Баттөр, Улаанбаатар, 2009.
 - О Вөнчөл, “Пак Жөн хыи” орчуулсан Ж. Баттөр,
 - Бэг Ён жүн, “Би үнэнч шударга хөдөлмөрөөр Америкийг байлдан дагуулсан” орчуулсан Ж.Баттөр, 2010.
 - Пак Гынхе, “Цөхрөл намайг хатуужуулж, найдвар намайг урагшлуулдаг”, орчуулсан Ж.Баттөр, Г.Эрдэнэчимэг, 2013, Nepko.

Монгол уншигчидыг Солонгосын уран зохиолтой танилцахад БНСУ-ын сангуудын дэмжлэг их үүрэг гүйцэтгэсэн гэдгийг онцлон дурдах ёстой. Тухайлбал, 1996 онд байгуулагдсан “Утга зохиолын орчуулгын сан” Солонгосын утга зохиолыг дэлхийд сурталчилан таниулах зорилгоо биелүүлэхийн тулд идэвхитэй ажиллаж ирсэн бөгөөд уг сангийн дэмжлэгээр Монголд 10 бүтээл орчуулагдан хэвлэгдснийг доор танилцуулав.

№	Төрөл	Зохиолын нэр солонгосоор	Орчуулгын нэр	Зохиолч	Орчуулагч	Хэвлэлийн компани
1	Орчин үе/тууж	이문열 중단 편집- 우리들의 일그러진 영웅 외	Манай ангийн Овгор	<u>이문열</u> И Мүн ёл	Даваасамбуу Эрдэнэсүрэн	ADMON
2	Орчин үе/шүлэг	황지우 시선- 나는 너다	БИ БОЛ ЧИ ЮМ	<u>황지우</u> Хван Жи ү	Цэрэнхорлоо	SOYOMBO
3	Орчин үе/тууж	바리데기	Бари гүнж	<u>황석영</u> Хван Сөг йөн	Цэрэнхорлоо	СОЁМБО (Soyombo)
4	Хүүхдийн	나는 할머니와 산다	Би эмээтэйгээ амьдардаг	Чхой Минъ гйөн	Даваасамбуу Эрдэнэсүрэн	Nom Hur
5	Орчин үе/тууж	나의 집을 떠나며	Гэрээ орхисон минь	<u>현길연</u> Хйөнъ Гир өнъ	И Анна, Г. Баярмаа	Bolor Sudar Publishing house
6	Орчин үе/тууж,	한국 현대	СОЛОНГО СЫН	<u>황석영</u>	Цэрэнхорлоо	МӨНХИЙН

№	Төрөл	Зохиолын нэр солонгосоор	Орчуулгын нэр	Зохиолч	Орчуулагч	Хэвлэлийн компани
	өгүүллэг	중단편선	ШИЛДЭГ ЗОХИОЛЫ Н ДЭЭЖИС	Хван Сөг йөн		ҮСЭГ
7	Орчин үе /шүлэг	종이	ЦААС	<u>신달자</u> Шинь Дал жа	Цэрэнхорлоо	SOYOMBO
8	Сонгодог	춘향전- 열녀춘향수 절가-	Чүнхян бүсгүйн домог	Зохиогч тодорхойгүй	Д. Сайнбилэгт	МӨНХИЙН ҮСЭГ
9	Орчин үе/тууж	엄마를 부탁해	Эжийгээ даатгая	<u>신경숙</u> Шинь Гйөн сүг	Сүрэн Банзрагч	Selenge Press
10	Орчин үе/тууж	난장이가 쏘아올린 작은 공	Одой хуний х00Pг0сн БяцхАН Б0мБ0л0г	<u>조세희</u> Чо Сэ хьи	Нандинцэцэг, Чөн Ён хван	SOYOMBO
11	Орчин үе/шүлэг	우연에 기댈 때도 있었다	-	<u>황동규</u> Хван Дон гюү	Түмэн жаргал	Soyombo
12	Хүүхдийн	마당을 나온 암탉		<u>황선미</u> Хван Сөнъ ми	Сүрэн	
13	Орчин үе/тууж	조드-가난한 성자들	-	김형수 Ким Хйөн сү	Нэргүйн Мэнд, Дүгэржавын Бизьяа	
14	Орчин үе/шүлэг	불꽃 비단벌레		<u>최동호</u>	투명자르갈	

Үүнээс гадна 1993 онд байгуулагдсан “Тхайсанъ соёлын сан”-гийн дэмжлэгээр нэг тууж, нэг түүвэр зохиол орчуулж хэвлүүлсэн ба хоёр бүтээлийг орчуулж байна.

№	Төрөл	Зохиолын нэр солонгосоор	Орчуулгын нэр	Зохиолч	Орчуулагч	Хэвлэлийн компани
1	Дунд үе тууж	하늘꽃	Тэнгэрийн цэцэг	И Инъ хва	Даваасамбуу Эрдэнэсүрэн	Мөнхийн үсэг 2007
2	Орчин үе/тууж	고산자	Ко Сан жа	<u>박범신</u> Паг Бөм шинь	Г. Эрдэнэчимэг	Мөнхийн үсэг 2010
3	Эрт үе/түүвэр зохиол	한국의 담	Солонгос үндэстний үлгэр домог		Даваасамбуу Эрдэнэсүрэн	Admon 2011
4	Орчин үе /өгүүллэгийн түүвэр	자전거도둑	Унадаг дугуйн хулгайч	박완서 Паг Ван сө	А. Нарангэрэл, Кан Сөн хва	SOYOMBO хэвлэгдээгүй
5	Орчин үе/тууж	사람의 향기	Хүний үнэр	송기원 Сон Ги вонь	Даваасамбуу Эрдэнэсүрэн	хэвлэгдээгүй

Монголоор орчуулсан Солонгосын утга зохиолын тоймыг товч танилцуулахад ийм байна. Цаашид монгол-солонгос, солонгос-монгол орчуулгын бүтээлийн бүртгэл, ном зүйг үйлдэж, цахимжуулах шаардлагатай байна. Улсын болон хотын, их сургуулиудын номын сангуудад энэ төрлийн орчуулгын буланг байгуулах, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт болон заавал унших номын жагсаалтад оруулах, хөдөлмөр хөрөнгө зарж орчуулсан бүтээлийг олны хүртээл болгохын тулд янз бүрийн арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай. Олны хүртээл болгохгүй бол эдгээр бүтээлүүд тун богино настай болно гэдэг нь тодорхой. Энэ талаар БНСУ-аас суралцах зүйл их бий.⁶⁵

Орчуулгын чанарын асуудал бараг орхигдоод байгааг дурдахгүй байж болохгүй. 1990-ээд оноос хойш солонгос хэлнээс энэ олон зохиолыг монгол

⁶⁵ D. Sainbiligt. 「몽골어로 소개된 한국문학 및 번역에 대한 고찰」, 2010.

хэлээр орчуулсан атал “Монголын нууц товчоо”-ны солонгос орчуулгыг харьцуулж судласан магистрын зохиолыг эс тооцвол орчуулгын шүүмж ганц ч гараагүй байна. Миний олж үзсэнээр орчуулгын алдаанд шинжилгээ хийсэн ганц ажил байгаа нь ОУУБИС-ийн багш Амартайваны бичсэн “Орчуулгыг даатгая” юм.⁶⁶ Сүүлийн хориод жил солонгос хэлнээс орчуулга хийж, туршлага хуримтлуулсан орчуулагч нар энэ чиглэлээр манлайлан ажиллах шаардлагатай байна.

Уран зохиолын орчуулгын номзүй

(Монгол хэлнээс солонгос руу)

Орчуулагч, бүтээл, зохиогчийн нэр гэсэн дарааллаар бичив.

I. Үргэлжилсэн үг

1. Роман, тууж

1. 김희숙 역, “만두하이”, 나차구 도루지 소설,
2. 데, 난딩체체그 역, “황금꽃”, 에르, 초이놈, Р.Чойном, “Хар цэцэг” тууж, 2008.
3. 유원수 역, “맑은 타미르 강” 1, 2, 차다라발로도이담바, 민음사, 2007; Юү Вөнъ сү, “Тунгалаг Тамир”, Ч.Лодойдамба, Минъымса, 2007.
4. 이안나 역, 아요르잔, 샤먼의 전설, 자음과모음, 2012; И Анна, “Бөөгийн домог”, Г.Аюурзана, Мөнхийн үсэг, 2010.
5. 이안나 역, 아요르잔저, 눈의 전설, 이룸, 2007; И Анна, “Цасны роман”, Г.Аюурзана,
6. 이안나 역, 자르갈새홍, 칭기스칸 영웅기 1, 웅진지식하우스, 2005; И Анна, “Чингис хааны нууц түүх 1”, С.Жаргалсайхан, Л.Удвал, Үнжинь жишиг хаус, 2005.
7. 이안나 역, 자르갈새홍, 칭기스칸 영웅기 2, 웅진지식하우스, 2005; И Анна, “Чингис хааны нууц түүх 2”, С.Жаргалсайхан, Л.Удвал, Үнжинь жишиг хаус, 2005.
8. 이안나 역, 자르갈새홍, 칭기스칸 영웅기 3, 웅진지식하우스, 2005; И Анна, “Чингис хааны нууц түүх 3”, С.Жаргалсайхан, Л.Удвал, Үнжинь жишиг хаус, 2005.

2. Өгүүллэг

1. Квон Сон Хүн, "Ламбагуайн нулимс", Д.Нацагдорж, (스님의 눈물), Атай Сонин, УБ, 2002.

⁶⁶ <http://www.choibalsan.mn/index.php?newsid=607>

2. 난당제제그와 정용환역, 샤르허브의 아지랑이, 더르즈점드 앵호벌트, 모시는사람들, 2006; Д.Нандинцэцэг, Чөн ён хуань, “Шар хөвийн зэрэглээ”, Доржзовдын Энхболд, 2006.

3. Бусад

1. 권성훈 역, “세 산에 얹힌 사연”, 데. 나차그도르지, 2006; Квон Сон Хүн, “Учиртай гурван толгой”, Д.Нацагдорж, УБ, 2006.
2. 김장구 역, 이평래역, “몽골의 역사”, 강톨가, 동북아역사재단, 2009; Ким Жангү, И Пйөнрэ, “Монголын түүх”, Ц.Гантулга, Зүүн Хойт Азийн Түүхийн Сан, 2009.
3. 김혜정 역, “몽골국 초대 대통령 오치르바트 회상록”, 푼살마긴 오치르바트, 오름, 2010; Ким Хе жөн, “Тэнгэрийн цаг”, П.Очирбат, Орым хэвлэл, 1996.
4. 베.돌마, 한정탁 역, “몽골의 역사”, 바아바르, 2008; Б. Баабар, “Монголын түүх”, Дулмаа.Б, Хан Жонтаг. УБ, 2008
5. 베, 돌마, 한정탁 역, “시사 몽골어, 몽골일간지로 보는 오늘의 몽골”, Дулмаа.Б, Хан Жонтаг, “Өнөөгийн Монгол”, УБ, Мөнхийн үсэг, 2009.
6. 테, 어트공톨 역, “시대의 도를 밝히 보여주는 종이새”, 울란바атар, 2015; Тогтохын Отгонтуул, “Цагийн жамыг тодруулагч Цаасан шувуу”, Улаанбаатар, 2015
7. 테, 어트공톨 역, “지혜의 열쇠”, 울란바атар, 2014, Тогтохын Отгонтуул, “Оюунтүлхүүр”, Улаанбаатар, 2014.

4. Ардын аман зохиол

1. 유원수 역, “게세르칸”, 몽골대서사시, 사계절, 2007; Юү Вөнъ сү, “Гэсэр хаан”, Сэгежөл хэвлэлийн газар, 2007.
2. 유원수 역, “장가르 1 - 영웅을 기다리는 유목민의 노래”, 한길사, 2011; Юү Вөнъ сү, “Жангар 1”, Ханъгилса, 2011.
3. 이안나 역, “말을 타고 가는 이야기”, 다쉬던덕, 이가서, 2006; И Анна, “Морьтой үлгэр”, Ж.Дашдондог, Игасө, 2006.
4. 이평래 역, “몽골민간신화”, 체렌소드놈, (대원동서문화총서 23), 대원사, 2001; И Пйөнрэ, “Монгол ардын домог үлгэр”, эмхтгэсэн Д.Цэрэнсодном, Тэвөнъсан, 2001.
5. 이안나 역, “몽골의 설화”, 체렌소드놈, 문학과지성사, 2007; И Анна, “Монгол ардын домог үлгэр”, эмхтгэсэн Д.Цэрэнсодном, Мүнъхаг гуажи сөнса, 2007.
6. 이안나역, 체렌서드님, “몽골 민족의 기원신화”, 울란바타르대학교출판부, 2001; И Анна, “Монгол ардын домог үлгэр”, эмхтгэсэн Д.Цэрэнсодном, Улаанбаатар Дээд Сургуулийн хэвлэл, 2001.

7. 이정희 역, “재미있는 몽골민담”, 백산자료원, 2000; И Жөн хьи, “Монголын ардын үлгэр”, Пэгсань жарё вонь, 2000.

II. Яруу найраг

1. Квон Сөн хүн, “Хэнз хурга”, “Хоёр ишиг”, “Анхны цас”, “Нууц янаг”, Д.Нацагдорж, Яруу найргийн шүүмж 32, Сөүл, 2008, 138-141х.
2. Квон Сөн хүн, “Миний нутаг”, “Миний ижий”, Д.Нацагдорж, Яруу найргийн шүүмж 33, Сөүл, 2008, 58-61х.
3. Квон Сөн хүн, “Гэр”, “Бадамлянхуа цэцэг”, “Яргуй”, “Монгол бүсгүй”, “Чи бидэн хоёр”, Б.Явуухулан, Яруу найргийн шүүмж 34, Сөүл, 2008, 141-144х.
4. Квон Сөн хүн, “Модуншаньюгийн айлтгал”, “Чоно”, “Аранш”, “Уяа”, “Эх”, Т.Галсан, Яруу найргийн шүүмж 35, Сөүл, 2009,
5. Квон Сөн хүн, “Хүлээлт”, Л.Өлзийтөгс, Яруу найргийн шүүмж 36, Сөүл, 2009, 37-38х.
6. Квон Сөн хүн, “Нүдээ аниад”, Ж.Батцэцэг, “Яруу найргийн шүүмж 36, Сөүл, 2009, 39-40х.
7. Квон Сөн хүн, “Цаг хугацааны бороо”, Б.Энхтуяа, Яруу найргийн шүүмж 36, Сөүл, 2009, 41-42х.
8. Квон Сөн хүн, “Нүүдэл”, Д.Сумьяа, Яруу найргийн шүүмж 36, 2009, Сөүл, 43х.
9. Квон Сөн хүн, “Өө, энэ өдрүүд...”, “Юу ч болоогүй мэт...”, “Цаг алган дээр хайлж...”, Г.Лхагвадулам, Яруу найргийн шүүмж 36, Сөүл, 2009, 44-45х.
10. Квон Сөн хүн, “Хэн нэгэнд үнэн хайртай байна гэдэг...”, “Сэтгэл минь хув хуурай байгаа ч...”, “Тайлж тавьсан даашинзны минь хормой...”, “Эргэж харалгүй яваад өгөхөд чинь...”, “Болзсон тэр минь ирээгүй өдөр”, Л.Өлзийтөгс, Яруу найргийн шүүмж 36, Сөүл, 2009, 96-99х.
11. Квон Сөн хүн, “Тэнгэрт үлдсэн шувууны мөр”, “Ойхон арлын зүүд”, “Хүлээлт”, “Миний өтөл нас”, “Миний л нэрийг дуудсаар...”, Г.Аюурзана, Яруу найргийн шүүмж 38, Сөүл, 2009, 36-40х.
12. Квон Сөн хүн, “Говь”, “Тэмээ”, Б.Явуухулан, Яруу найргийн шүүмж 39, Сөүл, 2010, 41-46х.
13. Квон Сөн хүн, “Морины дууль”, “Гэгээн бодол минь навчистай хамт унасаар...”, “Чи бид хоёрын од харалдаа байдаг...”, “Чи минь дуулж байна...”, “Надаас цаг хугацааг чимээгүйхэн нуух гэж...”, “Баярлалаа, ирж байгаарай...”, “Буцах шувуудын гуниглангуй...”, “Ширээний чидэн асаалттай байна...”, Ж.Болд-Эрдэнэ, Яруу найргийн шүүмж 41, Сөүл, 2010, 73-78х.
14. Квон Сөн хүн, “Ээжидээ би үнэтэй”, “Хүүдээ”, “Чамайг би зурсан”, Г.Мөнхцэцэг, Яруу найргийн шүүмж 43, Сөүл, 2011, 116-120х.

15. Квон Сөн хүн, “Зураглал”, “Ертөнцийн тухай гүн бодол”, “Зөрлөг дээр учирсан...”, “Би төгөлдөр хуур...”, Д.Энхболдбаатар, Яруу найргийн шүүмж 44, Сөүл, 2011, 51-55х.
16. Квон Сөн хүн, “Улаан гэрлийн охин”, “Надад хангалттай будаг бийрийг өг”, “Хоригдол”, “Чамдаа”, Б.Батрэгзэдмаа, Яруу найргийн шүүмж 45, Сөүл, 2011, 86-91х.
17. Квон Сөн хүн, “Асаалт”, “Хана”, Б.Ичинхорлоо, Яруу найргийн шүүмж 46, Сөүл, 2011, 251-255х.
18. Квон Сөн хүн, “Галт тэрэг хөдлөхөд...”, “Орой намрын шүлэг”, “Хичээлдээ бас чамд яарч...”, “Бороо орохоор...”, “Намар”, А.Эрдэнэ-Очир, Яруу найргийн шүүмж 49, Сөүл, 2012, 42-47х.
19. Б.Дулмаа, “Аав минь”, Х.Чилаажав, Азийн утга зохиол сэтгүүл. № 1 Сөүл., 2001.
20. Б.Дулмаа, “Хайрт аав”, “Эмэгтэй”, “Монгол эх орон”, Х.Чилаажав, Азийн уран зохиолын форум. Сөүл., 2005.
21. 이안나 역, 룽상도르찌 을지텍스, 나뭇잎이 나를 잎사귀라 생각할 때까지, 이룸(김현주), 2007; И Анна, “Навч намайг навч гэж бодох хүртэл”, Л.Өлзийтөгс, 2007.
22. 이안나 역, 몽골현대시선집, 문학과지성사, 2003; И Анна, “Орчин үеийн Монголын шилдэг яруу найраг”, Мүнххаггуажисонса, 2003.
23. 이안나 역, 바오긴 락그와수렌, 한 줄도 나는 베끼지 않았다, 사문학의 숲, 2013; И Анна, “Хоёрын тоо”, Б.Лхагвасүрэн, Са мүнххагэ сүп, 2013.

III. Эрдэм шинжилгээ

1. Квон Сөн хүн, “Монгол хэл аялгууны учир”(몽골어와 제 방언), Ш.Лувсанвандан, Монгол Судлал Х, Сөүл, 2000, 251-275х.
2. 『몽골의 무속과 민속』, 고려대 민족문화연구원, 민속학 연구소 편, 월인, 2001. Г.Эрдэнэчимэг, “Монгол бөө”, О.Пүрэв, Корйө Их Сургуулийн Үндэсний соёлын хүрээлэн, Угсаатны зүйн хүрээлэнгийн хэвлэл, 2001;
3. 설펜자빈 돌람, 『몽골 신화의 형상』, 이평래 역, 태학사, 2007; И Пйөнөрэ, “Монгол домог зүйн дүр”, С.Дулам, Нэмэн засварласан хоёрдахь хэвлэл, “Монгол соёлын чуулган” I боть, Улаанбаатар, 2009.
4. 『역주 몽골 황금사』, 김장구 역주, 동북아역사재단, 2014; Ким Жангү, “Хураангуй Алтан товч”, Зүүн Хойт Азийн Түүхийн Сан, 2014
5. 유원수 역, 『몽골비사』, 혜안, 1994; Юү Вөнъсү, “Монголын нууц товчоо”, Хез анъ, 1994.
6. 유원수 역, 『몽골비사』, 사계절, 2004; Юү Вөнъсү, “Монголын нууц товчоо”, Сагежөл, 2004.

7. 이안나역, 『몽골의 가정 예절과 전통』, 남질,민속원, 2007; И Анна, Монгол гэр бүлийн ёс заншил ба уламжлал, Т. Намжил, Миньсогвонь, 2007.
8. 체데브 다그미트마역, 돌고룬 체데브, 『몽골불교사』, 불교통신교육원, 2003
9. 최학근 역주, 『蒙古諸汗源流의 寶綱, 蒙古 源流』, 보경문화사, 1985; Орчуулж, тайлбар зүүлт хийсэн Чой Хаг гынъ, “Саган сэцний Эрдэнийн товч”, Погйөн мүнхха са, 1985.

(Солонгос хэлнээс монгол руу)

I. Үргэлжилсэн үг

1. Роман, тууж

1. Баттөр. Ж, Эрдэнэчимэг.Г, “Энх-Амгалан хаан”, Ж. Спэнс, Непко, 2015; 조너슨 D 스펜스, “강희제”, 이준갑 역자, 2001.
2. Баярмаа.Г, “Гэрээ орхисон минь”, Хёнъ Ги Рёнъ, Болор судар, 2012; 현길언, “나의 집을 떠나며”, 문화과지성사, 2009
3. Нандинцэцэг.Б, “Одой хүний хөөргөсөн бяцхан бөмбөлөг”, Жу Сэ Хи, УБ, 2003; 베, 난당체체그 역, “난장이가 쏘아올린 작은 공”, 조세희, 이성과 힘, 2000.
4. Нармандах.Д, “Бан Ги Мунъ - Солиотой юм шиг хичээллэж, суутан юм шиг мөрөөд”, Шинъ Үн жинъ, Мйөнжинъ хэвлэлийн газар, 2007; 신웅진, 바보처럼 공부하고 천재처럼 꿈꿔라(반기문 유엔사무총장이 세계청소년에게 전하는 꿈과 희망의 메시지), 명진출판사, 2007.
5. Цэрэндорж.Ц, “Хон Гилдон нэрт шастир”, Хө Гйүнъ, УБ, 2008; 허균, “홍길동전”
6. Цэрэнхорлоо.Ч, “Бари гүнж”, Хван Сөг йөнъ, Соёмбо, 2013; 황석연, ‘바리데기’, 창비, 2007.
7. Эрдэнэсүрэн.Д, “Би эмээтэйгээ амьдардаг”, Чвэ Минь Гён, Ном хур, 2012; 최민경, “나는 할머니와 같이 산다”
8. Эрдэнэсүрэн.Д, “Манай ангийн овгор”, Ли Мүн Ёл, Монсудар, Адмон ХХК, 2009; 이문열, “우리들의 일그러진 영웅”, (1987 년도 제 11 회 이상문학상 작품)
9. Эрдэнэсүрэн.Д, “Тэнгэрийн цэцэг”, И Инхва, Мөнхийн үсэг, 2007; 이인화, “하늘꽃”, 동방미디어, 2002
10. Эрдэнэсүрэн.З, “Ээжийгээ даатгая”, Шин Гён Сүг, Сэлэнгэ пресс, 2013; 신경숙,
11. “엄마를 부탁해”, 창비, 2008

12. Эрдэнэчимэг, Г, “Ко Санъ жа”, Паг Бөм шинь, Мөнхийн үсэг хэвлэлийн компани, 2012; 박범신, “고산자”, 문학동네, 2009.

2. Өгүүллэгийн түүвэр

1. Солонгос өгүүллэгийн дээжис, Б.Лхагваа нар, УБ, 1996
 - i. Б.Лхагваа, “Аадар бороо”, Хван Сүнъ вөнъ, бе, 하고, “소나기”, 황순원
 - ii. Б. Норовням, “Тогоруу”, Хван Сүнъ вөнъ, бе, 노로브남, “학”, 황순원
 - iii. Г.Эрдэнэчимэг, “Төмс”, Ким Дон инъ, ге, 에르덴치메그 “감자”, 김동인
 - iv. Э.Баярцэцэг, “Ядуу эхнэр” Хёнъ Жинъ гөнъ, эе, 마야르체체그, “빈처”, 현진건
 - v. С.Мөнхжаргал, “Сагаг цэцэг цэцэглэх цагаар” И Хё сөг, эе, 명흐자르갈, “메밀꽃 필 무렵”, 이효석
2. Солонгосын шилдэг зохиолын дээжис, Ч.Цэрэнхорлоо, Мөнхийн үсэг, 2006
3. Солонгосын шилдэг өгүүллэгийн дээжис, Б.Лхагваа нар, Сөүл хот, Дүсор, 2000
 - i. Б.Лхагваа, “Хэлгүй Сам Рён И”, На До хян, бе, 하과, “병어리 삼룡이”, 나도향
 - ii. С.Номиндарь, “Аз тохиосон өдөр”, Хён Жин Гон, с, 노명다리, “운수 좋은 날”, 현진건
 - iii. Д.Эрдэнэсүрэн, “Далавч”, Ли Санг, де, 에르덴수령, “날개”, 이상
 - iv. Д.Бүрэнжаргал, “Ваар урлагч өвгөн”, Хуанг Сүн Вон, де, 부렌자르갈, “독짓는 늙은이”, 황순원.
 - v. Ч.Цэрэнхорлоо, “Ахмад Ли”, Жон Гуанг Юунг, че, 체령호를로, “꺼비단 리”, 전광용.
 - vi. Д.Тэгшжаргал, “1964 оны өвөл, Ким Сынг уг, ”де, 텍시자르갈, “서울, 1964 년 겨울”, 김승옥,
 - vii. Ариунзул, “Бусдын гэрт”, Чүэ Ин ху, ариунжол, “타인의 방”, 최인호.
 - viii. Б.Отгонтогтох, П.Оюунгэрэл, “Занга”, Жу Сэ Хьи, бе, 어트경터터호, 페, 오음계렐, “내 그물로 오는 가시고기”, 조세희.
 - ix. Б.Энхсаруул, “Холын тэр минь”, Со Ёнг Ын, бе, 앵흐사로울, “먼 그대”, 서영은

- х. Б.Нандинцэцэг, “Саарал цасан хүн”, Чүэ Юн, бе, 난딩체체그,
“회색 눈사람”, 최윤.

3. Намтар

1. Баттөр.Ж, Бороо.З, “Солонгосын баатар Ким Гү-гийн дурдатгал”, Улаанбаатар, 2009; 제, 바트터르 역, “백범일지”, 김구,돌베개, 2005
2. Баттөр.Ж, “Ажлаар амьсгалсан он жилүүд”, И Мёнбаг, Солонгос Монголын харилцааг дэмжих нийгэмлэг (КОМЕКС), ВСІ хэвлэх газар, 2009; 제, 바트터르 역, “신화는 없다”, 이명박, 김영사, 2005
3. Баттөр.Ж, “Пак Жөнх Хый: Солонгосын сэргэн мандалт”, О Вончөл, Непко, С2009; 오원철, “박정희는 어떻게 경제강국 만들었나”, 동서문화사, 2006.
4. Баттөр.Ж, “Би үнэнч шударга хөдөлмөрөөр Америкийг байлдан дагуулсан”, Бэг Ён Жүн, 2010; 제, 바트터르 역, “나는 정직과 성실로 미국을 정복했다”, 백영중, 랜덤하우스, 2007.
5. Баттөр.Ж, Эрдэнэчимэг.Г, “Цөхрөл намайг хатуужуулж, найдвар намайг урагшлуулдаг”, Пак Гынхе, Непко, 2013; 박근혜, 절망은 나를 단련시키고 희망은 나를 움직인다, 위즈덤하우스, 2007

4. Ардын аман зохиол

1. Ариунбайгаль.Б, “Сайхан яриа”, УБ, 2003
2. Сайнбилэгт.Д, “Чүнхянг бүсгүйн домог”, УБ, Мөнхийн үсэг. 2006, “춘향전”
3. Уугантуяа.Д, “Солонгосын домог үлгэр ба хууч яриа”, И Жон-Сүг, УБДС, 2008; 이정숙, “전설과야화”, 한가람서원, 2007.
4. Эрдэнэсүрэн.Д, “Солонгос үндэстний үлгэр домог”, Admon, 2011

5. Бусад

1. Амартайван.М, Энх-Амгалан.Б, “Холын улс ба хөрш улс: Солонгос улс”, И Вонбуг, УБДС, 2009; 이원복, 21 세기 먼나라 이웃나라: 우리나라편, 김영사, 2003.
2. Амартайван.М, Энхзул.С, “Гадаад хүнд зориулсан Солонгосын соёлын унших бичиг”, Квөн Йён минь бусад, 2010; 엠, 아마르타이왕 역, “외국인을 위한 한국문화 읽기”, 권영민외, 아름다운한국어학교, 2009.
3. Амартайван.М, “Солонгос, солонгос хүн, солонгосын эдийн засаг”, И Вонбуг, Сун Бённаг, УБДС, 2004; 이원복, “만화로 보는 한국 한국인 한국경제”, 동아출판사, 1993

4. Амартайван.М, “Хэлмэрчлэх орчуулах үндэс”, Чвэ Жонхва, УБДС, 2004; 최정화, 통번역 입문, 1998
5. Ариунаа.Д, “Дээврийн өрөөн дэх миний мөрөөдөл”, И Жи Сонг, Хаан принтинг ХХК, 2010; 이지성, “꿈꾸는 다락방”, 국일미디어, 2007
6. Баттөр.Ж, “Таны хүүхэд гоц ухаантай”, Жөн Мириам,
7. Баттөр.Ж, Баярмаа.Г, Эрдэнэчимэг.Г, “Хөгжингүй орон болохын нууц”, Юү Жүн гынъ, УБ, 2007;
8. Баттуяа, Ким Сон Мүг, Тэр эрэгтэйн хүсдэг эмэгтэй, тэр эмэгтэйн хүсдэг эрэгтэй, УБИС, 2013.
9. Баярмаа.Э, “Анзаарч чадвал амьдрал сайхан”, Хэ Мин, 2013; 헤민스님, “멈추면 비로소 보이는 것들”, 쌤앤파커스, 2012
10. Ганчимэг.Б, “Америкийн агуу ерөнхийлөгч А Линкольн”, Жон Гуан, 전광, “책벌레 링컨이 대통령이 되었어요”, 생명의 말씀사, 2005
11. Ким Жон Рэ, “Мянганы гайхамшигт хүн”, 김종래, “밀레니엄 맨”
12. Ким Ү Жүн, Хорвоо дэлхий уудам, хийх ажил их байна, Б.Лхагваа, Д.Жамьяандорж, УБ, 1992; 김우중, “세계는 넓고 할일은 많다”, 김영사, 1989
13. Ким Юн Ги, Амьдралд хөтлөх үнэний зам, намтар хураангуй. УБ, 2008 он.
14. Мөнхчимэг.Б, “Намайг хөтлөн дагуулагч чи хэн бэ?” Паг Уг Сү, Удам Соёл, 2013
15. Нарангэрэл.А, Мягмарсүрэн, Өлзийжаргал.Ч, “Эмэгтэй хүний амьдрал гэрлэлтээр төгс болдог”, Нам Ин Сүк, Сэлэнгэ пресс, 2012; 남인숙, “여자의 인생은 결혼으로 완성된다”, 시작, 2009
16. Нармандах.Д, “Цагаан ордныг залбирлын өргөө болгосон ерөнхийлөгч Линкольн”, Жон Гуан, 데, 나르만다흐역, “책벌레 링컨이 대통령이 되었어요”, 전광, 생명의 말씀사, 2005
17. Өлзийжаргал.Ч, “Өөдрөг үзлийн үр”, Ким Хён Тэ, Сэлэнгэ пресс, 2012; 김현태, “긍정의 씨앗”, 주니어랜덤, 2009
18. Оюунжаргал.О, “Бүсгүй та эргэлзэлгүй яв”, Нам Ин Сүг, 2009; 남인숙, “여자 거침없이 떠나라”, 낸덤하우스, 2008
19. Оюунжаргал.О, “Эмэгтэй хүний амьдрал 20 наснаас эхэлдэг” (1-р дэвтэр), Нам Ин Сүг, 2010; 남인숙, 여자의모든인생은 20 대에결정된다, 랜덤하우스코리아, 2009
20. Оюунжаргал.О, “Эмэгтэй хүний амьдрал 20 наснаас эхэлдэг” (2-р дэвтэр), Нам Ин Сүг, 2010
21. Оюунчимэг.О, “Бурхан байхгүй гэж хэлэхээсээ өмнө”, Жан Ду Ман; 장두만,
22. “하나님이 없다고 말하기 전에”, 요단출판사, 2000
23. Урангоо.Б, “Сэжун хааны сэтгэл зүйн менежмент”, Пэг Ги Буг, Мөнхийн үсэг, 2012; 백기복, “대왕 세종”, 크레듀, 2007

24. Урангоо.Б, “20 насандаа бүү бууж өг”, И Жи Сон, Амар-Өргөө ХХК, 2013
이지성, “스무 살 절대 지지 않기를”, 리더스북, 2011.
25. Урангоо.Б, “20-30 настнуудыг амжилтанд хүргэх 30 өдрийн төлөвлөгөө”,
И Жи Сон, Амар-Өргөө ХХК, 2013; 이지성, “20 대를 변화시키는 30 일
플랜”, 맑은소리, 2006.
26. Цэрэнхорлоо нар, “Шуурганаар сийлэгдсэн түүх”, Ким Жон Рэ, 김종래,
“유목민이야기”, 자우출판사, 2002
27. Чо Ён Рэй, Амьд бамбар: Чун Тай Ил-ийн намтар; 전순옥, “한 줄기 불꽃:
전태일 평전”, 2003
28. Шин Инчол, Шидэт түрийвч, Б.Энх-Амгалан, 2011; 신인철, 마법의 지갑,
한스미디어, 2008
29. Эрдэнэчимэг.Г, БНСУ-ын Гадаад эдийн засгийн бодлогын хүрээлэн, “Төв
Ази. Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин, БНСУ-ын аж ахуйн
байгууллагууд Монголын зах зээлд өргөнөөр нэвтрэх нь”, VCI хэвлэлийн
газар, 2014. 게, 에르덴치메그, 대외경제정책연구원, “몽골의 투자환경과
한국기업의 진출확대방안”, VCI, 2014.
30. “Хүн өөрийгөө 1% л өөрчлөхөд амьдрал боломжоор дүүрэн”

II. Яруу найраг

1. Квон Сөн хүн, Орчин цагийн солонгосын шүлэг I, (한국 현대시 1) УБ,
2005, 120х.
2. Квон Сөн хүн, Солонгосын эртний яруу найргаас(I), -“Шар
бялзуухай”(황조가), “Маддуны дуу”(서동요), “Дүүгээ дурсахуй”
(제망매가), “Ардыг гэгээрүүлэх дуу”(훈민가), Солонгос судлал 2, УБ,
2005.
3. Квон Сөн хүн, Солонгосын эртний яруу найргаас(II), -“Хайртыгаа
санагалзах дуу”(사미인곡), Солонгос судлал 4, УБ, 2006.
4. Квон Сөн хүн, Орчин цагийн солонгосын шүлэг II (한국 현대시 2), УБ,
2007, 173х.
5. Сайнбилэгт.Д, Баттөр.Ж, Сон Ыи минъ, “Солонгосоос ирсэн нэгэн
шувуу”, Гү Жүн -хуй, 1997
6. Цэрэнхорлоо.Ч, “Би бол чи юм”, Хуан Жи Ү, Адмон, 2007; 황지우,
“나는 너다”, 풀빛, 1987
7. Цэрэнхорлоо.Ч, “Цаас”, Шинъ Дал жа, Соёмбо.

III. Эрдэм шинжилгээ

1. Монгол Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиум, БНСУ-
ын Үндэсний музей, МУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, МҮТМ,

- Сөүл -УБ, 2003 (солонгос-монгол, монгол-солонгос орчуулга) Ц.Цэрэндорж
2. Монголын Улаанбаатар Солонгосын үндэсний зурагтай уулзлаа, Сөүл - УБ, 2009 (солонгос-монгол, монгол-солонгос орчуулга) Ц.Цэрэндорж
 3. Сайнбилэгт.Д, “Утгыг тайлж хялбаршуулсан Хүнмин Жонгым” (Иргэнийг сургах зөв аялгуу), Үндэсний Хэлний Хүрээлэн, 2008; 국립국어원, “훈민정음”, 생각의나무, 2008
 5. Талын эзэнт гүрэн Хүннү, *Монгол-Солонгосын хамтарсан судалгааны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын материал*, МУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, МҮМ, БНСУ -ын Үндэсний музей, УБ, 2008
 6. Цэрэндорж.Ц, Гантулга.Ж, “Турван улсын нөхсөн судар”, Ирйёнъ, УБ, 2011; 일연, “삼국유사”, 홍신문화사, 1993.
 7. Цэрэндорж.Ц, “Дуурлиг нарсны хүннү булш” (Тусгай үзэсгэлэнгийн каталог), Сөүл-УБ, 2009 (солонгос-монгол хамтын орчуулга)
 8. Цэрэндорж.Ц, Худгийн толгойн хүннү булш, БНСУ -ын Үндэсний музей, МУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, МҮТМ, Сөүл, 2003 Чулуунд сийлсэн нүүдэлчдийн амьдралын хэв маяг, оюуны соёлын сэтгэлгээ, БНСУ-ын Кёнжү-гийн Үндэсний соёлын өвийн хүрээлэн, Чигжи сүм музей, МУ -ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Сөүл, 2008,
 9. Цэрэндорж.Ц, Чү Чэхйөг, Юань улс хятад угсаатныг ноёлон захирч байсан нь (Юань гүрний түшмэлийн давхаргын нийгмийн гарлын талаарх шинжилгээ) (өгүүлэл) – *Acta Historica*, МУБИС-ийн ТНУС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №9, УБ, 2008, 122-136-р тал.
 10. Цэрэндорж.Ц, Чү Чэхйөг, Монгол, солонгосчууд “Халх овог – Нумтан угсаатан”-аас салбарласан талаарх шинжилгээ (өгүүлэл) - *Acta Mongolica*, МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №9 (320), УБ, 2009, 125-146-р тал.
 11. Эрдэнэчимэг.Г, “Турван улсын түүхэн тэмдэглэл”, ‘Когүрийогийн их вангуудын намтар’, 13 -р дэвтэр, Солонгос судлал сэтгүүл 3, МУИС, ГХСС, 2006, 94-107 нүүр; G. Erdenechimeg, 『삼국사기』, ‘고구려 본기’권 제 13,
 12. Эрдэнэчимэг.Г, “Турван улсын түүхэн тэмдэглэл”, ‘Когүрийогийн их вангуудын намтар’, 14-р дэвтэр, МУИС, ГХСС, 2006, Солонгос судлал сэтгүүл 4, 77-84 нүүр; 『삼국사기』, ‘고구려 본기’권 제 14,
 13. Эрдэнэчимэг.Г, “Юань ба Их Монгол улс”, Ким Хо Дон, ОУХС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2011.

Summary

Mongolia starts to prepare national trained staffs with Korean language skills, as this country established diplomatic relationship with Korean People's Republic in 1990. Since then, Mongolian readers more and more gets familiarize with masterpieces of South Korean literary authors.

Korean literature that translated into Mongolian can be classified into two main stages, before and after 1990. The main reason of 1990's as a boundary is that Mongolia has started its own national qualified staffs with Korean language skills exactly in this period. Nowadays, there are many translated Korean works for Mongolian readers since the diplomatic relationship has established between two nations, and as various Korean literature translation foundations gave a lot of support in this practice. Especially, it is noteworthy that three pieces of Korean old classic literary works has been translated into Mongolian classic literary language skillfully. Meanwhile, in consequence of nonstandard or substandard translations, it needs veteran translators' leadership which accumulated almost 20 years knowledge.

ФРАНЦ ХЭЛЭЭР ОРЧУУЛСАН МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙД⁶⁷

Г. Буяннэмэх⁶⁸

Товч утга: Франц хэлээр орчуулсан Монгол түмний уран зохиолыг эртний, орчин үеийн аман ба бичгийн зохиол хэмээн ангилж эхний ээлжинд нэгэн тойм гаргахаар зорив.

Түлхүүр үг: монгол уранзохиолын франц орчуулга, ангилал, төрөл зүйл, эх сурвалж, судлагаа.

Монгол туургатны утга зохиолын баялаг өв сангаас халх, баруун монгол, ордос, халимаг угсаатны уран зохиолын франц орчуулгыг боломжийн хирээр эрэн сурвалжилсанаа энэ удаа бүртгэн оруулсан авч бид эс олж үзсэн, дурдалгүй орхисон зүйл байхыг үгүйсгэх юун.

Бидэнд буй хэрэглэгдэхүүнээс үзэхэд ХХ зууны эхэн үеэс франц хэлтэн монголч эрдэмтэд⁶⁹ монгол уран зохиолыг цуглуулах, эмхэтгэх, судлах, франц хэлээр орчуулах үйлсийн гарааг эхлэн⁷⁰ өртөөлсөөр иржээ.

Монголч эрдэмтэн Франсуаз Обен *Орчин үеийн хоёр шүлэг /Deux poèmes d'aujourd'hui* гэдэг өгүүлэлдээ Д.Нацагдоржийн *Миний нутаг / Ma patrie* шүлгийн сүүлийн 4 бадаг, Ц.Дамдинсүрэн гуайн *Үүл / Nuage* шүлгийн эхний 4 бадгийг францаар орчуулан [16:140], *Монголын эртний уранзохиол / L'ancienne littérature mongole* гэсэн өгүүлэлдээ *Заан огомтоно хоёр / L'éléphant et la souris, Шидэт өвгөн / Le vieux magicien* гэсэн хоёр үлгэрийг орчуулан хавсаргаж 1965 онд хэвлүүлжээ.⁷¹

Угсаатны зүйч, хүмүүн судлаач Профессор Роберт Амайон *Шаалайн бүүвэй*⁷² гэсэн 5 мөрт 3 бадаг бүүвэйн дуу, бадаг бүрт холбогдох домог, үлгэр, халх ардын 3 мөр бүхий 6 бадаг *Эхийн ерөөл /Vœu-bénédictio maternelle*, баяд ардын

⁶⁷ МУИС, ГХСС, Орчуулгазүй, 2014, №02-т гарсан өгүүлэлд сүүлийн үед гарсан орчуулагыг нэмэн оруулж засварласан болно.

⁶⁸ МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн ахмад багш, проф., доктор

⁶⁹ Бельгийн монголч эрдэмтэн, санваартан А. Мостаэрт 1905-1925 онд Ордост байхдаа Ордос түмний аман зохиолын баялаг хэрэглэгдэхүүнийг цуглуулан эмхэтгэж, 1937 онд Бээжин хотноо **Textes oraux ordos** нэртэйгээр хэвлүүлжээ.

⁷⁰ Францын нангиадч, монголч эрдэмтэн Поль Пеллио Монголын нууц товчооны I-VI бүлгийг францаар орчуулан 1949 онд Парист хэвлүүлжээ.

⁷¹ **Шинэ ардчилал** хэмээх сар тутмын сэтгүүлийн 1965 оны X сарын **La seconde épopée mongole** нэртэй тусгай дугаар, 129- 137, 140 дүгээр тал. Сайхь дугаар нэгэнт ховордсон, эс олдох болсон учир Доктор, Профессор Цэвэлийн Шагдарсүрэнгийн найрсаг зөвшөөрлөөр хувийнх нь хөмрөгөөс авч ашиглалаа.

⁷² Р. Амайон, **Монгол ардын бүүвэйн дуу**, Монголын судлал, I дэвтэр, 1970, 91-127 дугаар тал.

3 мөрт 3 бадаг *Эхийн дуу /Chant maternel*, буриад ардын 4 мөрт 4 бадаг *Өлгийн дуу/ Chant de berceau*, 37 зүйл ертөнцийн гуравыг ⁷³ франц хэлнээ тус тус орчуулсан ажээ. Мөн Бэгзийн Явуухулан гуайн *Бугын жим / La sente du serf* шүлгийг С.Адийхүүтэй хамтран францаар орчуулсан байна. [7:210-213]

Монгол судлаач Намчаа Бассаноф Халимаг ардын *Хавирган, Давсан, Сүрлэн хүү гурав, Үнэг, Хүний биеийн мөч эрхтэн, Богширго* гэсэн дөрвөн үлгэрийг орчуулжээ. [6:81-89]

1961 онд гарсан *Монголын хошин үлгэр яриа* номоос *Гэнэдсэн бадарч /Le badarči pris au piège, Бадарчин/ Le badarči, Сэтэртэй бадарчин / Le badarči consacré, Сахалтай бадарчин /Le badarči barbu* гэдгийг судлаач Сара Дарс (Sara Dars) францчилжээ. (6:78-80).

Дээрх монголч эрдэмтэн, судлаач нарын орчуулгын бүтээл тэр бүр манайд олдох нь ховор болсон тул энд тоймлон дурдсан болно.

Монгол уран зохиолын франц орчуулгыг: ардын аман зохиол, эртний, орчин үеийн уран зохиолын орчуулга хэмээн ангилав.

I. Монгол ардын аман зохиолын орчуулга

Профессор Алэн Дежак⁷⁴, Цэгмидийн Сүхбаатар нар орчуулан 1991 онд Парист хэвлүүлсэн 35 үлгэр бүхий *Монгол ардын үлгэрийн түүвэр /Contes et récits de Mongolie*, 2010 онд Улаанбаатарт хэвлүүлсэн *Монгол ардын ерөөл билгийн үгээс / Des délicats formules de souhaits populaires mongols*, Патрик Фишман, Г.Мэнд-Ооёо нарын 2012 онд хэвлүүлсэн 30 үлгэр, домог бүхий *Монгол цэцэн билигт ардын үлгэр / Contes des sages de Mongolie*⁷⁵, А.Мостаэрт гуайн *Ордос аман зохиолын цоморлиг /Textes oraux ordos*⁷⁶ зэрэг бүтээлийг эх хэрэглэгдэхүүнээр, өмнө дурдсан хийгээд цаашид дурдах бүтээлүүдийг нэмэлт хэрэглэгдэхүүнээр ашиглан халх, баяд, буриад, халимаг болон ордос түмний аман зохиолын орчуулгыг нэгтгэн, А.Мостаэрт гуайн ангилалд үндэслэн аман зохиолын төрөл зүйлээр ангилан гаргалаа. Үүнд:

- Үлгэр, домог, хошин яриа / Contes, Légendes, Anecdotes – 145
- Дуу / Chansons– 172

⁷³ Roberte Hamayon, *Triades de l'univers, Etudes mongoles, Cahier 3, 1972, pp. 225-238.*

⁷⁴ Хөгжим судлаач Лиллийн Их сургуулийн профессор Алэн Дежак монгол багш, орчуулагч нартай хамтран Монгол ардын аман зохиол хийгээд монголын эрт, эдүгээгийн уранзохиолын олон бүтээлийг франц хэлнээ орчуулсан, Монгол судлалд өөрийн байр суурьтай эрдэмтэн юм.

⁷⁵ Эдгээр 30 үлгэрээс Монголд үлгэр домог үүссэн нь / *Origine des contes et légende de Mongolie, Шаалуу хүүгийн домог / L'histoire du garçon Shalou, Долоон хожгор, нэг можгор / Sept chauve et un Trapi, Хүн гэрэлтэй байсан тухай / La légende de la lumière humaine, Тогоруу ба хүүхэд / L'enfant des grues* гэсэн таван үлгэрийг МУИС-ийн багш С. Булгантамир орчуулжээ.

⁷⁶ Antoine Mostaert, *Folklore ordos (Traduction des Textes oraux ordos), - Monumenta Serica, Monograph XI, Peip'ing, 1967 [605 pp.].*

- Онъсого, таавар/ Enigmes, Problèmes – 200
- Хүүхдийн наадгай/ Jeux d'enfants – 31
- Адис, ерөөл, даллага, шившлэг, маань тарни / Formules de bénédictions, formulas de dalalgha, formulas conjuration, formulas de serment impécatore; Oraisons jaculatoire – 94
- Элэглэл, тохуурхал, хараал үг / Railleries, Malédiction, Injures – 5
- Сургаал, зүйр, цэцэн үг болон төрөл бүрийн үг хэллэг /Sentences, Dictions, Proverbes, manière de parler diverses – 562 гэсэн

тоон үзүүлэлт тус тус гарч байгаагаас үзэхэд монгол ардын аман зохиолын төрөл зүйлийг өргөн хүрээгээр хамран франц хэлнээ орчуулсан нь чамгүй их болой.

Энэ тухайд Профессор Ц.Сүхбаатар, Ален Дежак нарын орчуулсан *Монгол ардын ерөөл билгийн үгээс / Des délicats formules de souhaits populaires mongols* хэмээх бүтээлд *адуу манах, услах, хариулах, морь уургалах, бугуйлдах, хурдан морь сойх, хөлслөх* г. м. адуу, морьтой холбоотой 58 мөр, *азарга, буур, бух, хуц, ухна тавих* зэрэг эцэг мал тавих, хөнгөлөх үед хэлэх ерөөл 64 мөр, *хонь хяргах, тэмээ ноослох, сарлагийн саваг авах* зэрэг малын ноос авах, ноос савах, эсгий хийх үед хэлэх 38 мөр үг, *арьс сур элдэх, чөдөр ногт зангидах, юм оёх, тогоо нэрэх г.м.* аливаа үйл хийх, аян жинд явахад хэлэх ерөөл 60 мөр, *бэр гуйх, шинэ хувцас өмсөх, гүүний үрс гаргах, гал тахих, домнох* г.м. зан үйлийн холбогдолтой 128 мөр ерөөл, нийтдээ 63 зүйлийн 348 мөр ерөөл билиг үгийг монгол, францаар харгалдуулан тавьсан байгаа нь нэн сонирхолтой бөгөөд сургалт, судлагааны хэрэглэгдэхүүнээр ашиглах боломжтой юм.

Торгон нутаг клуб Bibliotheca Oiratica XXXVIII цувралдаа Торгууд гүнж Ниржидмаа, *Монголын арван найман дуу шүлэг* нэртэй бүтээлийг 2014 онд Улаанбаатарт хэвлүүлээд байна⁷⁷.

Laure de Cazenove et Odile Weuleresse, *Treize contes de l'Empire Mongol*, 1998 /Лор де Казенов, Одиль Велрес, *Монгол гүрний үеийн 13 үлгэр*/ гэсэн ном livre.fnac.com сайтад байна. Эдгээр үлгэрийг нэгбүрчилэн үзэх боломжгүй байсан учир үлгэр, домгийн орчуулгад энэ удаа оруулан тооцож эс чадав.

2. Монголын эртний уран зохиолын орчуулга

а. Монголын нууц товчоон.

⁷⁷ Уг бүтээлийн хавсралтын 119-173 дугаар талаас харах: *Dix-huit chants et poèmes mongols* recueillis par le princesse Nirgidma de Torhout et transcrits par Mme Humbert-Sauvageot, avec notation musicales, texte mongol, commentaires et traductions, Librairie orientaliste Paul Geuthner, Paris, 1937.

Монголын түүх, уран зохиолын яндашгүй гайхамшигт энэ бүтээлийн франц орчуулга хоёронтоо гарчээ.

Эхнийх нь 1949 онд Парис хотноо хэвлэгдсэн нангиадч, монголч эрдэмтэн Поль Пеллиогийн *Монголын нууц товчоон*-ы эхийн латин сийрүүлэг, I-VI бүлэг буюу 185 дугаар зүйлийн орчуулга юм.

Хоёр дах нь монголч эрдэмтэн Мари-Доминик Эвен, Родика Поп нарын *МНТ*-ы бүрэн орчуулга бөгөөд 1994 онд Парист хэвлэжээ.

Бельгийн монголч эрдэмтэн Антуан Мостаэртийн *Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols*, Cambridge, Massachusetts, 1953 хэмээх номыг *МНТ*-ы судлалаар гарсан хамгийн жинтэй бүтээл гэж эрдэмтэн судлаач нар үздэг билээ.⁷⁸

Мөн Франсуаз Обен гуайн өгүүлэлд цомхон ч нягт санаа оноотой *L'histoire secrète, ou l'épopée de Gengis-khan* гэсэн хэсэг буй. [16:130-132]

МНТ-ы франц орчуулгаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын олон бүтээл гарч эрдэм шинжилгээний эргэлтэнд нэгэнт орсон тул үүгээр хязгаарлав.

Харин сүүлийн үед манайд гарч эхэлсэн энэ чиглэлийн судлагааны зарим бүтээлийг дурдвас Г.Цэвэлсүрэнгийн *МНТ*-ы зүйрлэл, адилтгалыг франц хэлнээ орчуулсан онцлог сэдэвт Ph.докторын диссертаци (2006), Т.Сая-Эрдэнийн *МНТ*-ы хүний нэрийн зүйлийн франц орчуулгад хийсэн ажиглалт, судлагаа сэдэвт магистрын дипломын ажил (2007), Г.Цэвэлсүрэнгийн *МНТ*-ы хэлний зүйрлэлийн уран хэрэгсэлийг франц хэлнээ орчуулсан онцлог (ХИС, 2005), *МНТ*-г франц хэлэнд орчуулсан нь (МУИС, ОУХС 2008), Н.Мөнхийн *МНТ*-ы *čigidei yadir* хэмээх үгийн орчуулгын тухайд (ГХСС, 2010), *Börte-činō, Qo'ai maral* хэмээх хоёр нэрийн франц орчуулгад хийсэн ажиглалт (2011), *МНТ*-ы франц орчуулга дахь зарим нэрийн тухайд (2012), *МНТ*-ы –жин дагавараар төгссөн хүний нэрийн франц орчуулга (2013) зэрэг өгүүлэл гарчээ.

6. Гэсэрийн тууж

Профессор Алэн Дежак, Цэгмидийн Сүхбаатар нарын орчуулгаар *La geste de Ghesar* гэсэн бүтээл 1991 онд хэвлэгдсэн бөгөөд энэ нь 1716 онд Бээжин хотноо хэвлэгдсэн монгол эхийг баримталсан 8 хэсэг бүхий товч орчуулга юм. Товч орчуулга гэсэн тухайд Ц.Дамдинсүрэн гуайн ... *Объем этого эпоса очень велик. Исполнение его сказителями длится иногда в течение недели и даже нескольких недель. Имеются сведения о том, что полная версия тибетской*

⁷⁸ А. Мостаэрт гуайн уг бүтээлийн монгол орчуулгыг Антоон Мостаэрт монгол судлалын төв эрхлэн *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухай* нэртэйгээр 2010 онд Улаанбаатар хотноо хэвлүүлэв. Эл орчуулгын VII- XVI талаас Ё.Жанчив агсаны бичсэн Ерөнхий редакторын үгийг үзнэ үү.

Гэсэриады состоит 16 томов. ... Буриатская версия Гэсэриады, записанная в начале XX в., включает 20 или 30 тысяч стихов... гэдгийг үзнэ үү (16:5-6).

Гэсэрийн тууж-ийн энэ франц орчуулгаар хийсэн судлагаа хараахан гараагүй бололтой.

в. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шашдир

Профессор Ц.Сүхбаатар Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос 1982 онд хэвлэсэн *Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив* бүтээлээс монгол эхийг бэлтгэн орчуулж хоёронтаа хэвлүүлжээ.

1995 онд хэвлэгдсэн *La logomachie d'un orphelin vis-à-vis de neuf grands officiers de Genggis khan* хэмээх эхний орчуулгыг хийхдээ франц хэлтэн Мутомба Мүкэнгатай хамтран ажиллажээ.

Хоёр дах нь *Dispute entre un orphelin et neuf grands officiers de Tchinggis khan* гэсэн гарчигтай гарсан бөгөөд Хорлоогийн Оюун, Мутомбо Мүкэнгэ нартай хамтран ажилласан байна. [2:28-390]

г. Чингисийн хоёр эр загалын тууж

н. А.Мостаэрт уг туужийн нэгэн хувилбарыг *Чингис хааны хоёр загал* нэрээр тэмдэглэн авч Ордос аман зохиолын бичвэрийн⁷⁹ 66-д оруулсан байна. [17:162-167]

д. Алтан сургаал

Ишданзанванжилтаны *Алтан сургаал* /*Le précepte d'or* бүтээлээс 50 мөрийг Бямбын Ринчен гуай утгачилан орчуулжээ. [16:51]

е. Оюун түлхүүр

Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив бүтээлээс монгол эхийг бэлтгэн Профессор Ц.Сүхбаатар, Алэн Дежак нар орчуулжээ.

Монгол, франц хоёр эрдэмтэн оюун бодлоо ширээн хийсэн 440 мөр энэ орчуулгыг зэрэгцүүлэн үзвээс нэн тустай гэж бодогдном.

... Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн, *La nuit pensez à ce que vous avez fait la veille.*

Ичгүүр гэмт явдлыг ялгаж орхигтун. *Renoncez à toute affaire honteuse,*

Олны дотор үгээ бэхэл. *En société gardez votre langue.*

⁷⁹ Ордос аман зохиолын бичвэрийн франц орчуулга 1967 онд Бээжинд гарсан байна. *Folklore Ordos (Traduction des textes oraux ordos), -Monumenta Serica, Monograph XI, Peip'ing, 1967 [605 pp]* хэмээх франц орчуулга тэр бүр олдоогүйгээс эхтэй нь тулган үзэж эс чадав.

Ганцаар суухдаа сэтгэлээ шинжил ... *Lorsque vous êtes seul analysez vos sentiments ...*

гэсэн 4 мөрийн орчуулгаас л харахад монгол эхийн утгыг франц хэлнээ сайтар оноон буулгасан нь харагдана.

3. Орчин үеийн уран зохиолын орчуулга

Орчин үеийн монгол уран зохиолын франц орчуулгыг эрэн сурвалжилж цуглуулсан хэрэглэгдэхүүнээ шүлэг, яруу найраг, өгүүллэг, тууж, роман гэж ангиллаа.

а. *Шүлэг, яруу найраг*

Ази-Африкийн зохиолчдын байнгын хороо эрхлэн англи, франц, араб хэлээр гаргадаг улирал тутмын *Lotus* сэтгүүлд монгол зохиолчдын бүтээлийг 1960-аад оны сүүлээс орчуулан хэвлэх болжээ. [13:18]

Монголын зохиолчдын Хороо Д.Нацагдоржийн *Од* шүлэг, *Ламбугайн нулимс* өгүүллэгийн орос, англи, франц, герман орчуулгыг нэгтгэн 1976 онд хэвлүүлжээ. [23:14, 47-52].

Д.Нацагдоржийн *Дөрвөн цаг: Хавар, зун, намар, өвөл; Од*, Б.Явуухулангийн *Би хаана төрөө вэ, Алаг дэлхийд төрсөн минь учиртай, Эх нутгийн уянга, Мөнгөн хазаарын чимээ, Сохор зоосны дууль* гэхчилэн 37 шүлэг, яруу найргийн монгол эх, С.Адийхүү агсаны франц орчуулгыг харгалдуулан *Монголын яруу найргийн дээжис / Recueil des poèmes mongols* гэсэн номыг 2011 онд эмхэтгэн гаргасан нь орчин үеийн монгол яруу найргийн франц орчуулгаар гарсан тоймтой нэгэн бүтээл болжээ. [19]

Б.Явуухулангийн *Бугын жим* шүлгийн С.Адийхүүгийн, С.Адийхүү, Роберт Амайон нарын гэсэн хоёр орчуулга байна. [19:118-123, 7:210-213].

Д.Нацагдоржийн *Миний нутаг* шүлгээс хэсэгчилсэн 2 орчуулга байна. Эхнийх нь өмнө бидний дурдсан Франсуаз Обений, хоёр дах нь англи хэлнээс дам орчуулсан Э.Дюпа (E. Dupas)-гийн Хэрлэн, Онон, Туулын ... гэдгээс эхэлсэн 3 бадгийн орчуулга гарчээ.⁸⁰

Эдгээр шүлэг, яруу найргийн 90 гаруй хувийг С.Адийхүү гуай орчуулан, монголч эрдэмтэн Роберт Амайон хянан тохиолдуулжээ.

Сүүлийн үед Г.Хишиг-Эрдэнэ, Жером Бушар нарын орчуулгаар Ш.Гүрбазарын *Говийн ганц айл / Une famille du Gobi*, Г.Мэнд-Ооёогийн *Чулууны*

⁸⁰ *rue-de-la-poésie.blogspot.com*

аялгуу / *La mélodie des pierres*, Х.Тэргэлийн *Залуу явахад юм бүхэн өнгөлөг / Tout brille quand on est jeune* гэсэн гурван шүлэг хэвлэгдээд байна.⁸¹

б. Өгүүллэг

Бидний суран сурвалжилсанаар Монгол зохиолчдын 20-иод өгүүллэгийг эдүгээ францаар орчуулсан байна. Үүнд:

Д.Нацагдоржийн *Ламбугайн нулимс / La larme d'un vénérable lama*, *Цагаан сар ба хар нулимс / Le Nouvel an et les larmes amères* гэсэн хоёр өгүүллэгийг С.Адийхүү, *Хуучин хүү / Le fils du vieux monde*⁸², Харанхуй хад / *Pierre noire*⁸³, Д.Цэвэгмидийн *Хос тогоруу / Un couple de grues*, Ч.Лодойдамбын *Гэрээслэл / Un témoignage en héritage* [14:3, 27], Л.Бадарчийн *Хүжийн гал / Le feu de l'ensens* [15:31], Т.Галсангийн *La marmotte ou le raisonnement*, Д.Цэнджавын *Банхар / Bankhar le chien*, Морь / *Un cheval*, Чонос / *Les loups*, Мазаалай / *Mazaalai, l'ours de Gobi*, Хулангийн цавчаал / *Khulan, l'hémione sauvage*; Ц.Доржготовын *Цагаан морь / Le cheval blanc*, *Гичий чонын гиншээ / Le gémissement de la louve*; Ч.Лодойдамбын *Шаргачин / La gazelle femelle*; Ц. Дамдинсүрэнгийн *Хоёр цагаан юм / Deux choses blanches*; С.Дашдооровын *Үрт амьтан / Le serpent et ses petits*; Д. Маамын Тэмээ / *Le chateau*; Д.Намдагийн *Хөгшин чонын ульсан нь / Le hurlement du vieux loup* [12] г.м. өгүүллэгийг францаар орчуулан хэвлүүлсэн байна.

Сүүлийн үед монголоос францчилсан орчуулгын талаархи судалгаа ховор байгаа авч Б.Алтангүлийн *Д.Нацагдоржийн “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэгийн франц орчуулгад хийсэн ажиглалт* [25:5], Г.Буяннэмэх, *Монголоос франц хэлнээ орчуулах асуудлаас*⁸⁴ гэсэн ганц нэг өгүүлэл хэвлэгдээд буй. Цаашид энэ чиглэлийн орчуулга, судлагааны ажил өргөжин гүнзгийрнэ гэдэгт бүрэн итгэнэм.

в. Тууж

Л.Түдэвийн *Хорвоотой танилцсан түүх* туужийн хэсэгчилсэн хийгээд бүрэн орчуулга *Le monde qui m'entoure* [15:15-30]; *Comment j'ai découvert le monde* [17:5-141] нэртэйгээр гурвантаа хэвлэгдээд байна.

г. Роман

⁸¹ JENTAYU, revue littéraire d'Asie, no.1, hiver 2014-2015.

⁸² ГХСС-ийн Орчуулгазүйн Профессорын хамтлагаас 2012-2013 оны хичээлийн жилд тус сургуулийн 13 хэлний оюутны дунд Д.Нацагдоржийн *Хуучин хүү* өгүүллэгийн орчуулгаар уралдаан зарласан дүгнэсэн. Франц орчуулгаар тэргүүн байр авсан II ангийн оюутан Ц.Бадамхандын орчуулгыг МУИС, ГХСС, Орчуулга зүй, 2013, № 01, 27-28 талаас үзнэ үү.

⁸³ Э.Дюпа (E. Dupas), *Англиас дам орчуулсан Харанхуй хад* өгүүллэгийг <http://poésie-et-racbouini.over-blog.com> –оос үзэх.

⁸⁴ МУИС, *Гадаад хэл соёл судлал*, 2010, №333 (10)

Романы бүрэн шууд орчуулга хараахан гараагүй байна. Харин ... 1970-аад оны үеэс ... эхлэн Б.Ринченгийн Үүрийн туяа романыг хэсэгчлэн ... С.Адийхүү францаар орчуулж хэвлүүлсэн байдаг. [25:5] гэсэн мэдээлэл байгаа ч бид уг орчуулгыг олж үзэж чадсангүй.

Мөн Ц.Оюунгэрэлийн *Ногоон нүдэн лам* романыг франц хэлээр орчуулан хэвлэх гэрээг Францын Грассе ба Фаскэл (Grasset et Fasquelle) компани хийсэн мэдээ гарсан ч уг бүтээл гарсан эсэхийг мэдэх боломж олдсонгүй⁸⁵.

Зохиолч Чинагийн Галсангийн монгол ахуй амьдралын сэдэвт германаар бичсэн тууж, романыг франц хэлээр орчуулан 1998 оноос хойш хэвлэсэн байна.⁸⁶

Доминик Пети (Dominique Petit)- гийн орчуулгаар:

1. *Vingt jours et un /Zwanzig und ein Tag*, Editions Métailié, 1998.
2. *Ciel bleu / Der blaue Himmel*, Editions Métailié, 1999, 160 pages.
3. *Le monde gris/ Die graue Erde*, Editions Métailié, 2004, 237 pages.
4. *Sous la Montagne blanche / Der weisse Berg*, Editions Métailié, 2004, 288 pages.
5. *La fin du chant / L'Esprit des Péninsules*, 2005, 182 pages.

Изабел Либерийн (Isabelle Liber) орчуулгаар:

6. *L'Enfant élu /Das Geraubte Kind*, Editions Métailié, 2008.
7. *Chaman/ Die Rückkehr*, Editions Métailié, 2012;

Доминик Вотьегийн (Dominique Vauthier) орчуулгаар:

8. *Belek, une chasse dans le Haut-Altai*, L'Esprit des Péninsules, 2003, 120 pages.
9. *La Caravane / Die karawane*, Edition Esprit des Péninsules, 2006.

Ойрын ирээдүйд монгол түмний уранзохиолын франц орчуулга, судалгааны бүтээл олон гарна гэдэгт итгэн энэ удаа Торгууд гүнж Ниржидмаагийн *Монголын арван найман дуу шүлэг* бүтээлд орсон дуу, шүлгийг хавсралтаар орууллаа.

ДҮГНЭЛТ

1. Монгол түмний утга, уран зохиолыг францаар орчуулах, судлах үйлсийн гарааг франц хэлтэн монголч эрдэмтэд тавьсан бөгөөд 1960-аад оны дунд үеэс монгол орчуулагч дагнах, эс бөгөөс францын монголч эрдэмтэн, судлаач нартай хамтран орчуулга хийсээр байна.

⁸⁵ Өдрийн сонин, т. 6, 2015.12.19. Бямба, №305 (5257).

⁸⁶ *Wikipedia. org. Galsan Cinag.*

2. Монгол уран зохиолыг халх, ордос, халимаг, буриад, баяд, торгууд хэл аялгуунаас ихэнхидээ шууд францчилсан, хаа нэг дам, тухайлбал англи хэлээр дамжуулан орчуулсан байна.
3. Ардын аман зохиол хийгээд орчин үеийн уран зохиолын франц орчуулгын зэрэгцүүлсэн судалгаа ховор байна.
4. Бид энэ удаа Антуан Мостаэрт гуайн ордос аман зохиолын баялаг орчуулгаас гадна монгол туургатны 76 үлгэр домгийн, ардын билиг ерөөлийн 63 зүйл 350 мөрийн, ертөнцийн гурвын 37, халх, баяд, буриад, торгууд ардын бүүвэйн болон ардын дуу 36, эртний уранзохиолын 6, орчин үеийн уран зохиолоос бүрэн хийгээд бүрэн бус орчуулгатай шүлэг, яруу найргийн 42, тууж 2, роман 2, өгүүллэгийн 20 франц орчуулгыг бүртгэн авав.

Résumé

Nous essayons d'établir un bref répertoire des œuvres littéraires mongols traduits en langue française, mais notre documentation est parfois déficiente, nous ne voulions citer que les titres de certains œuvres parus dans l'Internet, en les classifiant : la littérature orale populaire, la littérature ancienne et contemporaine.

Hormis la traduction de riches œuvres orales ordos par M. Antoine Mostaert, la traduction de 76 contes et récits, plus de 60 formules de souhaits, de 37 triades de l'univers, des berceuses et des chansons épiques ou populaires de l'éthnie bayad, bouriate, khalkha et torhuut mongol, de 6 sources de la littérature ancienne et celle d'une quarantaine de poèmes, d'une vingtaine de nouvelles contemporaines étaient recueillis et classifiés.

Ашигласан ном зүй

1. Antoine Mostaert, *Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols*, Cambridge, Massachusetts, 1953.
2. *Branche de la sagesse*, traduite par Soukhbaatar Ts., UB., 2010.
3. *Contes des sages de Mongolie*, par Patrick Fischmann et G. Mend-Ooyo, Seuil, 2012.
4. *Contes et récits de Mongolie*, par Alain Desjacques et Tsegmidin Soukhbaatar, © Nathan, Paris, 1991.
5. *Dix-huit chants et poèmes mongoles* recueillis par la princesse Nirgidma de Torhout et transcrits par Mme Humbert-Sauvageot, avec notations musicales, texte mongol, commentaires et traductions, Librairie orientaliste Paul Geuthner, Paris, 1937, pp.119-144.

6. *Études mongoles*, Cahier 1, 1970.
7. *Études mongoles*, Cahier 2, 1971.
8. *Études mongoles*, Cahier 3, 1972.
9. *La geste de Ghesar*, traduit par A. Desjacques et Ts. Soukhbaatar, , Casterman, 1991.
10. Œuvres posthumes de Paul Pelliot, *Histoire secrète des Mongols , Restitution du texte mongol et traduction française des chapitres I à VI*, Paris, Librairie d'Amérique et d'Orient, Adrien-Maisonneuve, 11, rue Saint-Sulpice, 1949.
11. *Histoire secrète des Mongols* traduit du mongol, présenté et annoté par Marie -Dominique Even et Rodica Pop, Gallimard, Paris, 1994.
12. *Le hurlement du loup et autres nouvelles mongoles*, traduits par Munkhzul R., Oulan-Bator, 2016.
13. *Lotus*, index 1968, 1969, 1970.
14. *Nouvelles des écrivains mongols*, traduites par Ga. Bouyannemekh , rédaction et correction par Alain Desjacques, Udam soyol, Oulan-Bator, 2010.
15. *Nouvelles des écrivains mongols*, traduites par B. Altangul, rédaction et correction par Alain Desjacques, Udam soyol, Oulan-Bator, 2014.
16. *La seconde épopée mongole*, numéro spécial, octobre 1965.
17. Tudev L., *Comment j'ai découvert le monde*, traduit et adapté par Rinchin Munkhzul, © Borealia, 2015.
18. Дамдинсүрэн Ц., *Исторические корни Гэсэриады*, Из-во АН СССР, Москва, 1957.
19. Монголын яруу найргийн дээжис (Д. Нацагдорж, Б. Явуухулан), орчуулсан С. Адийхүү, хянан тохиолдуулж эмхэтгэсэн Б. Алтангүл, франц хэлний орчуулгыг хянасан Роберт Амайон, Букар Амандин, УБ., 2011.
20. Мостаэрт А., *Монголын нууц товчооны зарим хэсгийн тухай*, УБ., 2010.
21. Мостаэрт А., *Ордос аман зохиолын цоморлиг*, УБ., 2010.
22. Мэнд-Ооёо, *Хөхүүдэй, морин хуурын домог*, Мөнхийн үсэг, УБ., 2012.
23. Нацагдорж Д., *Од, Ламбугайн нулимс*, франц орчуулсан С. Адийхүү, УБ., 19 ?? .
24. *Франц судлал* , № 01, УБ., 2009.
25. *Хэлишинжлэл, Боловсрол судлал, Орчуулгын онол, хэрэглээ, ЭШХ-ын эмхэтгэл*, УБ., 2013, 5- тал.

Тод номын гэрэл төв эрхлэн хэвлүүлсэн

Bibliotheca Oiratica

XXXVIII

Торгууд гүнж Ниржидмаа

Монголын арван найман дуу шүлэг

УБ., 2014, х. 119-141 дах

Dix-huit chants et poèmes mongols

recueillis par

la princesse Nirgidma de Torhout

et transcrits par

Mme Humbert-Sauvageot

Avec notations musicales, texte mongol, commentaires et traductions,

Librairie Orientaliste Paul Geuthner, 12 rue Vavin, Paris VI^e, 1937.

гэсэн хэсгээс арван найман дууны нэрийг түүвэрлэн гаргалаа.

1. Аянчны дуу	Pour le voyageur
2. Санан уйтгарлахуй	Nostalgie
3. Тоорой банди	Touri Bendi
4. Сэндэрьяа	Sindirya
5. Түүнийг минь харав уу?	Avez-vous vu ?
6. Гавилмаа	Gavelma
7. Дурсамж	Souvenir
8. Өндөр уулын оргил	La montagne le plus haute
9. Улиастай	L'Ouliastaï
10. Саравчлан харвал	La main aux yeux
11. Хээрийн галууны гашуудал	Complainte des oies sauvages

12. Хундаганы дуу	Chanson à boire
13. Шаштир	Shastar
14. Галдмаа	Galdanma
15. Дамбижалсан	Dambi Jaltsan le Brave
16. Базарсадын хувилгаан	Basraçadi incarné
17. Дүүрэн бэлэг	During Belec
18. Жангарын домог	La légende de Jehangar

ХЯТАД-МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТҮҮХЭН ХАНДЛАГА

Ш. Эгшиг⁸⁷

Товч утга: *Төр улсаа байгуулсан Хүннү нар хөрш Хань улстай орчуулагч хэлмэрчээр дамжуулан харьцаж байснаас эхлэлтэй хятад хэлнээс орчуулах үйл явц өнөөг хүртэл түүхэн онцлогтой хөгжжээ. Хятан улс, Их Монгол улс ба Манжийн үеийн монгол дуун хөрвүүлэгч нар хятадаас орчуулах орчуулгын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан нь дан гагц уран зохиолын төдийгүй бусад шинжлэлийн ном зохиолын орчуулгад ч хамааралтай юм. Хятадаас орчуулагч дуун хөрвүүлэгч нар чухам хэн байсан, тэдний орчуулга бусад хэлнээс орчуулж байсан уламжлалаас ямар онцлогтой байсан, шинэ болон орчин үеийн орчуулгын зохиол бүтээлийн байдлыг тодруулж, тухай тухайн үеийн орчуулгын хандлагыг тогтоохыг зорьж бичив.*

Түлхүүр үг: *орчуулгазүй, орчуулгын түүх, “дөрвөн бичиг, таван ном”, хятадын сонгодог зохиол, орчуулагч, дуун хөрвүүлэгч, “Ачлалт ном”, үлгэрч, бэнсний үлгэр*

Орчуулгын судалгааны бүтээлүүдийг ерөнхийд нь авч үзвэл, төвд болон орос хэлнээс орчуулсан ном зохиолтой жишихэд, хятадаас орчуулсан бүтээлтэй холбогдох судалгаа харьцангуй бага бөгөөд тогтолцоотой бус, хэсэг бусад байдалтай байгааг тэмдэглэх хэрэгтэй буй заа. Тэдгээр судалгаанд гол төлөв уран зохиолын орчуулгын талаархи судалгаа зонхилж байна.

Хятад хэлнээс монголчилсон зохиол бүтээлд одоо баттай мэдэгдэж буй хамгийн эртний бичгийн баримт гэвэл Сяньбийн үед хамаарч байна. “Сүй шү” хэмээх түүхийн номзүйн хэсэг (32-р бөлөг)-т Сяньби нарын үед гарсан сяньби хэлнээ холбогдох 12 номын жагсаалт буй⁸⁸ бөгөөд үүнд улсын (үндэсний) хэлний сурах бичиг, толь бичиг болон намтар зохиол, дуу шүлгийн зүйл олон байгаа нь лавтайяа тэр үед хэлний шинжлэл багагүй хөгжиж ирсний нотолгоо юм.

Сяньби нарын түүхийг гүнзгий судалсан доктор Г.Сүхбаатар энэ үед “... Ачлалт ном-ыг орчуулан ерөнхийдөө унших бичиг болгон хэрэглэж байжээ. Ачлалт ном (“Тахимдуу бичиг” ч гэж орчуулдаг)-ын эл орчуулга бол монгол хэлний анхны орчуулга гэж үзэж болох байх...” гэж тэмдэглэжээ⁸⁹. Энэ мэдээг

⁸⁷ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

⁸⁸ Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by L. Ligeti, Budapest, 1970, p. 279 (265-308).

⁸⁹ Г. Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал.

францын монголч Франсуаз Обен баталдаг⁹⁰. Харамсалтай нь уг орчуулга бидний үед хүрэлцэн ирсэнгүй.

Ч.Нарантуяа нарын монгол бичгээс кирилл үсэгт буулгасан “Кунз” хэмээх бэсрэг номын оршил тайлбарт “471-499 онд Кэси-линг “Ачлалт ном”-ыг тоба хэл дээр орчуулжээ. Манай тооллын 480 онд Монгол Сяньби аймгийн мэргэн гүүш нар “Ачлалт ном”-ыг нангиадаас монгол хэлэнд орчуулан ард олонд түгээн тархааж байжээ.” хэмээжээ. Энэхүү мэдээг Өвөр Монгол дахь эх сурвалжаас авч бичсэн бололтой бөгөөд хэрэвзээ баримтаар нотлогдвол мөнөөхөн судалгаанд их нэмэртэй болох юм.

Хятадаас орчуулсан орчуулгад холбогдох илүү бодитой баримт гэвэл, Хятаны үед холбогддог. Хятаны түүхийг бичсэн Б.Багана, Х.Пэрлээ нар тэр цагт “...Хятаны ба Хятадын судар бичгийн хүрээлэн хоёр байжээ. Хятан хүрээлэнд хятан судар бичиг зохиох орчуулгын хэрэг эрхлүүлжээ. Хятад хүрээлэнд Хятаны харъяат Хятадын бичиг, судар зохиох ажил хийж, хятад эрдэмтэн сэхээтэн нараас улсын мөчих шалгаан авч эрдмийн зэрэг олгох ажлыг эрхлүүлжээ...” хэмээн тэмдэглэсэн хэсэг буй⁹¹.

“Ляо улсын эх адагийн хэрэг” хэмээх түүхийн мэдээгээр Хятаны томоохон язгууртан нар гэртээ номын сантай байсан бөгөөд тэнд нь хятадын дөрвөн бичиг буюу “Их суртахуй” (大学), “Ер дунд бичиг” (中庸), “Шүүмжлэл өгүүлэл бичиг” (论语), “Менз бичиг”(孟子) таван ном буюу “Зурхайт ном” (易经), “Шүлэглэлт ном” (诗经), “Засагт ном” (尚书), “Ёслолт ном” (礼记), “Шажинт ном”, “Хавар намар” (春秋) болон энэтхэг, солонгосын утга зохиолын ном байдаг байсан хийгээд заримынх нь номын тоо түм хүрч байсан хэмээжээ⁹². Тан улсын их шүлэгч Бай Жү И (白居易) болон бусад найрагчдын бүтээлээс орчуулж байсан мэдээ “Хятан гүрний ойллого” (契丹国志) түүхийн сударт тэмдэглээстэй байдгийг Я.Ганбаатар номдоо дурджээ⁹³. Үүнээс гадна, өөрснөө цаг тооны бичиг зохиож байсны хажуугаар хятадаас “Түн-ли” (通历) хэмээх Цаг улирлын нэвтэрхий бичиг болон цааз хуулийн зүйлийг орчуулж байсан баримт байна⁹⁴.

Хятан улс тухайн цагтаа бичиг соёлоо хөгжүүлж, таван нийслэл хот хийгээд муж бүртээ сургууль байгуулан, аян замын болон түүхэн тэмдэглэл зохиох, ном зохиол орчуулах, хэвлэх талаараа Ази дахинаа их л нөлөөтэй явж

⁹⁰ Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209.

⁹¹ Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 120-р тал (130 хуудас); Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 72-р тал.

⁹² Ляо улсын эх адагийн хэрэг, гар бичмэл, 1-р дэвтэр, 45-46, 68, 85-р тал; 2-р дэвтэр, 21-р тал; 3-р дэвтэр, 40-р тал.

⁹³ Я.Ганбаатар *Нангиадын сонгодог яруу найраг*, Таван хэлний орчуулгыг зэрэгцүүлэхүй, Улаанбаатар, 2006 он, 26-р тал.

⁹⁴ Б. Багана, *Хятан нарын асуудал*, гар бичмэл, 122-123-р тал (130 хуудас);

ирсэн бөгөөд 995 онд Солонгосоос хятан хэл, бичиг сурахаар хүмүүс тусгайлан ирж байсан мэдээ буй⁹⁵ нь үүний нэгэн нотолгоо болно.

Их Монгол улсын үед хятадаас ном судрын зүйл орчуулах ажил үлэмжхэн хөгжиж,⁹⁶ тэдгээр орчуулга нь ч уг эхээрээ бидний үед хүрэлцэн ирж, хятадаас монголчилсон зохиол бүтээлийн бодит судлагдахуун болдог билээ.

Өгөдэй хааны 6-р он буюу 1234 онд “Төрийн хөвгүүдийн сургууль” (国子监) Улсын хөвгүүдийн сургууль гэж хэлэх нь ч бий.) байгуулах зарлигийг хаантан буулгаснаар анхлан хааны угсааны агь ба том түшмэдийн хөвгүүдийг сургах сургууль үүсчээ. Энэ сургуульд монгол хятад бичиг үсэг эзэмшсэн тухайн үеийн хамгийн нэрт эрдэмтдээр хичээл заалгаж байжээ. Энэ сургуулийг Хятадын дараагийн түүхэн улсууд уламжлан авч, Монголчуудын тогтоосон сургуулийн тогтолцоогоор цаашид явуулсаар ирсэн бөгөөд энэхүү сургуулийн барилга одоо ч гэсэн Бээжин хотноо хадгалагдан үлдэж, тухайн цагийн түүхийг өгүүлэн оршсоор байгаа юм. 1236 онд “Бичиг зохион найруулах хүрээлэн, судар бичгийн хүрээлэнг байгуулж, судар түүх цуглуулж найруулах ажил хийлгэж эхэлсэн тухай БНХАУ-ын монголч Ж.Ринчиндорж дурджээ.⁹⁷ Энэхүү байгууллагуудад судалгаа, сургалтын ажилд шаардагдах орчуулгын ажил ихэд өрнөсөн юм. Жишээ нь, төрийн хөвгүүдэд уншуулахаар хятадын “Дөрвөн бичиг, таван ном” болон энэтхэгийн “Панчатантра”-г тусгайлан орчуулуулж байжээ. Л.Хүрэлбаатар багштаны “Монгол орчуулгын товчоон”-д ч мөн энэ талаар дурдахдаа, Хубилай хаан Жао-би гэгч эрдэмтнээр 4 номыг орчуулгажээ. 1288 оноос Төрийн хөвгүүдийн сургууль ба орон нутгийн монгол сургуульд “Их суртахуй бичиг” (大学)-ийг монголоор орчуулж, дөрвөлжин үсгээр товхисон эхээр зааж эхэлсэн байна. Үүнээс хойш он цагийн дарааллаар 1282 онд Сыма Гуан (司马光)-ы “Төрд туслах нэвтэрхий толь” (自治通鉴)-ыг 1311 оноос Тан улсын “Чжен гуань чжен яо” (贞观政要)-ыг 1317 оноос Алинтөмөр удирдан, “Их суртахуй ачлалт ном”-ыг Аллактөмөр тус тус орчуулж эхэлжээ. Тэд мөн 1326 онд “Эзэн богдын их сургаал”-ыг орчуулан хэвлэжээ. Монгол эрдэмтэн Цагаан тухайн үедээ их эрдэм төгс, ном зохиохоос гадна орчуулгын ажил хийж байв. Тэрээр Тан улсын Тайцзун хааны зохиосон “Чжен гуаний төрийн товч” (贞观政要) “Хаан эзний дүрэм”, “Шударга ном”-ыг орчуулах ажлыг хийж байв.⁹⁸

Академич Д.Цэрэнсодном: 1240 онд “*Да Сыюу Ян-ий*” (үүнийг Цэрэнсодном авгайн өөрийн бичсэнээр оруулав.) гэдэг номыг хятадаас орчуулсан гэх мэдээ буйг дурдаж, бас 1264 онд хятадын сонгомол зохиол

⁹⁵ Х. Пэрлээ, *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*, Улаанбаатар, 1959, 69-74-р тал.

⁹⁶ Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160-р тал;

⁹⁷ Ж.Ринчиндорж, *Дундад улс дахь Монгол судлалын тойм*, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 1992, No.1,2 (9,10), Special issue: World Mongol Studies, Ulaanbaatar, 164-165 pp.

⁹⁸ Л.Хүрэлбаатар, *ХШ-ХIY зууны үеийн орчуулгын зохиол*, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995, 4-6-р тал.

орчуулах, түүх зохиох хороо байгуулсныг тус тус тэмдэглэснээс гадна 1307 онд “Ачлалт ном”-ыг Булутөмөр орчуулсныг тэмдэглэжээ⁹⁹.

Юань улсын үеийг судалсан манай нэрт түүхч, академич Ч.Далай: Сүн (北宋) улсын түүхч Сыма Гуан (司马光 1019-1086)-ы “Төрд туслах нэвтэрхий толь”- (“资治通鉴”)-ийг 1269-1271 оны хооронд, христосын тооллын өмнөх 200-аад оны үед зохиогдсон Күнзийн суртлын “Ачлалт ном” - (“孝经”)-ыг Болдтөмөр гэдэг монгол эрдэмтэн 1307 онд, “Их суртахуй бичиг” - (“大学”) -ийг 1288 оноос өмнө тус тус орчуулж монгол болон дөрвөлжин бичгээр гаргаж байсан тухай дурджээ¹⁰⁰. Энд өгүүлсэн “Ачлалт ном”-ын орчуулагчийн нэрийг академич Ч.Далай гуай Болдтөмөр гэсэн бол дээр өгүүлсэн академич Д.Цэрэнсодном гуай Булутөмөр орчуулсан гэжээ. Тэгэхээр орчуулсан цаг хугацааны хувьд нэгэн он байгаа тул энэ нь нэг хүн бололтой, гагцхүү энэхүү хүний нэрийг эш татсан эх сурвалжаас буулгахдаа өөр өөрөөр тайлж буулгасан бололтой байна. Хятадаас монголчилсон зохиол бүтээлүүдийн дотроос энэхүү зохиолын орчуулга, орчуулсан цаг хугацаа болон удаа дараа хэдэн удаа орчуулсан, түүнээс лавтайяа таван орчуулга нь бидний үед хүрэлцэн ирсэн, бидэнд хүрэлцэн ирсэн хувилбар орчуулгуудаас хамгийн эртнийх болох XIV зууны орчуулга нь дундад үеийн монгол хэлний тухайн цагийн хэлзүйн онцлог байдлыг тусгасан зэргээрээ монгол орчуулгын түүхнээ онцгой байрыг эзэлдэг. Тийм ч болохоор дээр дурдсан монгол орчуулгуудаас “Ачлалт ном”-ын “анхны” гэгдэх орчуулгыг эрдэмтэн Х.Лувсанбалдан, профессор Л.Лигети (L. Ligeti), И. де Рахивильз (I. de Rachewiltz), Ф.В.Кливез (F. W. Cleaves), Хас-Эрдэнэ зэрэг олон эрдэмтэн хэлний онцлог болон орчуулгын түүхийн талаас нь тусгайлан судалжээ¹⁰¹. Гэвч нарийвчлан хөөвөөс, доктор Г.Сүхбаатар, Ф.Обен нарын үзсэнээр “Ачлалт ном”-ыг бүр анх Сяньби нар орчуулсан гэж үзэх үндэслэл гарч байна¹⁰².

⁹⁹ Д. Цэрэнсодном, *Орчуулгын зохиолын өв уламжлалаас*, - Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972, (14 - 23-р тал) 15-р тал.

¹⁰⁰ Чулууны Далай, *Монголын түүх* (1260-1388), гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 160, 194-р тал;

¹⁰¹ Х.Лувсанбалдан, *Ачлалт номын тухай*, *Studia Mongolica*, Tom. III, Fasc. 12, Улаанбаатар, 1961; I. de Rachewiltz, *The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 16, Wiesbaden, 1982, pp. 7-109; F. W. Cleaves, *The First Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 36, Budapest, 1982, pp. 69-88; F. W. Cleaves, *The second Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching*, - *Documenta Barbarorum*, Festschrift für Walter Heissig zum 70. Geburtstag, Wiesbaden, 1983, pp. 272-281; L. Ligeti, *A propos de la traduction mongole préclassique de Hsiao-king*, - *Acta Orientalia Hung.*, Tom. 38, Budapest 1984, pp. 303 - 349; I. de Rachewiltz, *More about the preclassical mongolian version of the Hsiao-ching*, - *Zentralasiatische Studien*, Band 19, Wiesbaden, 1986, pp. 27- 37. Qaserdeni, *Mongol kelen-ü Takimda᠋u bi᠋iq-un uge butuhu yosun*, - *Erdem sinjilegen-u sedkul*, Kukeqota, 1991, N. 2 (33), 21-27.

¹⁰² Г.Сүхбаатар, *Сяньби*, Улаанбаатар, 1971, 119-р тал; Françoise Aubin, *A note about the spread of Chinese Literature amongst the Mongols*, - *Literary Migrations, Traditional Chinese fiction in Asia* (17-20 Centuries), Beijing, 1987, p. 209.

Юань улсын дараагаар тухайлбал: Хятадын Мин улсын үед хятадаас монголчлох үйл ажиллагаа харьцангуй саарсан байдал харагддаг бөгөөд энэ нь цаанаа улс төрийн учир холбогдолтой байж болох ч мөн нөгөө талаас тухайн үеийн Монголын төр нэлээд тогтворгүй, феодалын бутрал зэрэг түүхэн нөхцөл байдлаас болж, тухайн үеийн бичгийн зохиол бүтээл дайн тулааны хөлд устаж үгүй болоод, бидний үед уламжлагдан ирээгүй байж болох тул, тухайн цагт огт орчуулга хийж байгаагүй хэмээж болохгүй мэт. Ж.Ринчиндоржийн бичсэнээр 1369 онд эрдэмтдийг зохион байгуулж, “Юань улсын судар”-ыг бичүүлсэн ба “Монголын нууц товчоон”-ыг Юань улсын сүүл, Мин улсын эхэн үед галиглаад, монгол эрдэмтэн Хуёнгай, Маш Их нар хятадаар орчуулж, үг бүрийн махчилсан орчуулга ба бөлөг бүрийн хойно утгачилсан орчуулгыг хийсэн байна.¹⁰³ Энэ бол уг нь манай сэдэвт хамааралтай бус ч тухайн үед орчуулгын ажил мөн л ихээхэн эрчтэй явж байсныг илтгэнэ. “Юань улсын судар”-ыг Дандаа хэмээх Дэмчигдорж Ардын хувьсгалын эхний жилүүдэд (1917-1923) орчуулсан байдаг билээ.

Харин Манж Чин улсын үед хятадын зохиол бүтээлийг орчуулахад нэгэн өвөрмөц үе эхэлсэн гэж үзэх үндэс буй. Үүнд: шууд хятад эхээс нь монголчлохын хажуугаар манж орчуулгаас нь дам монголчлох ажил багагүй хөгжсөнтэй холбоотой юм. Энэ нь нэгд, манж нар хятад хэлэнд нэвтэрхий сайн байсан учир орчуулга нь харьцангуй сайн байсантай, хоёрт, монгол манж хоёр хэл нь гарал нэгтэй болохоор манжаас монголчлох нь илүү хялбар байснаар тус тус тайлбарлаж болно. Хятадын Баруун Хойдын Үндэстний Их сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн профессор Тан Жисы *“Манжийн ноёрхлын эхэн ба дунд үед монголчуудыг хятадуудтай шууд харилцахгүй байлгах бодлого явуулж байжээ. Тухайлбал, соёлын харилцааны хувьд гэхэд монгол хүн хятад бичиг үсэг сурч болохгүй, монгол орчуулагч зөвхөн манжаас орчуулна, хятадаар орчуулж хэлмэрчлэхгүй гэх мэт хуулийн хатуу заалттай байжээ. Түүхийн сурвалжид тэмдэглэсэнээр, 1639-1644 онд Манжийн Амбагай цэцэн хааны зарлигаар ордны бичгийн түшмэлийн удирдлаган дор Түдэн, Өлзийт, Сэрэн, Соном нарын хүн “Ляо улсын түүх”, “Алтан улсын түүх”, “Юань улсын түүх”-ийг манж орчуулгаас монгол хэлнээ хөрвүүлжээ. Энэ бол Манж Чин улсын үеийн хамгийн эртний монгол хэлэнд орчуулсан орчуулга байх, хожим нь 1724 онд “Шэн юй гуан шюнь” хэмээх хаадын зарлигласан цаазыг өргөн олонд тайлбарласан бичиг, 1755 онд “Дөрвөн бичиг”, 1759 онд “Их суртахуй”, Тэнгэр тэтгэгчийн үед “Шүүмжлэл өгүүлэл бичиг”, 1785 онд “Мэнз бичиг”, 1812 онд “Ачлалт номын тайлбар”, 1832 онд “Сан зы жин” хэмээх гурван үсгийн судар гээд манж хятад монгол гурван үсгийн хадмал зохиолууд гарч байжээ. Харин Манжийн ноёрхлын сүүл үе буюу Манж улс доройтон суларсан үед хятадуудад хатуу чанд баримтлах бодлого суларснаас болон Монгол нутагт хятад иргэд*

¹⁰³ Ж.Ринчиндорж, *Дундад улс дахь Монгол судлалын тойм*, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 1992, No.1,2 (9,10), Special issue: World Mongol Studies, Ulaanbaatar, 165-166 pp.

